



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

# КРИМИНАЛИСТИК

## *Гарын авлага*

**Зөвлөх:**

Б.Бат-Эрдэнэ (Ph.D)

**Боловсруулсан:**

Б.Лхагвасүрэн (LL.M)

Н.Баясгаланбат (LL.M)

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй  
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”  
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар хот  
2013 он

DDC  
363.25  
К-82

## КРИМИНАЛИСТИК ГАРЫН АВЛАГА

**ХӨТӨЛБӨР, ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛСАН:**

**Зөвлөх:**

Б.Бат-Эрдэнэ (Ph.D)

**Боловсруулсан:**

Б.Лхагвасүрэн (LL.M)

Н.Баясгаланбат (LL.M)

Хэвлэлийн хуудас: 16.2

Цаасны хэмжээ: В5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-77-6

© Энэхүү гарын авлага зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.



## ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТАН, БАГШ НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн зохицуулагч*

*БОЛЬХОРЛООГИЙН САРАНТУЯА*

## ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг. 1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх*

*УХНААГИЙН ТУЯА (Ph.D)*

## ЗОХИОГЧИД

### **Бөхчолууны БАТ-ЭРДЭНЭ**

*Хууль зүйн ухааны доктор, профессор,  
цагдаагийн хурандаа*



1984 онд ЗХУ-ын (хуучнаар) ДЯЯ-ны Волгоград хотын мөрдөн байцаагчийн дээд сургуулийг Эрх зүйч-криминалистикийн шинжээч мэргэжлээр төгссөн. 2009 онд ОХУ-ын ДЯЯ-ны Москва хотын их сургуульд “ЭБША-ны оролцогч шинжээч, мэргэжилтний эрх зүйн байдал” сэдвээр хууль зүйн докторын (Ph.D) зэрэг хамгаалсан.

1984-1998 онд ЦЕГ-ын Криминалистикийн шинжилгээний төвд шинжээч, ахлах шинжээч, 1998 оноос Цагдаагийн академид ахлах багш, тэнхимийн эрхлэгч, факультетийн эрхлэгч, Эрдэмтэн нарийн бичгийн дарга, 2011 онд ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн захирал, 2012 оноос ХСИС-ийн Удирдлагын сургуулийн захирлаар ажиллаж байна. “Криминалистик” сурах бичгийг 2003 онд бичсэн, 10 гаруй магистрын ажил удирдсан.

### **Батхишигийн ЛХАГВАСҮРЭН**

*Хууль зүйн магистр, цагдаагийн ахмад*

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Шүүхийн шинжилгээний тэнхимийн ахлах багш*



2005 онд Цагдаагийн академийг Эрх зүйч-криминалистикийн шинжээч мэргэжлээр төгссөн. 2007 онд Цагдаагийн академид “Бичгэнд хийх криминалистикийн оношлол зүй” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

1998-2001 онд СХД-ийн Цагдаагийн хэлтэст эргүүлийн цагдаа, 2005-2007 онд ШШҮТ-ийн Криминалистикийн хэлтэст бичиг судлалын шинжээч, 2007 оноос Цагдаагийн академид багш, Хууль сахиулахын их сургуульд ахлах багшаар ажиллаж байна.

“Гэмт үйлдлийн мөр” (2008 он), “Криминалистикийн шинжилгээ судлал” (2010 он), “Мөр-мөрдөгчийн гарын авлага” (2011 он) ном, сурах бичгийн зохиогч, 20 гаруй илтгэл хэлэлцүүлж, нийтлэл хэвлүүлсэн, 10 гаруй бакалаврын ажил удирдсан.



## **Намхайн БАЯСГАЛАНБАТ**

*Хууль зүйн магистр, цагдаагийн дэд хурандаа  
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Криминалистикийн  
тэнхимийн ахлах багш*



1998 онд Цагдаагийн дээд сургуулийг Эрх зүйч-цагдаагийн ажилтан мэргэжлээр төгссөн. 2002 онд Цагдаагийн академид хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан.

1998-2002 УБ төмөр зам дахь Цагдаагийн хэлтэст эрүүгийн төлөөлөгч, 2002-2007 онд СХД-ийн Цагдаагийн хэлтэст ахлах мөрдөн байцаагч, 2008 оноос Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургуульд ахлах багшаар ажиллаж байна.

## ӨМНӨТГӨЛ

“Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд “Криминалистик” хичээлийн гарын авлагыг хууль зүйн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудад зориулан гаргаж байна.

Эрх зүйн шинэчлэл эрчимжиж байгаа өнөө үед гэмт хэргийг хийсвэр, аман нотлох баримтаар бус харин гэмт үйлдлийн мөр ашиглан “мөрдөж нотлох” нь эрх зүйт нийгмийг цогцлоох нэг үндэс болох юм.

Монгол Улсын хууль зүйн салбарт ажиллах ирээдүйн хуульч та гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрхийг хамгаалах ариун үйлсдээ шинжлэх ухааны үндэстэй арга зүй ашиглах ёстой. Тэрхүү арга зүйг Таньд криминалистик олгох болно. Криминалистик хичээл нь эрх зүйч мэргэжлээр суралцаж буй оюутны заавал судлавал зохих мэргэшүүлэх хичээл юм.

Энэхүү гарын авлагыг эрх зүйн бакалаврын хамгийн энгийн түвшинд боловсруулсан бөгөөд оюутан та цаашид гүнзгийрүүлэн судлах өргөн боломж байгааг зохиогч бид зөвлөж байна.

*Хууль зүйн доктор (Ph.D), профессор,  
цагдаагийн хурандаа Б.Бат-Эрдэнэ*



## ГАРЧИГ

НЭГ. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР.....	9
1. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ.....	9
2. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА.....	13
ХОЁР. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА.....	32
I БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ.....	32
СЭДЭВ 1. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ, ТОГТОЛЦОО, ЗОРИЛГО.....	32
СЭДЭВ 2. КРИМИНАЛИСТИКИЙН ОНОШЛОЛ БА АДИЛТГАЛЫН ОНОЛ.....	36
СЭДЭВ 3. КРИМИНАЛИСТИКИЙН ЗАРЧИМ, ХЭЛ.....	40
II БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН ТЕХНИК ЗҮЙ.....	44
СЭДЭВ 1. МӨР СУДЛАЛ.....	44
СЭДЭВ 2. МӨРТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ.....	51
СЭДЭВ 3. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ ЗҮЙ.....	61
СЭДЭВ 4. ХҮНИЙ МӨР СУДЛАЛ.....	69
СЭДЭВ 5. ХҮНИЙ ДҮР, ТӨРХ СУДЛАЛ.....	77
СЭДЭВ 6. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МӨР СУДЛАЛ.....	80
СЭДЭВ 7. БИЧИГ БАРИМТ СУДЛАЛ.....	86
СЭДЭВ 8. ГАЛТ ЗЭВСЭГ СУДЛАЛ.....	91
III БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН ТАКТИК ЗҮЙ.....	95
СЭДЭВ 1. КРИМИНАЛИСТИКИЙН ТАКТИК ЗҮЙН ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР.....	95
СЭДЭВ 2. МӨРДӨХ АЖИЛЛАГАА БА ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АРГА ХЭМЖЭЭ.....	102
СЭДЭВ 3. КРИМИНАЛИСТИКИЙН ТААМАГЛАЛ.....	107
СЭДЭВ 4. МӨРДӨХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	112

СЭДЭВ 5. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ .....	122
СЭДЭВ 6. БАЙЦААН ШИЙТГЭХ ТОДОРХОЙ АЖИЛЛАГААНЫ ТАКТИК.....	128
IV БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН АРГА ЗҮЙ .....	130
СЭДЭВ 1. КРИМИНАЛИСТИКИЙН АРГА ЗҮЙН ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ .....	130
СЭДЭВ 2. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХ АРГА ЗҮЙ.....	136
СЭДЭВ 3. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХ АРГА ЗҮЙ.....	143
ГУРАВ. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ЗААХ АРГА ЗҮЙ .....	151
ДӨРӨВ. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....	160



## НЭГ. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

### 1. Криминалистик хичээлийн тодорхойлолт

#### Хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр:	“Криминалистик”
Индекс:	
Кредит цаг:	2 кр
Нийт цаг:	40
Улирал:	3-р дамжааны хаврын улирал

#### Хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн өнөөгийн нийгэмд гэмт хэргийг байцаалтын аргаар бус харин хэргийн газраас илрүүлсэн ул мөр, эд мөрийн баримт, тэдгээрт хийсэн шинжилгээ, шинжлэх ухааны үндэстэй мөрдөх ажиллагаагаар нотолж, илрүүлэх явдал чухал юм.

Криминалистик нь гэмт хэрэгт холбоотой бүхий л үзэгдлийн зүй тогтлыг судалж, гэмт хэргийг “мөрдөж нотлох” арга зүйг боловсруулдаг шинжлэх ухаан юм.

Иймд “Криминалистик” хичээл нь эрх зүйн дээд боловсрол олгох их, дээд сургуулиудын сонсогч, оюутны хувьд заавал судлах мэргэшүүлэх хичээл бөгөөд энэ хичээлийг судлахгүйгээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх (урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх), шүүх-шинжилгээ хийлгэх, мөрдөх, прокурор, шүүгч нь хэргийг хянан шийдвэрлэх, өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргээ практикт хэрэгжүүлэх боломжгүй юм.

#### Хичээлийн зорилго

Криминалистикийн онол, техник, тактик, арга зүйн үндсэн ойлголтуудыг судлуулж гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үед төрөл бүрийн ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хураан авах, адилтгалын болон оношлолын онолыг үндэс болгож криминалистикийн шинжилгээ хийлгэх, мөр, нотлох баримт ашиглан байцаан шийтгэх ажиллагааны шийдвэр гаргах мэдлэг, чадварыг эзэмшүүлнэ.

#### Хичээлийн зорилт.

- Криминалистикийн онол, техник, тактик, арга зүйн үндсэн ойлголтуудыг судлуулах,

- Ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, хураан авах арга зүй, дээрхи ажиллагааны дараалалтай танилцуулах,
- Криминалистикийн хэдэн төрлийн шинжилгээ байдаг, шинжээчээр тогтоолгож болох асуудлын талаарх ойлголтыг бий болгох,
- Мөр ашиглан шийдвэр гаргах мэдлэг, чадварыг эзэмшүүлэх,
- Байцаан шийтгэх тодорхой ажиллагааг хуулийн дагуу зөв тактикаар явуулах арга барил эзэмшүүлэх,
- Тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөх арга зүйн төсөөлөлтэй болгох,
- Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэхэд криминалистикийн үүрэг, ач холбогдлыг таниулах,
- Хууль хамгаалах байгууллагыг хүндэтгэх сэтгэлгээг төлөвшүүлэхэд оршино.

### **Залгамж холбоо:**

Энэхүү хичээлийг судлахын өмнө Эрх зүйн онол, Логик, Эрүүгийн эрх зүй хичээлүүдийн хөтөлбөрийг бүрэн хангасан байх ба Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Гүйцэтгэх ажил, Криминологи, Прокурорын хяналт, Өмгөөлөх үйл ажиллагаа гэсэн хичээлүүдтэй зэрэгцээ холбоотой байна.



**“Криминалистик” хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт**

д/д	Бүлгийн нэр	Лекцийн сэдэв	Цаг	Семинар, дасгалын сэдэв	Цаг	Бүлэгт ногдох цаг
1	Криминалистикийн онол	Криминалистикийн шинжлэх ухааны ойлголт, судлах зүйл, тогтолцоо, зорилго	2			6
		Криминалистикийн оношлол ба адилтгалын онол	2			
				Криминалистикийн хэл, зарчим	2	
2	Криминалистикийн техник зүй	Мөр судлал, мөр үүсэх зүй тогтол. мөрний ангилал, төрөл	2			16
				Мөртэй ажиллах арга зүй	2	
		Криминалистикийн шинжилгээ зүй	2			
		Хүний мөр судлал	2			
				Хүний дур, төрх судлал	2	
				Тээврийн хэрэгслийн мөр судлал	2	
				Бичиг баримт судлал	2	
		Галт зэвсэг судлал	2			
3	Криминалистикийн тактик зүй	Криминалистикийн тактик зүйн ойлголт, мөн чанар	2			12
				Мөрдөх ажиллагаа ба гүйцэтгэх ажлын арга хэмжээ	2	
		Криминалистикийн таамаглал	2			
		Мөрдөх ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт	2			
				Хэргийн газрын үзлэг	2	
4	Криминалистикийн арга зүй	Криминалистикийн арга зүйн ойлголт, үзэл баримтлал	2			6
		Тодорхой төрлийн гэмт хэрэг мөрдөх арга зүй	2			
				Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг мөрдөх арга зүй	2	
Бүгд			24		16	40

### **Багшид тавигдах шаардлага**

Мэргэжлийн талаар:

Эрх зүйч, криминалистикийн шинжээч мэргэжилтэй, шүүхийн шинжилгээ болон мөрдөн байцаах байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан, боловсролын магистр болон түүнээс дээш зэрэгтэй, Криминалистик хичээлийг заах онол, арга зүйн өндөр мэдлэг, чадвар, дадлага туршлагатай, техник сэтгэлгээтэй байх.

### **Заах арга зүйн талаар:**

Ерөнхий шаардлага.

- Лекц унших, семинари болон сонсогчдын бие даалтын ажлыг удирдах арга зүйг эзэмшсэн, сурган хүмүүжүүлэх ухааны зохих мэдлэг, чадвартай байх,
- Оюутны лекцээр болон дадлага ажлаар олж авсан мэдлэгт суурилан Криминалистикийн мэдлэгийг нь батжуулан, бүтээлчээр хөгжүүлэх чадвартай байх,

### **Тусгай шаардлага.**

- Хууль зүйн сургалт явуулах, заах арга зүйд гарч байгаа орчин үеийн хандлагын өөрчлөлтийг мэдэрч, өөрийн заах арга зүйг боловсронгуй болгох, байнга шинэчлэх чин эрмэлзлэлтэй байх,
- Багш, оюутнуудтай хамтран багаар ажиллах чадвартай байх,
- Мэдээлэл түгээх болон оролцооны идэвхтэй аргуудыг хэрэгжүүлэх зохих мэдлэг дадалтай байх,
- Оюутны болон хичээлийн үнэлгээг чадамгай зохион байгуулж, зөв оновчтой үнэлэж, дүгнэж шийдвэр гаргаж чаддаг байх.

### **Бусад шаардлага:**

- Сургалтын материал, сурах бичиг, тараах материал, үлгэрчилсэн ажилбар, шинжилгээ зэрэг ажиллагаануудыг үр дүнтэйгээр бэлтгэх, тэдгээрийг ашиглах аргыг сургах,
- Оюутанд зориулсан гарын авлагыг товч, тодорхой энгийн хялбаршуулсан аргаар бэлтгэх,
- Орчин үеийн техник, хэрэгслийг ашиглах чадвартай байх (компьютер, проектор, кодоскопи, видео аудио техник хэрэгсэл),
- Хичээлээр олсон мэдлэг, чадварыг үнэлэх зохистой шалгуурыг сонгон авч, оюутан нэг бүрийг бодитойгоор үнэлдэг байх.



## 2. Криминалистик хичээлийн товч агуулга

### 1-р бүлэг. Криминалистикийн онол

**Бүлгийн зорилго:** Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх онолын сургаалиудыг танин мэдэх, улмаар гэмт хэргийг шинжлэх ухааны үндэстэй “мөрдөж нотлох”, хянан шийдвэрлэх мэдлэг, хандлага төлөвшихэд оршино.

#### Эх сурвалж:

1. Бадарчи.С, БНМАУ-д гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистикийн арга, хэрэгслийг хэрэглэж байгаа нь. Докторын диссертаци., ЗХУ., 1982.
2. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
3. Белкин.Р.С., Курс криминалистики., М., 2001.
4. Ганс Гросс., Руководство для судебных следователей как система криминалистики., 1898.
5. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.
6. Майлис.Н.П., Моя профессия-судебный эксперт., Москва., 2006.
7. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1., УБ., 2002.

### 1. Криминалистикийн шинжлэх ухааны ойлголт, судлах зүйл, тогтолцоо, зорилго

#### Сэдвийн зорилго:

Криминалистикийн шинжлэх ухааны ойлголт, ерөнхий ба тусгай онол, судлах зүйл, тогтолцоо, түүх, хууль зүйн шинжлэх ухаан дах байр суурийн талаар ойлголттой болох, тухайн сэдвээр бодох, шүүн тунгаах чадвартай болж, улмаар онолын асуудлуудыг үндэслэлтэйгээр тайлбарлаж сурахад оршино.

#### Нэр томьёо:

- Криминалистик
- Зүй тогтол
- Гэмт хэргийн бүтцийн зүй тогтол
- Мөрдөж нотлох
- Байцааж нотлох
- Эрүү шүүлт
- Нотлох баримт

- Байгалийн шинжлэх ухаан
- Техникийн шинжлэх ухаан
- Нийгмийн шинжлэх ухаан

## **Агуулга:**

1. Криминалистикийн шинжлэх ухааны ойлголт, үүсэл хөгжил.
2. Криминалистикийн шинжлэх ухааны судлах зүйл.
3. Криминалистикийн шинжлэх ухааны тогтолцоо.
4. Криминалистикийн шинжлэх ухааны зорилго.

## **Эх сурвалж:**

1. Алтанхишиг.Ч., Нэгэн жаран., 2004.
2. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
3. Белкин.Р.С., Курс криминалистики., В 3т., 1:Общая теория криминалистики., М.: Юрист., 1997.
4. Белкин. Р.С., Криминалистика., Москва., 1999.
5. Белкин.Р.С., Курс криминалистики., М., 2001.
6. Бүдханд.Ц., Криминалистик., УБ., 2002.
7. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.
8. Зорин.Г.А., Теоретические основы криминалистики., Минск., 2000.
9. Зүмбэрэлхам.Д., Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйн презумпци., УБ., 2005.
10. Крылов.И.П., В мире криминалистики., Л., 1989.
11. Нарангэрэл.С., Англи-Монгол-Орос хууль зүйн толь., УБ., 1994.
12. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1., УБ., 2002.
13. Хүний эрх-олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл: НҮБ., УБ., 1992.
14. Цэвэл.Я., Монгол хэлний товч тайлбар толь.,УБ., 1966.
15. “Эд мөрийн баримт” сэтгүүл., УБ, ХЗҮТ., 2006.



## 2. Криминалистикийн оношлол ба адилтгалын онол

### Сэдвийн зорилго:

Криминалистикийн оношлолын болон адилтгалын онол, тэдгээрийн мөн чанар, шинж тэмдгийн тухай сургаалын талаар мэдэх, гэмт хэрэг мөрдөх, хянан шийдвэрлэх ажиллагаанд оношлол болон адилтгалын онолыг ашиглах чадвартай болоход оршино.

### Нэр томьёо:

- Онош
- Адилтгал
- Шинж тэмдэг
- Адилтгагдаж буй объект
- Адилтгаж буй объект
- Бүлгийн харьяалал
- Лаборатори
- Дахин давтагдашгүй
- Харьцангуй тогтвортой

### Агуулга:

1. Криминалистикийн оношлолын онол, мөн чанар.
2. Криминалистикийн оношлолын төрөл, хэлбэр.
3. Криминалистикийн адилтгалын онол, мөн чанар.
4. Криминалистикийн адилтгалын төрөл, хэлбэр.
5. Шинж тэмдгийн тухай сургаал, ангилал.

### Эх сурвалж:

1. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
2. Белкин.Р.С., Курс криминалистики., М., 2001.
3. Бүдханд.Ц., Криминалистик., УБ., 2002.
4. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.
5. Зорин.Г.А., Теоретические основы криминалистики., Минск., 2000.
6. Крылов.И.П., В мире криминалистики., Л., 1989.
7. Лхагвасүрэн.Б., Криминалистикийн шинжилгээ судлал., УБ., 2010.
8. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1., УБ., 2002.

## 2-р бүлэг. Криминалистикийн техник зүй

### 1. Мөр судлал, мөр үүсэх зүй тогтол, мөрний ангилал, төрөл

#### Сэдвийн зорилго:

Криминалистикийн мөр судлал, мөрний ангилал, төрөл, мөр судлалын шинжилгээгээр тогтоож болох асуудлуудын талаар тодорхой ойлголттой болох, эдгээрийг онолын үндэстэйгээр тайлбарлаж сурахад оршино.

#### Нэр томьёо:

- Мөр
- Мөр-дүрс
- Мөр-эд
- Мөр-бодис
- Макро, микро мөр
- Гүн, өнгөц мөр
- Үзэгдэх, бүдэг, үл үзэгдэх мөр
- Динамик
- Статик

#### Агуулга:

1. Криминалистикийн мөр судлалын ойлголт.
2. Мөрийн ангилал, төрөл.
3. Мөр үүсэх зүй тогтол.
4. Мөр судлалын шинжилгээгээр тогтоох асуудал.

#### Эх сурвалж:

1. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
2. Белкин.Р.С., Курс криминалистики., М., 2001.
3. Бүдханд.Ц., Криминалистик., УБ., 2002.
4. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.
5. Жаргалсайхан.Б., Учралын газрын үзлэг., УБ., 2008.
6. Лхагвасүрэн.Б., Мөр., УБ., 2011.
7. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1., УБ., 2002.



## 2. Криминалистикийн шинжилгээ зүй

### Сэдвийн зорилго:

Криминалистикийн шинжилгээ зүй, шинжилгээний ангилал, төрөл, хэлбэрийн ойлголт, шинжээчийн үйл ажиллагааны талаар тодорхой ойлголт бий болох, байцаан шийтгэх ажиллагааны явцад шинжилгээ хийлгэх мэдлэг, чадвар эзэмшихэд оршино.

### Нэр томьёо:

- Шинжилгээ.
- Шинжилгээний ангилал.
- Шинжилгээний төрөл.
- Шинжилгээний хэлбэр.
- Дагнасан шинжилгээ.
- Хамтарсан шинжилгээ.
- Анхны шинжилгээ.
- Нэмэлт шинжилгээ.
- Дахин шинжилгээ.
- Бүрэлдэхүүнтэй шинжилгээ.

### Агуулга:

1. Шинжилгээ судлалын ойлголт, зарчим.
2. Шинжилгээний ангилал, төрөл, хэлбэр.
3. Шинжээч ба мэргэжилтэн.
4. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд анхаарах асуудал.

### Эх сурвалж:

1. Аверьянова.Т.В, Статкус.В.Ф., Эксперт., Москва., 2003.
2. Амгаланбаяр.Ц., Шүүх-шинжилгээ хийлгэхэд тавих асуултын лавлах., УБ., 1994.
3. Алтанхишиг.Ч., Мөрөн.Д., Шүүх-шинжилгээ., УБ., 2004
4. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
5. Белкин.Р.С., Курс криминалистики., М., 2001.
6. Будханд.Ц., Криминалистик., УБ., 2002.
7. Винберг.А.И., Судебная экспертиология., Волгоград., 1979.
8. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.
9. Лхагвасүрэн.Б., Криминалистикийн шинжилгээ судлал., УБ., 2010.
10. Майлис.Н.П., Моя профессия-судебный эксперт., Москва., 2006.
11. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1., УБ., 2002.

12. Шүүхийн шинжилгээний байгууллага, шинжээчийн гарын авлага., УБ., 2008.
13. “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжилгээ” сэтгүүл., УБ., ХЗҮТ., 2006.

### 3. Хүний мөр судлал

#### Сэдвийн зорилго:

Хүний мөр судлалын ойлголт, хүнээс үүсэх мөрний ангилал, төрөл, хүний мөрийг илрүүлэх, бэхжүүлэх талаар тодорхой ойлголттой болох, хүний мөр ашиглан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шийдвэр гаргах чадвар эзэмшихэд оршино.

#### Нэр томьёо:

- Хүний өөрийн мөр
- Хүний эдлэлийн мөр
- Гарын мөр
- Дельта
- Хөлийн мөр
- Шүдний мөр
- Хөлийн мөр

#### Агуулга:

1. Хүний мөр судлалын ойлголт.
2. Хүний мөрийн ангилал, төрөл.
3. Хөлийн мөр судлал.
4. Гарын мөр судлал.

#### Эх сурвалж:

1. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
2. Довдон.Ш, Энхзол.Д., Криминалистик (Гарын мөр, автоматжуулсан системийн арга зүй)., УБ., 2008.
3. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.
4. Жаргалсайхан.Б., Учралын газрын үзлэг., УБ., 2008.
5. Лхагвасүрэн.Б., Мөр., УБ., 2011.
6. Хурцгэрэл.Ж., Криминалистик-1., УБ., 2002.



## 4. Бичиг баримт судлал

### Сэдвийн зорилго:

Бичиг баримт судлалын ойлголт, гар бичмэл, гарын үсгийн шинжилгээ, бичиг-техник судлалын ойлголт, уг шинжилгээгээр тогтоох нөхцөл байдал, шинжээчид тавих асуултын талаар тодорхой ойлголт бий болох, энэхүү мэдлэгийн салбарыг байцаан шийтгэх ажиллагаанд ашиглах мэдлэг, чадвар эзэмшихэд оршино.

### Нэр томьёо:

- Бичгийн хэл
- Бичгийн хэв
- Монограмм
- Чөлөөт загвар
- Харьцангуй чөлөөт загвар
- Түршилтын загвар
- Үнэт цаас
- Хэвлэлийн технологи
- Хэвлэлийн бар

### Агуулга:

1. Бичиг судлалын ойлголт.
2. Бичиг судлалын шинжилгээгээр тогтоож болох нөхцөл байдал.
3. Бичиг-техник судлалын ойлголт.
4. Бичиг-техник судлалын шинжилгээгээр тогтоож болох нөхцөл байдал.

### Эх сурвалж:

1. Бадарчи.С., Криминалистикийн бичиг судлал, УБ., 1989.
2. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик, УБ., 2003.
3. Белкин.Р.С., Курс криминалистики, М., 2001.
4. Бямбадолгор.Л., Компьютерт бэлтгэсэн баримт бичигт хийх криминалистикийн техник шинжилгээ, УБ., 1999. Магистрын ажил.
5. Винберг.А.И., Судебная экспертиология, Волгоград, 1979.
6. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник, УБ., 1998.
7. Лхагвасүрэн.Б., Бичигт хийх криминалистикийн оношлогооны шинжилгээний онол, практикийн зарим асуудал, УБ., 2007. Магистрын ажил.
8. Солонго.Ж., Мөнгөн тэмдэгтэнд хийх криминалистикийн шинжилгээний онол, практикийн зарим асуудал, УБ., 2009. Магистрын ажил.
9. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1, УБ., 2002.

## 5. Галт зэвсэг судлал

### Сэдвийн зорилго:

Галт зэвсэг судлалын ойлголт, галт зэвсгийн ангилал, төрөл, үүсэх мөр, уг шинжилгээгээр тогтоож болох нөхцөл байдал, шинжээчид тавих асуултын талаар тодорхой мэдлэгтэй болох, галт зэвсэг ашиглан үйлдсэн гэмт хэргийг мөрдөх, хянан шийдвэрлэхэд энэхүү мэдлэгийн салбарыг ашиглах чадварыг эзэмшихэд оршино.

### Нэр томьёо:

- Галт зэвсэг, хэрэгсэл
- Гадаад баллистик
- Дотоод баллистик
- Бянт
- Цохих буулгах механизм
- Гол төмөр
- Сум, хушуу, хонгио
- Сумны хонгио, хушууны сан

### Агуулга:

1. Галт зэвсэг судлалын ойлголт.
2. Галт зэвсгийн төрөл, ангилал.
3. Буудлагын улмаас мөр үүсэх зүй тогтол.
4. Гадаад, дотоод баллистик.
5. Галт зэвсгийн мөрөөр тогтоож болох нөхцөл байдал.

### Эх сурвалж:

1. Амгаланбаяр.Ц., Шүүх-шинжилгээ хийлгэхэд тавих асуултын лавлах., УБ., 1994.
2. Алтанхишиг.Ч., Мөрөн.Д., Шүүх-шинжилгээ., УБ., 2004.
3. Алтанхишиг.Ч., Нэгэн жаран., 2004.
4. Бат-Эрдэнэ.Б., Криминалистик., УБ., 2003.
5. Баяр.Б., Криминалистикийн гэрэл зургийн үндэс., 2009.
6. Бүдханд.Ц., Криминалистик., УБ., 2002.
7. Жаргалсайхан.Б., Криминалистикийн техник., УБ., 1998.



8. Жаргалсайхан.Б., Учралын газрын үзлэг., УБ., 2008.
9. Лхагвасүрэн.Б., Мөр., УБ., 2011.
10. Одгэрэл.Х., Галт зэвсгийн шинжилгээ-1., УБ., 2008.
11. Хурцгэрэл.Ж., Криминалистик 1., УБ., 2002.
12. Хурцгэрэл.Ж., Криминалистик 2., УБ., 2004.
10. Б.Хос-Эрдэнэ., Галт зэвсгийн хошуу, хонгионы сангийн өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох нь., УБ., 2008. Магистрын ажил.
11. Д.Золзаяа., Галт зэвсэгт хийх криминалистикийн шинжилгээний онол, практикийн зарим асуудал., УБ., 2009. Магистрын ажил.

### **3-р бүлэг. Криминалистикийн тактик зүй**

#### **Бүлгийн зорилго:**

Криминалистикийн тактик зүйн ойлголт, судлах зүйл, зорилго, зарчим, мөрдөх ажиллагааны таамаглал, төлөвлөлт, зохион байгуулалт, эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны тактикийн талаар системтэй мэдлэг олох, тодорхой төрлийн гэмт хэргийн онцлогт тохируулан байцаан шийтгэх тодорхой ажиллагааг сонгон явуулах ур чадвар эзэмшихэд оршино.

#### **1. Криминалистикийн тактик зүйн ойлголт, мөн чанар**

##### **Сэдвийн зорилго:**

Криминалистикийн тактик зүйн ойлголт, судлах зүйл, тавигдах шаардлага, мөрдөх ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын талаар шинжлэх ухааны онол, арга зүйн суурь мэдлэг олох, эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааг оновчтой сонгон үр бүтээлтэй хэрэглэх дадал, чадвар эзэмших зорилготой.

##### **Нэр томьёо:**

- шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмжүүд
- тактикийн шийдвэр
- тактикийн арга барил
- тактик ажилбар
- тактик хувилбар
- криминалистикийн эрсдэл
- мөрдөн байцаалтын төлөвлөлт
- мөрдөн байцаалтын ажиллагааны зохион байгуулалт
- тактик – байлдаанд бэлтгэх ба явуулах үйл ажиллагааны арга ухаан

##### **Агуулга:**

1. Криминалистикийн тактик зүй нь криминалистикийк шинжлэх ухааны бие даасан хэсэг болох нь.
2. Тактикийн үе шатууд.



## **Эх сурвалж:**

### **А. Хууль эрхийн актууд**

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль ТМ., 2002. №5
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль УБ., 2002

### **Б. Сурах бичиг гарын авлага**

1. Криминалистика., Белкин Р.С. М., 1999
2. Криминалистика., Яблоков Н.П. М., 1997
3. Криминалистика., Пантелеев. И.П. М., 1993 он
4. Юридический энциклопедический словарь М., СЭ -1984
5. Криминалистикийн тактик., Болдбаатар Ж. УБ., 2001
6. Криминалистик II., Хурцгэрэл.Ж. УБ., 2004
7. Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс., Бүдрагчаа. С., Комиссаров В.И.УБ., 1987
8. Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулашгүй ажиллагаа., Доржпалам.Х., Сайнжаргал. Ж., УБ., 1996
9. Мөрдөн байцаалтын ажиллагаа., Глазырин. В.И. М.1975
10. Мөрдөн байцаалтын үзлэг., Балжинням. А.УБ 1988
11. Байцаалт, түүний онцлог., Бат-эрдэнэ. Б. УБ., 1994
12. Таньж олуулах ажиллагаа., Зүмбэрэлхам. Д. УБ., 1994
13. Мөрдөн байцаалтын туршилт., Зүмбэрэлхам. Д. УБ., 1997
14. Малын хулгайн гэмт хэрэгтэй хийх тэмцэлийн арга тактикийн боловсронгуй болгох нь УБ., 1990

## **2. Криминалистикийн таамаглал**

### **Сэдвийн зорилго:**

Криминалистикийн таамаглалын талаарх мэдлэг эзэмшиж улмаар түүнийгээ үйл ажиллагаандаа тогтмол ашиглах хандлага төлөвших, гэмт хэрэг мөрдөх үеийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн нотлох баримтанд үндэслэн дэвшүүлж байгаа төсөөлөхүй нь тухайн гэмт хэргийг илрүүлэх гол хүчин зүйл болохыг мэдсэнээр суралцагч нь тухайн гэмт хэргээ бүрэн дүүрэн шалгаж тогтоох болон хүний эрхийг хангах, хамгаалах талаар тодорхой мэдлэгтэй болох юм.

### **Нэр томьёо:**

- Криминалистик
- Таамаг, таамаглал
- Төсөөлөл
- Төсөөлөхүй
- Нотлох баримт

### **Агуулга:**

1. Таамаглалын тухай ойлголт
  - Таамаглал нь баримт үзэгдлийн талаарх төсөөлөл
  - Таамаглалын ангилал, төрөл, шинж
2. Таамаглал дэвшүүлэх үе шат
  - Таамаглал дэвшүүлэх
  - Таамаглал шалгах
  - Таамаглалд дүгнэлт хийх

### **Эх сурвалж:**

1. Ж.Хурцгэрэл “Криминалистик I-II” УБ., 2003, 2004 он
2. Т.Оюунчимэг нар “Криминалистикийн тактик” УБ., 2000 он
3. Д.Адъяабазар “Монгол УЛСын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт” УБ., 1998 он
4. Д.Адъяабазар, З.Төрмандах нар “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс” УБ., 2005 он



5. Ч.Алтанхишиг, Д.Мөрөн “Шүүх шинжилгээ” УБ., 2004 он
6. Б.Лхагвасүрэн “Гэмт үйлдлийн мөр” УБ., 2009 он
7. Б.Лхагвасүрэн “Мөр” УБ., 2011 он
8. Ц.Амгаланбаяр “Байцаалтанд нотлох баримтыг ашиглах нь” УБ., 1989 он
9. Б.Бат-Эрдэнэ “Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” УБ., 2004 он
10. Ш.Довдон “Гарын мөр” УБ., 2002 он
11. Б.Батзориг “Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” УБ., 2002 он
12. Б.Галдаа “Монгол Улсын нотолгооны эрх зүйн үндсэн асуудал” УБ., 2001, 2008 он
13. С.Нарангэрэл “Хүний эрх өмгөөлөл” УБ., 1998 он
14. Д.Зүмбэрэлхам “Монгол Улсын ЭБШ эрх зүй дэх гэм буруугүйн презумпци” УБ., 2005 он
15. С.Жанцан “Хууль зүйн сэтгэл судлал” УБ., 2005 он
16. Ж.Болдбаатар нар орч.бүтээл “Мөрдөн байцаагчийн тэмдэглэл” УБ., 2011 он

### **3. Мөрдөх ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт**

#### **Сэдвийн зорилго:**

Хэрэг бүртгэлт, мөрдөх ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын талаар онолын мэдлэг олох, гэмт хэргийг илрүүлэх, хэрэг шалгах төлөвлөгөө боловсруулах дадал, чадварыг эзэмших, мөрдөх ажиллагааг төлөвлөлтийн дагуу явуулахын зэрэгцээ, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, бие дааж оновчтой шийдвэр гаргах, бусад албадын үйл ажиллагааны уялдаа холбоог удирдан зохион байгуулах, тусгай техник хэрэгсэлтэй ажиллах мэдлэг, чадвар эзэмшихэд чиглэгдэнэ.

#### **Нэр томьёо:**

- мөрдөх ажиллагааны төлөвлөлт
- хэрэг шалгах төлөвлөгөө
- түүвэр төлөвлөгөө
- календарчилсан төлөвлөгөө
- мөрдөн байцаалтын удирдан зохион байгуулалт

#### **Агуулга:**

1. Мөрдөх ажиллагааны төлөвлөлт.
2. Мөрдөх ажиллагааны төлөвлөлтийн зарчмууд.
3. Мөрдөх ажиллагааны зохион байгуулалт.

#### **Эх сурвалж:**

##### **А. Хууль эрхийн актууд**

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль ТМ., 2002. №5
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль УБ., 2002

##### **Б. Сурах бичиг гарын авлага**

1. Криминалистика., Белкин Р.С. М.,1999
2. Криминалистика., Яблоков Н.П. М., 1997
3. Криминалистика., Пантелеев. И.П. М.,1993он
4. Юридический энциклопедический словарь М., СЭ -1984



5. Криминалистикийн тактик., Болдбаатар Ж. УБ., 2001
6. Криминалистик II, Хурцгэрэл.Ж. УБ., 2004
7. Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс., Бүдрагчаа. С., Комиссаров В.И.УБ., 1987
8. Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулашгүй ажиллагаа., Доржпалам.Х., Сайнжаргал. Ж., УБ., 1996
9. Мөрдөн байцаалтын ажиллагаа., Глазырин. В.И. М.1975
10. Мөрдөн байцаалтын үзлэг., Балжинням. А.УБ 1988
11. Байцаалт, түүний онцлог., Бат-эрдэнэ. Б. УБ., 1994
12. Таньж олуулах ажиллагаа., Зүмбэрэлхам. Д. УБ., 1994
13. Мөрдөн байцаалтын туршилт., Зүмбэрэлхам. Д. УБ., 1997
14. Малын хулгайн гэмт хэрэгтэй хийх тэмцэлийн арга тактикийн боловсронгуй болгох нь УБ., 1990

#### 4-р бүлэг. Криминалистикийн арга зүй

##### Бүлгийн зорилго:

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, байцаан шийтгэх ажиллагааны бүхий л үе шатуудад эрх зүйн ухамсарыг удирдлага болгон олж авсан онолын мэдлэгээ амьдралд бүтээлчээр хэрэгжүүлэх мэдлэг чадвартай болох, түүнчлэн тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөх, нотлохдоо криминалистикийн арга зүйн зөвлөмжүүдийг хуульд нийцүүлэн хэрэглэх дадал эзэмшихэд чиглэнэ.

Түүнчлэн энэ бүлэгт хүн алах, бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, танхайн зэрэг гэмт хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах арга барилд суралцах, хэрэг нэг бүрийн онцлогт тохирсон тактикийн арга барилыг зөв оновчтой ашиглах талаар шинжлэх ухааны онол, арга зүйн зохих түвшний мэдлэг олох, гэмт хэрэг нэг бүрийг криминалистикийн шинжлэх ухааны тусгай зөвлөмжийн дагуу мөрдөн шалгах, техник хэрэгслэл, хүн хүчийг зөв хуваарилан нотлох баримтыг илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, үнэлж дүгнэх, ашиглах талаар ур чадвар эзэмших, мөрдөн байцаах ажиллагааг хэрэгжүүлэхдээ хууль ёсыг дээдлэн сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн ажиллах чиг хандлага төлөвшихэд оршино.

#### 1. Криминалистикийн арга зүйн ойлголт, үзэл баримтлал

##### Сэдвийн зорилго:

Гэмт хэргийг мөрдөх, түүнчлэн тухайн гэмт хэргийг амжилттай илрүүлэх явдлыг хангахад криминалистикийн арга зүйн ерөнхий мэдэгдэхүүнийг удирдлага болгох, аливаа гэмт хэргийг мөрдөхөд өмнөх боловсруулсан зөвлөмжийг ашиглах дадал чадвар эзэмших, ЭБШ хуулийн хэм хэмжээг сахих учиртайг танин мэдэж, хүний эрхийг дээдлэх үзэл төлөвших зорилготой.

##### Нэр томьёо:

- Криминалистикийн арга зүй
- Криминалистикийн үзэл баримтлал
- Криминалистикийн арга зүйн эх сурвалж
- Гэмт хэргийн криминалистик шинж
- Криминалистикийн таамаглал
- Таамаглалын төрөл



### **Агуулга:**

1. Криминалистикийн арга зүйн ойлголт, эх сурвалж, зарчим.
2. Гэмт хэргийн криминалистик шинжийн ойлголт, мөн чанар, ач холбогдол.

### **Эх сурвалж:**

#### **А. Хууль эрхийн актууд**

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль ТМ., 2002. №5
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль УБ., 2002

#### **Б. Сурах бичиг гарын авлага**

1. Криминалистика., Белкин Р.С. М.,1999
2. Криминалистика., Яблоков Н.П. М., 1997
3. Криминалистика., Пантелеев. И.П. М.,1993он
4. Юридический энциклопедический словарь М., СЭ -1984
5. Криминалистикийн тактик., Болдбаатар Ж. УБ., 2001
6. Криминалистик II., Хурцгэрэл.Ж. УБ., 2004
7. Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс., Будрагчаа. С., Комиссаров В.И.УБ., 1987
8. Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулашгүй ажиллагаа., Доржпалам.Х., Сайнжаргал. Ж., УБ., 1996
9. Мөрдөн байцаалтын ажиллагаа., Глазырин. В.И. М.1975
10. Мөрдөн байцаалтын үзлэг., Балжинням. А.УБ 1988
11. Байцаалт, түүний онцлог., Бат-эрдэнэ. Б. УБ., 1994
12. Таньж олуулах ажиллагаа., Зүмбэрэлхам. Д. УБ., 1994
13. Мөрдөн байцаалтын туршилт., Зүмбэрэлхам. Д. УБ., 1997
14. Малын хулгайн гэмт хэрэгтэй хийх тэмцэлийн арга тактикийн боловсронгуй болгох нь УБ., 1990

## **2. Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй**

### **Сэдвийн зорилго:**

Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга зүйн зөвлөмжийг амьдралд хэрэгжүүлэх онолын мэдлэгтэй болох, арга зүйн зөвлөмжүүдийг үйлдэгдсэн хэргийг шалгахад ашиглах дадал чадвар эзэмших, криминалистикийн арга зүйн зөвлөмж нь тодорхой төрлийн гэмт хэргүүдэд хэрхэн илэрдэг болохыг танин мэдэж, улмаар уг арга зүйн зөвлөмжүүдийг ашиглахдаа хүний эрхийг хангах талаар тодорхой хэм хэмжээг баримтлах хандлага төлөвшинө.

### **Нэр томьёо:**

- криминалистикийн аргачлал
- мөрдөн байцаалтын тохироо (нөхцөлт байдал)
- гэмт хэргийн криминалистик шинж
- мөрдөн байцаалтын үе шат
- тактическая комбинация - тактикийн хувилбар
- тактический риск – тактикийн эрсдэл
- преступная алиби – гэмт хэргийн эсрэг нотолгоо

### **Агуулга:**

1. Гэмт хэргийг мөрдөн байцаах аргачлалын тухай ойлголт
2. Мөрдөн байцаалтын үе шатууд
3. Эсрэг үйлдлийг нотлох хэрэгсэл, арга

### **Эх сурвалж:**

#### **А. Хууль эрхийн актууд**

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль ТМ., 2002. №5
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль УБ., 2002



## **Б. Сурах бичиг гарын авлага**

1. Криминалистика., Белкин Р.С. М.,1999
2. Криминалистика., Яблоков Н.П. М., 1997
3. Криминалистика., Пантелеев. И.П. М.,1993он
4. Юридический энциклопедический словарь М., СЭ -1984
5. Криминалистикийн тактик., Болдбаатар Ж. УБ., 2001
6. Криминалистик II., Хурцгэрэл.Ж. УБ., 2004
7. Урьдчилсан мөрдөн байцаалтын шинжлэх ухааны үндэс., Бүдрагчаа. С., Комиссаров В.И.УБ., 1987
8. Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулашгүй ажиллагаа., Доржпалам.Х., Сайнжаргал. Ж., УБ., 1996
9. Мөрдөн байцаалтын ажиллагаа., Глазырин. В.И. М.1975
10. Мөрдөн байцаалтын үзлэг., Балжинням. А.УБ 1988
11. Байцаалт, түүний онцлог., Бат-эрдэнэ. Б. УБ., 1994
12. Таньж олуулах ажиллагаа., Зүмбэрэллхам. Д. УБ., 1994
13. Мөрдөн байцаалтын туршилт., Зүмбэрэллхам. Д. УБ., 1997
14. Малын хулгайн гэмт хэрэгтэй хийх тэмцлийн арга тактикийг боловсронгуй болгох нь УБ., 1990

## ХОЁР. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

### I БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ

#### СЭДЭВ 1. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОЙЛГОЛТ, СУДЛАХ ЗҮЙЛ, ТОГТОЛЦОО, ЗОРИЛГО

1. Ойлголт, үүсэл, хөгжил
2. Шинжлэх ухааны судлах зүйл
3. Шинжлэх ухааны тогтолцоо
4. Шинжлэх ухааны зорилго

**1. Ойлголт.** Криминалистикийн онолын ойлголт XIX зууны сүүл үеэс эхтэй бөгөөд 1892 онд Австрийн шүүхийн мөрдөгч Ханс Гросс “Шүүхийн мөрдөн байцаагч ба цагдаагийн түшмэлийн мөрдлөг болгох зүйл” номоо хэвлүүлсэн нь тухайн үедээ нотлох баримттай ажиллах бүх арга, хэрэгслийг нэгтгэн цэгцэлж, мөр, хэргийн биет баримт цуглуулах, шинжлэх талаар зөвлөмж өгч, гэмт хэрэг үйлдэх, нуун далдлах зарим аргыг тодорхойлон бичиж, ноцтой гэмт хэрэг илрүүлэн мөрдөх арга зүйг томъёолон өгсөн явдал болов.

Энэхүү номоо 3 дах удаагаа 1898 онд “Шүүхийн мөрдөн байцаагчийн мөрдлөг нь криминалистикийн тогтолцоо мөн” нэрээр хэвлүүлэв. Энэ нь чухамдаа гэмт хэрэг илрүүлэх урлаг хэмээн нэрлэгдэж байсан мэдлэгийн энэхүү салбарыг бие даасан шинжлэх ухаан болгох суурийг тавьж “Криминалистик” хэмээн нэрлэх үндэс болжээ.

Эрх зүйн тогтолцооноос хамаарч криминалистикийн шинжлэх ухааныг зарим улс оронд өөрөөр нэрлэж хэвшжээ. Тухайлбал: Англи, Америкт Criminal investigation буюу Гэмт хэрэг мөрдөхүй, Япон болон зүүн өмнөд азийн орнуудад Police science буюу Цагдаагийн шинжлэх ухаан, Энэтхэг болон далайн зарим орнуудад Forensic science буюу Шүүх шинжлэх ухаан хэмээн нэрлэхийн сацуу шинжлэх ухааны тогтолцоо, бүтэц, харьяалал нь ялгаатай байдаг.

Криминалистик нь гэмт хэргийн бүтцийн зүй тогтол, гэмт хэрэг ба түүнд оролцогчдын тухай мэдээлэл бий болох зүй тогтол, түүнчлэн нотлох баримт цуглуулах, шинжлэх, үнэлэх, ашиглах зүй тогтлууд, тэдгээрийн танин мэдэхүй дор суурилсан гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх таслан зогсоох тусгай арга, хэрэгслийн тухай шинжлэх ухаан мөн.<sup>1</sup>

1 Белкин.Р.С., Курс криминалистики., В 3т., 1:Общая теория криминалистики., М.:Юрист., 1997.



Явцуу утгаараа бол: Криминалистик гэдэг нь гэмт хэрэгт холбоотой бүхий л үзэгдлийн зүй тогтлыг судалж, гэмт хэрэгтэй тэмцэх арга зүйг боловсруулдаг шинжлэх ухаан юм.

**2. Судлах зүйл.** Аливаа шинжлэх ухааны судлах зүйл нь янз бүрийн үзэгдэл, үйл явц, баримтад тусгалаа олсон бодит үнэний зүй тогтлын танин мэдэхүй байдаг. Криминалистикийн судлах зүйл нь гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхийн тулд зайлшгүй танин мэдэх бодит үнэний зүй тогтлын цогц юм.

Гэмт хэргийг “залхаан байцааж” биш харин мөрдөж нотлохын тулд криминалистик дараах бодит зүй тогтол (закономерность) болон гаж тогтол (парадокс)-ыг судалдаг.

### **Ерөнхий зүйлд:**

- Криминалистикийн удиртгал. (Криминалистикийн ойлголт, зорилго, зарчим, зорилт, тогтолцоо, хэл)
- Гэмт хэргийн механизмын бодит зүй тогтол, түүний тусгал. (Криминалистикийн үзлийн үүднээс)
- Гэмт хэрэг ба түүнд оролцогчдын тухай мэдээлэл бий болгох зүй тогтол.
- Нотлох баримт цуглуулах, үнэлэх, ашиглах зүй тогтол.

Эдгээр нь гэмт хэрэгтэй тэмцэх тусгай аргачлал, зөвлөмжийг боловсруулдаг суурь ойлголт юм.<sup>2</sup>

### **Тусгай зүйлд:**

- Дадал, туршлагын тухай криминалистикийн сургаал.
- Гэмт хэрэг үйлдэх, нуун далдлах аргын тухай криминалистикийн сургаал.
- Мөр үүсэх зүй тогтлын тухай криминалистикийн сургаал.
- Шинж тэмдгийн тухай криминалистикийн сургаал.
- Мөртэй ажиллах тухай криминалистикийн сургаал.
- Криминалистикийн бүртгэлийн тухай сургаал.
- Криминалистикийн адилтгалын онол.
- Эрэн сурвалжлах тухай криминалистикийн сургаал.
- Криминалистикийн шинжилгээний онол, зарчим.
- Криминалистикийн онолын шүтэлцээ.
- Криминалистикийн таамаглал, мөрдөн байцаалтын төлөвлөлт, зохион байгуулалтын тухай сургаал.
- Криминалистикийн прогнозын онол.<sup>3</sup>

2 Белкин.Р.С., Курс криминалистики., В 3т., 1:Общая теория криминалистики., М.:Юрист., 1997., 56 дахь тал.

3 Белкин.Р.С., Курс криминалистики., В 3т., 1:Общая теория криминалистики., М.:Юрист., 1997., 87 дахь тал.

**3. Криминалистикийн тогтолцоо** (систем) гэдэг нь уг шинжлэх ухааны мэдлэгийг хүлээн зөвшөөрөгдсөн ангиллын дагуу бүлэглэснийг хэлнэ. Криминалистикийн шинжлэх ухаан нь судлах зүйлээсээ хамаарсан 4 элемент бүхий тогтолцоотой.

- Криминалистикийн онол,
- Криминалистикийн техник зүй,
- Криминалистикийн тактик зүй,
- Криминалистикийн арга зүй.

**а. Криминалистикийн онол нь:** ерөнхий онол ба тусгай онолоос бүрдэнэ.

**Криминалистикийн ерөнхий онол** - Шинжлэх ухааны бүхий л судлах зүйл, гадаад, дотоод харилцааг нийтэд нь тусгаж буй ертөнцийг үзэх үзэл, онолын үзэл баримтлал, ухагдхуун, ойлголт, арга, тодорхойлолт, нэр томъёоны тогтолцоо юм.

**Криминалистикийн тусгай онол** - Шинжлэх ухааны судлах зүйлийг хэсэгчилэн хамарч буй мэдлэгийн тогтолцоо бөгөөд криминалистикийн хэрэгсэл, арга барил, зөвлөмжийг боловсруулах суурь юм. Тусгай онолуудын үүсэл нь шинжлэх ухааны хөгжлийг илтгэж байдаг. Криминалистикийн адилтгал ба оношлолын онол, шинж тэмдгийн тухай сургаал, системчлэлийн онол, мөр үүсэх явцын тухай сургаал, нотолгооны мэдээллийг бэхжүүлэх тухай сургаал, эрэн сурвалжлах тухай сургаал, бүртгэлийн тухай сургаал, нөхцөл байдал судлалын онол, баримт судлалын онол, үзэгдэл судлалын онол, мэдээлэл үүслийн онол, экспертологийн онол зэрэг тусгай онолууд байна.

**б. Криминалистикийн техник зүй** - Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх, урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт үйлдлийн мөр цуглуулах, шинжлэх, ашиглахад чиглэгдсэн арга зүйн мөрдлөг, түүнд суурилсан техник зөвлөмжийн тогтолцоо юм. Байгаль, техник, хүмүүнлэг, эрх зүйн шинжлэх ухааны мэдлэг дээр криминалистикийн техник зүйн мэдлэг суурилна.

**в. Криминалистикийн тактик зүй** - Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх ажлыг зохион байгуулах, төлөвлөх, байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъектын зан үйлийн чиг шугам тодорхойлох шинжлэх ухааны мөрдлөг, түүнд суурилсан практик зөвлөмжийн тогтолцоо юм. Криминалистикийн тактик зүйн үндсэн зорилго нь байцаан шийтгэх ажиллагаа, мөр цуглуулах, шинжлэх үйлдлийг төлөвлөлт-зохион байгуулалтын болон тактикийн хамгийн үр дүнтэй хувилбараар хангах явдал байдаг. Логик, сэтгэл судлалын шинжлэх ухааны мэдлэг нь тактик зүйн онолын суурь нь болдог.

**г. Криминалистикийн арга зүй** - Тодорхой төрлийн болон бүлэг гэмт хэрэг мөрдөх, таслан зогсоох аргачилсан зөвлөмж, түүний шинжлэх ухааны мөрдлөгийн



тогтолцоо юм. Криминалистикийн арга зүй нь гэмт хэрэг үйлдэх ба мөрдөх ажиллагааны практик, шинжлэх ухааны арга судлалын мөрдлөгүүдийг судалж, түүний зүй тогтол ба гаж тогтлыг танин мэдсэнээр гэмт хэрэг мөрдөх, таслан зогсоох хамгийн үр дүнтэй аргыг боловсруулах үүрэгтэй.

**4. Криминалистикийн ерөнхий зорилго нь:** хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын (цагдаа, мөрдөх алба, хил хамгаалах алба, маршалын алба гэх мэт) гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг бодитой, шинжлэх ухаанч, шуурхай явуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

#### **Криминалистикийн тусгай зорилго нь:**

А/ Криминалистикийн судлах зүйлийн үндэс болж буй бодит зүй тогтол болон парадоксыг үргэлжлүүлэн судлах, шинжлэх ухааны хөрс суурь болох ерөнхий ба тусгай онолыг хөгжүүлэх,

Б/ Гэмт хэрэг мөрдөх ажлын техник-криминалистикийн хангамжийг байгаль, техник, хүмүүнлэгийн шинжлэх ухааны ололтыг ашиглах замаар сайжруулах, шинээр боловсруулах,

В/ Мөрдөх ажиллагаа, шүүн таслах ажиллагааны зохион байгуулалт, тактик, арга зүйн үндсийг боловсруулах, сайжруулах, энэ зорилгоор мөрдөх ажиллагаа, шүүхийн практикийг нэгтгэн судлах,

Г/ Гэмт хэрэг таслан зогсоох криминалистикийн арга, хэрэгслийг боловсруулах,

Д/ Гадаадын криминалистикчдын ололтыг судалж, гэмт хэрэг мөрдөхөд болон шинжлэх ухааны судалгаанд ашиглах явдал юм.

Криминалистикийн тодорхой зорилго нь гэдэг нь цаг үеийн шинжтэй, тухайн үе шатанд шинжлэх ухааны өмнө оршиж буй шийдвэрлэвэл зохих асуудал юм.

#### **ХЯНАЛТЫН АСУУЛТ:**

1. “Криминалистик” гэсэн нэртөмьёог тайлбарлана уу? Эрх зүйн тогтолцооноос хамаарч уг шинжлэх ухааныг улс орнууд юу гэж томьёолдог вэ?
2. Криминалистикийн шинжлэх ухааны үүсэл, түүний үечлэлийн талаар ярина уу?
3. Криминалистикийн тогтолцоо хоорондын шүтэлцээг юу гэж бодож байна вэ?
4. Криминалистикийн шинжлэх ухааны судлах зүйл юу вэ?
5. Криминалистикийн шинжлэх ухаан нь бусад салбар шинжлэх ухаануудтай хэрхэн холбогдох вэ?

## СЭДЭВ 2. КРИМИНАЛИСТИКИЙН ОНОШЛОЛ БА АДИЛТГАЛЫН ОНОЛ

1. Оношлолын онол, мөн чанар
2. Адилтгалын онол, төрөл, хэлбэр
3. Шинж тэмдэг

1. Онош гэсэн үг “өвчтөнийг шинжилсний үндсэн дээр гаргах өвчний тодорхойлолт”<sup>4</sup> гэсэн агуулгатай. Уг үгийн тайлбарыг ухаж ойлговол: онош гэдэг нь ямарваа нэгэн зүйлийг шинжлэх ухааны аргаар судалж, түүнээс илрүүлсэн шинж тэмдэгт үндэслэж гаргасан мэдээлэл (тодорхойлолт) гэж өргөн утгаар нь тайлбарлах боломжтой юм.

“Криминалистикийн адилтгал маш чухал ач холбогдолтой хэдий ч, нотолгооны зарим асуудал, ялангуяа аливаа үзэгдэл, үйл явдлын мөн чанарыг тодорхойлоход хүчин мөхөсддөг. Өөрөөр хэлбэл, зарим судалгааны үр дүн адилтгалаар бус, оношлолоор тогтоогдоно.”<sup>5</sup> Тухайлбал, хэргийн газраас илрүүлсэн гутлын улны мөртэй адилтгах гутал байхгүй тохиолдолд уг гутлын улны мөрийг оношлож, мөр үүсгэгчийн анатоми шинж (биеийн чац, галбир, нас, хүйс, согог), үйл хөдлөлийн шинж (алхаа, явдалын онцлог, гүйсэн, зогссон байдал), сэтгэл зүй шинж (яарсан, тайван, согтуу байсан эсэх) зэргийг тогтоосноор сэжигтнийг эрэн сурвалжлах эрлийн хүрээг хумих, таамаглал дэвшүүлэх, эрэн сурвалжлах ажиллагааг шуурхай зохион байгуулах, гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх ач холбогдолтой.

Криминалистикийн оношлол зүйн талаар криминалист доктор, профессор Ж.Хурцгэрэл: “Шинж тэмдэг илрүүлэх, ялгах, тодорхойлохыг криминалистикийн онош зүй (диагностика) гэнэ. Объектын тодорхой шинж байдал тогтоох, үйл явдлын явц, үзэгдлийн шалтгааныг тайлбарлах зорилгоор онош зүйн шинжилгээ хийдэг”<sup>6</sup> гэж тодорхойлжээ.

Гэмт хэргийн үйлдэл, арга улам нарийсч нуугдмал, зохион байгуулалттай болж байгаа өнөө үед оношлол зүй ихээхэн ач холбогдолтой юм.

### **Юмс дараах шинж чанартай тул тэдгээрийг оношлох боломжтой.**

- Тодорхой бүлэгт харьяалах ерөнхий шинжтэй.
- Бүлгийн дотроо бусдаасаа ялгагдах хувийн онцлог шинжтэй.

4 Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь*, УБ., 1966., 418 дахь тал.

5 Б.Бат-Эрдэнэ, *“Криминалистик”*, УБ., 2003., 24 дэхь тал.

6 Ж.Хурцгэрэл, *“Криминалистик I”*, УБ., 2002., 95 дахь тал.



- Ерөнхий болон хувийн онцлог шинж нь бүрэлдэх, төлөвших, өөрчлөгдөх зүй тогтолтой.
- Ерөнхий болон хувийн онцлог шинж ямагт тухайн зүйлийнхээ тухай мэдээллийг агуулж байдаг.
- Мөр үүсгэгчийн үйлдэл, түүний улмаас үүссэн мөр хоорондоо шалтгаант холбоотой.

Гэмт хэрэг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөх, нотлох, хянан шийдвэрлэх зорилгоор оношлол хийдэг ба дараах асуудлыг шийдвэрлэнэ.

- Болж өнгөрсөн үйл явдал нь гэмт хэрэг эсвэл эрх зүйн ямар зөрчил болохыг тогтоох,
- Гэмт хэрэг мөн бол түүний криминалистик шинжийг тогтоох,
- Юмсын байдал, шинж чанарыг тодорхойлох,
- Мөр үүссэн зүй тогтол болон парадоксыг тодорхойлох,
- Мөр үүсгэгчийн тухай мэдээллийг бий болгох,
- Үйлдэл, мөр хоорондын шалтгаант холбоог тогтоох,
- Үйлдэл, үйл явдлын нөхцөл тогтоох.

2. Адилтгал (identification)-Криминалистикийн эрэлхийллийн асуудлын хүрээнд объект болон бие хүнийг тэдгээрийн ерөнхий ба хувийн шинж тэмдгийн нийлмэл цогцоор нь адил эсэхийг тогтоох үйл явц юм. Өөрөөр хэлбэл, ул мөрийг, түүнийг үүсгэсэн байж болох объекттой харьцуулж гадаад, дотоод шинжээрээ адил байгаа эсэхийг тогтооно гэсэн үг. Хэрэв адилтгалын объектуудад шинж тэмдэг цогц байдлаараа бүрэн давхацвал тухайн мөр үүсгэгчийг олж тогтоолоо гэж үзэж болно.

Материалаг юмс дараах шинж чанартай тул адилтгалын үйл явц хэрэгжих боломжтой болдог.

- Юмс бүр хувийн онцлог, бусдаас ялгагдах шинжтэй,
- Юмс, үзэгдэл дахин давтагддаггүй,
- Юмсын шинжүүд харьцангуй тогтвортой,
- Юмс харилцаанд орохдоо тусгалаа үлдээдэг

Криминалистикийн адилтгалын үндсэн нөхцөл:

А. Адилтгалын объект тодорхой байх, тогтвортой шинжүүдийг агуулж байх,

Б. Адилтгалын объектын энэхүү тогтвортой шинжийн дүрслэлээр нь явуулах,

В. Адилтгалыг гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх, шүүн таслах ажиллагааны хүрээнд явуулах.

**Криминалистикийн адилтгалын 4 төрөл байдаг:**

А. Шинж тэмдгийн биет дүрсээр адилтгах- Аливаа юмс харилцан үйлчлэх үед бие биедээ тусгал хэлбэрээр гадаад бүтцийнхээ шинжийг үлдээдэг ба тодорхой хугацаанд хадгалагдах энэхүү дүрсээр нь адилтгал хийнэ. Жишээ нь: Хэргийн газраас илрүүлсэн гутлын улны мөрийг сэжигтэн этгээдээс хураан авсан гуталтай адилтгах.

Б. Ерөнхий гарал үүслийнх нь шинжээр адилтгах- Аливаа цогц оршин байсан юмсын хэсгүүд нь нэг гарал үүсэлтэй болохыг шинж чанар, шинж тэмдгээр нь тогтооно. Өөрөөр хэлбэл, тусдаа оршин буй хэсгүүд өмнө нь нэг бүхэл цогц зүйл байсныг тодорхойлох үйл явц юм. Жишээ нь: зам тээврийн гэмт хэргийн газраас бэхжүүлсэн толины хагархай хэсэг, сэжигтний унаж яваа тээврийн хэрэгслийн толины хагархай хэсгүүдтэй хэлбэр дүрс, хэмжээгээрээ тохирвол эдгээр нь гэмт үйлдлийн өмнө нэг бүхэл цогц байжээ гэсэн үг.

В. Хүний оюун ухаанд хадгалагдсан дүрээр адилтгах – Хохирогч, гэрч, яллагдагчийн оюун ухаанд хадгалагдан үлдсэн сэтгэл зүй, физиологийн дүрийг биетээр оршин буй юмтай адилтгахыг хэлнэ. Хүний гадаад дүр төрхийг тодорхойлж, гэмт хэрэгтний субъектив дүрийг (ам зураг) гаргахад гол төлөв хэрэглэгдэнэ. Оюун ухаанд хадгалагдах дүр нь субъектив шинжтэй байх ба сэтгэхүй, мэдрэхүйн хэлбэртэй байж болно.

Г. Тодорхойлон бичсэн шинж тэмдгээр адилтгах – Гэмт хэргийн газраас тодорхойлон бичих аргаар бэхжүүлэн авсан ул мөр, эсвэл картан санд хадгалагдан буй гэмт хэрэгтний талаарх мэдээлэл зэргийг адилтгахыг хэлнэ.

**Адилтгал нь процессын ба процессын бус гэсэн 2 хэлбэртэй байна.**

Процессын хэлбэр нь экспертиз (шинжилгээ) хийлгэх буюу байцаан шийтгэх ажиллагаа явуулах байдлаар хэрэгжинэ. Адилтгалын үр дүн нь шинжээчийн дүгнэлт болон байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлд тусгагдаж нотолгооны ач холбогдолтой болно.

Процессын бус хэлбэрийг үзлэг, нэгжлэгийн үед хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бусад нотлох баримтыг цуглуулах зорилгоор хэрэгжүүлнэ. Эрэн сурвалжлах зорилгоор хийж буй адилтгал, чиглүүлэх мэдээлэл олж авахын тулд хэргийн газар дээр хийж буй экспресс анализ, экспертиз томилохоос өмнө мэргэжилтний гүйцэтгэсэн шинжилгээ нь мөн үүнд хамаарагдана. Эдгээр нь гол төлөв сэтгэхүйн үйлдлийн хэлбэрээр илрэх ба түүний үр дүн нь нотолгооны ач холбогдолгүй байдаг.

3. Шинж тэмдэг – Хэрэгт ач холбогдолтой бүхий л зүйлийн онцлогийг илтгэсэн, оношлол болон адилтгалын зорилгоор ашиглагдах гадаад, дотоод мөн чанар, хэлбэр, дүрс.



Шинж тэмдэг оношлол, адилтгалын ач холбогдолтой байхын тулд дараах нөхцөлийг хангасан байна.

А. Шинжилгээний ач холбогдолтой байх – Шинж тэмдэг онцгой шинжтэй, өвөрмөц, ялгаатай, чанартай байх.

Б. Тод илэрсэн байх – Шинж тэмдэг байнга, тод, ойлгомжтой, дүрслэгдэх. Мөр давтан үүссэн тохиолдол бүрт шинж тэмдэг мөр үүсгэгчийн талаар ижил мэдээлэл дамжуулахыг хэлнэ.

В. Харьцангуй тогтвортой байх – Тодорхой хугацаанд шинж тэмдгүүд хадгалагдаж тогтвортой байхыг хэлнэ.

### Шинж тэмдгийн ангилал

- Объектын шинжийг хамрах хүрээгээр нь : Ерөнхий ба хувийн,
- Төлөв байдлаар нь: Тоон ба чанарын,
- Адилтгалын чиглэлээр нь: Адилтгалын ба ялгаллын,
- Хадгалагдах хугацаагаар нь: Тогтвортой ба харьцангуй тогтвортой,
- Мөн чанараар нь: Зүй ёсны ба тохиолдлын,
- Онцлогийг тодорхойлох ач холбогдлоор нь: Бүлгийн харьяалалын ба хувийн онцлогын,
- Бусад шинж тэмдэгтэй холбоотой байдлаар нь: Хамааралтай ба үл хамааралтай,
- Үүслээр нь: Өөрийн ба олдмол,
- Объектын бүтцийг илэрхийлэх байдлаар нь: Гадаад бүтцийн ба дотоод бүтцийн гэж ангилна.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Криминалистикийн оношлол зүйн мөн чанар юу вэ? Яагаад болж өнгөрсөн үйл явдлыг оношлож болдог вэ?
2. Криминалистикийн адилтгал гэж юу вэ?
3. Адилтгахын шинжлэх ухааны үндэс юу вэ?
4. Шинж тэмдэг гэж юу вэ? Ертөнц дээрх бүх юмс шинж тэмдэгтэй юу?
5. Шинж тэмдэгт ямар шаардлага тавигдсанаар оношлол, адилтгал хэрэгжих боломжтой болдог вэ?
6. Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх үед оношлолыг хэрхэн ашиглах вэ? Оношлол зүйн шинжилгээний дүгнэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх үү?
7. Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөх үед адилтгалыг хэрхэн ашиглах вэ?

### СЭДЭВ 3. КРИМИНАЛИСТИКИЙН ЗАРЧИМ, ХЭЛ

1. Криминалистикийн зарчим – Уг шинжлэх ухааны судалгаанд мөрдлөг болгож буй онол, сургаал, мэдлэгийн үндэс (эхлэл) юм.

- Бодитой байх зарчим,
- Түүхчлэн үзэх зарчим,
- Эрэмблэн цэгцэлж үзэх зарчим.

Бодитой байх зарчим - Шинжлэх ухааны судалгаанд үнэн зөв хандах, судалгааны явц, үр дүн, дүгнэлт, харилцан уялдаатай байх, судалгааны арга үнэн баталгаатай байх шаардлага юм.

Түүхчлэн үзэх зарчим - Танин мэдэхүйн судлагдахууныг үүсэл, хөгжил, үгүй болохтой нь, өөрөөр хэлбэл, үзэгдэл, үйл явдал, баримтыг эхлэл, өрнөл, төгсгөлтэй нь холбож үзэх мөрдлөг юм.

Эрэмблэн цэгцэлж үзэх зарчим - Шинжлэх ухааны бүтцийн хэсгүүд нь харилцан холбоотой, харилцан нөхцөлдсөнийг хүлээн зөвшөөрөхийн сацуу, эдгээр нь нэг бүхэл цогц зүйлийн элемент хэмээн үзэж судлагдахууныг эрэмблэн жиших хандлага юм.

Дээрх нь гэмт хэрэгтэй тэмцэх криминалистикийн суурь зарчимууд бөгөөд үүнээс салбарлан шүүх-шинжилгээний зарчим бий болно.

Шүүх-шинжилгээний зарчим гэж шинжилгээ хийлгэхээр даалгасан албан тушаалтан, шинжээч нараас шинжилгээ хийх үйл ажиллагаанд заавал баримтлах зан үйлийн чиг шугам.

#### **Ерөнхий зарчимд:**

1. Хууль ёсны байх,
2. Шинжээч бие даасан, хараат бус байх,
3. Нууц хадгалах,
4. Аюулгүй байх,
5. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах зэрэг болно.

- Хууль ёсны байх гэдэг нь шинжилгээг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хийнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Арбитрын тухай хуульд шинжилгээ хийх үндэслэл, журмыг зааж өгсөн байдаг. Хэрэв хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж шинжилгээ хийсэн бол шинжээчийн дүгнэлт ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.4-д зааснаар нотлох баримтын эх сурвалж болж чадахгүй. Хуулийн зарим заалтыг ягштал мөрдсөн хэрнээ энэ зарчмыг зөрчих болчихоод байдаг нь тийм заалтыг



залруулах шаардлагатайг харуулдаг. Жишээлбэл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасныг үндэслэн эрх бүхий байгууллагын хүсэлтээр хийсэн шинжилгээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-ийг зөрчих болдог. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т зааснаар шинжээч дуудагдан очиж шинжилгээ хийх ёстой нь амьдралд хэрэгжих боломжгүй байдаг.

- Шинжээч шинжилгээ хийж, дүгнэлтэд хүрэх бүхий л үйл явц бие даасан, хараат бус байх ёстой. Шинжилгээний явцад хөндлөнгөөс нөлөөлөх нь шинжээчээс бодитой бус, амьдралд болж өнгөрсөн үйл явдалтай зөрчилдсөн дүгнэлт гаргахад хүргэдэг. Туршлагатай шинжээч, шадар даргын өгсөн зөвлөгөө, саналыг харгалзан үзэж болох боловч шинжээч гаргасан дүгнэлтээ ЭБШХ-ийн 85 дугаар зүйлийн 85.1, ШШТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.4-д зааснаар зөвхөн өөрөө хариуцна.

- Шинжээч шинжилгээний явцад төрийн болон хувь хүний тухай мэдээллийг мэдэх боломжтой байдаг бөгөөд уг мэдээллийг чандлан нууцлах ёстой. Мөн шинжилгээний явц, эцсийн үр дүнгийн талаар эрх бүхий албан тушаалтнаас бусад сонирхсон хүн бүрт урьдчилан мэдээлж болохгүй.

- Криминалистикийн шинжилгээ, шинжилгээний аргачлал нь хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй, хууль ёсны ашиг сонирхол, эд хөрөнгөнд хохирол учруулахааргүй байх ёстой.

- Криминалистикийн шинжилгээ хүний эрхтэй нягт холбоотой ба криминалистикийн аргаар хүний эрхийг хангах нь гэмт хэргийг шинжлэх ухааны үүднээс нотлож буй явдал юм. Өөрөөр хэлбэл, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны (мөрдөн байцаалт, шүүх хуралдаан) явцад хязгаарлагдсан болон зөрчигдсөн хүний эрхийг криминалистикийн аргаар хангах асуудал, цаашлаад хэн нэгнийг хилсээр шийтгэгдэхээс хамгаалах, эсвэл гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд шударгаар ял оногдуулахад шаардлагатай шинжлэх ухаанч нотлох баримт гаргаж өгөх нь криминалитсикийн зорилго байдаг.

### **Тусгай зарчимд:**

1. Шинжилгээнд шинжлэх ухаанч, бодитой хандах,
2. Шинжилгээг нарийвчлалтай, тал бүрээс нь хийх,
3. Шинжилгээг бүрэн дүүрэн, төгс хийх эдгээр болно.

- Шинжлэх ухаанч, бодитой хандах зарчим: Шинжээч сэтгэл хөдлөл, өөрт төрсөн бодол, субъектив мэдрэмжид бус харин шинжлэх ухааны онол, аргачлалын үр дүнд л тогтоох бодит зүй тогтлыг үнэлж, түүнд үндэслэн дүгнэлтэд хүрнэ. Энэ зарчмыг хангахын тулд шинжээч нь тусгай мэдлэг эзэмшсэн байх ёстой.

- Шинжилгээг нарийвчлалтай, тал бүрээс нь хийх зарчим: Шинжээч энгийн, тойм аргаар шинжилгээг хийх бус харин нарийвчлал өндөр арга, хэрэгсэл, технологи ашиглан шинжилгээний зүйлд буй шинж тэмдэгт үндэслэн боломжит бүхий л мэдээллийг бий болгох ёстой.

- Шинжилгээг бүрэн дүүрэн, төгс хийх зарчим нь шинжилгээнд бодитой хандах, шинжилгээг нарийвчлалтай тал бүрээс нь хийх зарчимтай нягт холбоотой. Шинжээч зөвхөн асуусан асуултад хариулт өгөх бус харин шинжилгээний явцад бий болсон бүхий л үр дүнг дүгнэлтэд дурдах ёстой. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д «Хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар дүгнэлтдээ тусгах» үүрэгтэй гэж хуульчилсан байдаг.

2. Криминалистикийн хэл - шинжлэх ухааны агуулгыг оновчтой илэрхийлж чадах ойлголт, тодорхойлолт, нэр томьёо, таних тэмдгийн тогтолцоо. Шинжлэх ухаан даяаршиж буй өнөө үед мэдлэгийг нэгтгэн цэгцлэх, мэдээлэл дамжуулах зорилгын үүднээс криминалистикийн агуулгыг нэг мөр ойлгох, нэр томьёог цэгцлэх, ижилсгэх, шинэ ухагдахуун бий болгож нэрлэх, тодорхойлолтыг өөрчлөх, хамрах хүрээг нь тэлэх, ялгаж зааглах, таних тэмдгийн системийг боловсруулах шаардлага урган гарч байна.

Нэг зүйлийг янз бүрээр томьёолох нь бодит байдлыг гаж болгох аюултай байдаг. Дэлхийд хүлээн зөвшөөрсөн, түгээмэл хэрэглэдэг шинжлэх ухааны хэл (үг)-ийг криминалистикийн орчинд хэрэглэж болох боловч криминалистикийн агуулгыг дэлхийн улс орнуудын хэл дээр адил утга, агуулгаар ойлгох монгол хэл (үг)-ээр тодорхойлж, нэршил хийх нь хууль зүйн болоод эрдэм судлалын өндөр ач холбогдолтой.



## Сорил

### 1. Аль нь криминалистикийн зарчим бэ?

- a) Бодитой байх зарчим.
- b) Энэрэнгүй ёсны зарчим.
- c) Мэтгэлзэх зарчим.
- d) Шударга ёсны зарчим.

### 2. Криминалистикийн шинжлэх ухааны тогтолцоог нөхөж бич.

- a) .....
- b) .....
- c) .....
- d) .....

### 3. Шүүх-шинжилгээний зарчмыг мөрдлөг болгох субъект хэн нь вэ?

- a) Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч.
- b) Хохирогч.
- c) Мөрдөгч, прокурор, шүүгч, шинжээч.
- d) Өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч.

## II БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН ТЕХНИК ЗҮЙ

### СЭДЭВ 1. МӨР СУДЛАЛ

1. Криминалистикийн мөр судлалын ойлголт
2. Мөрний ойлголт, ангилал, төрөл
3. Мөр үүсэх зүй тогтол

1. Монгол Улсын мөр судлалын уламжлал эртнээс улбаатай гэдэг. Тухайлбал, Халх журам хууль (1709 он)-ийн хулгайн 59 зүйл цаазад “хулгайчийг ах хулгай, дүү хулгай гэж ангилаад анх удаа хулгай хийх, дахин ахин хулгайлах, аргын хувьд ил буюу далд хулгай гэж, хулгайч хүрээнд мөрөө оруулах гэх мэт заасан нь гэмт хэргийг ангилах, мөр судлалыг хөгжүүлэхэд дэвшил гарсныг харуулах баримт юм”<sup>1</sup>, мөн Ардын түр засгийн газрын 1921 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар хурлаар баталсан “Эрүү шүүлтийн тухай тогтоол”-ын 10-р зүйлд: “Аливаа дотоод гадаадын хүмүүсийн эрүү шүүлтийн тухай хэлэлцээд аливаа гадаадын хүнтэй холбогдсон монгол хүнийг мөн гадаадын хүний адил эрүү шүүлт хэрэглэхгүй, эд мөр, хөндлөн гэрчийг баримтлан шийтгэсүгэй. Дан ганц монгол хүн гэрээ гэрчгүйд хэргийг хүлээхгүй бол юуны урьд эрүү шүүлт хэрэглэхгүйгээр үнэнийг олохыг хичээх”<sup>2</sup> гэсэн нь Монгол Улсад “мөр судлал”-ын номлол байсныг нотлож байна.

Криминалистикийн мөр судлал (трасологи)<sup>3</sup> гэдэг нь мөр үүсэх зүй тогтлыг судлаж, улмаар мөртэй ажиллах нийтлэг арга зүйг боловсруулдаг шинжлэх ухааны мэдлэгийн цогц юм.

Мөр судлал нь тодорхой арга зүйг боловсруулахдаа байгал, техник, хүмүүнлэгийн шинжлэх ухааны мэдлэгийг ашигладаг.

Криминалистикийн мөр судлалын зорилго нь мөрийг нотлох баримт болгон хувиргахын тулд мөртэй ажиллах арга зүйн шинжлэх ухааны үндэслэлийг боловсронгуй болгоход оршино.

Мөр судлалын тогтолцоо. Криминалистикийн мөр судлал нь зорилгоо хэрэгжүүлэхийн тулд судалж буй зүйлээсээ хамаарсан, өөр хоорондоо уялдаа

1 Бадарчи.С., Монгол Улсын хуульзүйн албаны түүхийн товчоон., УБ., 2007., 46 дахь тал.

2 Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд., УБ., 1954., 128 дахь тал.

3 Мөр судлал буюу “трасология” гэдэг нь “trace”-мөр гэсэн Франц үг, “logus”-судлал, сургаал гэсэн Латин үгнээс үүсжээ.



холбоо бүхий дараах тогтолцоонд хуваагддаг.

- Шинжлэх ухааны мөрдлөг.
- Мөр-дүрс судлал.
- Мөр-эд зүйл судлал.
- Мөр-бодис судлал<sup>4</sup>.

Шинжлэх ухааны мөрдлөг. Энэ нь мөр, мөр үүсэх нийтлэг зүй тогтлын тухай сургаал, мөр үүсэх явц зүй, мөрний ангилал, төрөл, мөртэй ажиллах арга зүйн онолын үзэл баримтлал.

Мөр-дүрс судлал. Харилцан үйлчлэлийн дүнд мөр үүсгэгчийн гадна шинж мөр хүлээн авагчийн гадаргууд хуулбарлагдан зураглал үүсгэх зүй тогтлыг судлаж, мөрдүрстэй ажиллах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

Мөр-эд судлал. Биет юмс хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулах зүй тогтлыг судлаж, мөр-эдтэй ажиллах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

Мөр-бодис судлал. Бодис тодорхой үйлдлийн улмаас мөр болон үлдэх зүй тогтлыг судлаж, мөр-бодистой ажиллах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

Мөр судлал нь дараах байдлаар салбарлан хөгжсөн байна.

- Хүний мөр судлал. (Антропоскопи, дактилоскопи)
- Шүд судлал. (Одонтологи)
- Эвдлэгч багаж, хэрэгсэл, үйлдвэрийн механизмын мөр судлал. (Механоскопи)
- Тээврийн хэрэгслийн мөр судлал. (Транспортоскопи)
- Мал, амьтны мөр судлал. (Анимаскопи)
- Буудлагын мөр судлал. (Баллистик)
- Үнэр-мөр судлал. (Одорологи) гэх мэт.

2. Монголчууд “мөртэй амьдрах”, “цаасан дээр нэртэй, цасан дээр мөртэй”, “гишгэсэн мөрөө эргэж харах” хэмээн ярьдаг. Эдгээр нь цасан дээр гишгээд байхын үйл биш, харин хүн бүтээсэн зүйлтэй байх, хийж буй ажлаа цэгнэх гэсэн ойлголт билээ. Мөр гэдэг үгнээс “мөрдөх” гэсэн үйл үг үүсэх ба “юмны зам мөрөөр орон явах, мөрийг мөшгөн хянаж шалгах, гэмт хэрэг өдүүлсэн явдлыг илрүүлэн гаргах”<sup>5</sup> үйлийг хэлдэг.

4 Б.Бат-Эрдэнэ., Криминалистик., УБ., 2003., 42 дахь тал.

5 Я.Цэвэл., Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 345 дахь тал.

Харин “гэмт хэргийн мөрийг судлан илрүүлэх, гэмт хэрэгтнийг мөшгөн мөрдөх үүрэг бүхий ажилтныг<sup>6</sup> мөрдөгч” хэмээнэ.

Манай орны эрдэмтэн, судлаачдын бүтээлд мөрийг дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал, доктор, профессор Ж.Хурцгэрэл: “Криминаликтик мөрийг өргөн болон явцуу гэсэн хоёр утгаар ойлгоно. Өргөн утгаараа бол энэ нь гэмт хэргийн ямар ч материаллаг үр дагавар, объект буюу эд юмсын байдлын өөрчлөлт, нэг зүйл нөгөөдөө үйлчилснээс бий болсон мөр, гэмт этгээдийн орхисон объект, гэмт этгээдийн авч явсан объект”<sup>7</sup>, доктор Б.Бат-Эрдэнэ: “Мөрийг өргөн утгаар нь авч үзвэл энэ нь гэмт үйлдлийн үр дүнд үүссэн бүхий л өөрчлөлт”<sup>8</sup>, Б.Жаргалсайхан: “Мөр гэсэн ерөнхий ойлголтод гэмт хэрэг үйлдэгдсэнтэй холбогдон хүрээлэн буй орчинд үүсэж бий болж байгаа аливаа бодит өөрчлөлтүүдийг хэлнэ”<sup>9</sup> гэж тус тус тодорхойлжээ.

Ямар нэгэн үйлийн улмаас хүрээлэн буй орчинд бий болсон бүх төрлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг мөр гэж ойлгож болох ба тухайн орчинд шинээр бий болсон, тэндээс алга болсон, байсан зүйл солигдсон гэх мэт хэлбэрээр илэрч болно.

Ингэхлээр хууль зүйн онол, практикт хэрэглэдэг «ул мөр, эд мөрийн баримт, баримт сэлт» гэсэн ойлголт нь бүгд «мөр» гэсэн ойлголтын агуулгад багтаж байна.

Гэмт үйлдлийн мөр гэдэг нь нийгэмд аюултай үйлийн улмаас бий болсон, тухайн хэргийг нотлож, шийдвэрлэхэд ач холбогдолтой бүхий л зүйлийг хэлнэ.

Гэмт үйлдлийн мөр нь хэргийн газар, сэжигтэн, хохирогчийн ой ухаан, бие, хувцас, ачаа, тээш, тээврийн хэрэгсэл, орон байр, компьютерийн төхөөрөмж, санах ой зэрэгт үүснэ.

Англиар “evidence” гэдэг нь монгол “мөр” гэсэн үгтэй дүйх ойлголт юм. Evidence гэдгийг Cambridge-ийн тайлбар тольд “ямар нэгэн шийдвэр гаргахад хүргэж буй үндэслэл” /one or more reasons for believing that something is or is not true/<sup>10</sup> гэж тайлбарласан байна. Эндээс үзвэл, аливаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд үндэслэх нотлох баримтын иш нь “evidence” болж байна. Үүний нэгэн адил нотлох баримтын анхын хэлбэр нь мөр билээ. Өөрөөр хэлбэл, мөр нь криминалистикийн тусламжтайгаар нотлох баримт болон хувирдаг.

6 И.Дамбажав., Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж., УБ., 2010., 983 дахь тал.

7 Ж.Хурцгэрэл., Криминалистик-I., УБ., 2002., 248 дахь тал.

8 Б.Бат-Эрдэнэ., Криминалистик., УБ., 2003., 42 дахь тал.

9 Б.Жаргалсайхан., Криминалистикийн техник., УБ., 1998., 49 дэх тал.

10 Cambridge international dictionary of English., Cambridge university press., 1995., 474 дэх тал.



Мөр —————> Нотлох баримт

Evidence —————> Proving fact

Мөрийг гадаад төлөв, дотоод бүтцийг нь харгалзан үндсэн гурван бүлэгт ангилдаг.<sup>11</sup>

- а. мөр-дүрс (следы-отображения), (trace-evidence),
- б. мөр-эд (следы-предметы), (physical-evidence),
- в. мөр-бодис (следы-вещества), (substance-evidence)

Мөр-дүрс гэдэг нь юмсын харилцан үйлчлэлийн дүнд нэг юмны<sup>12</sup> гадна шинж нөгөө юмны гадаргууд хуулбарлагдаж үлдсэн зураглал, өөрчлөлт юм.

Мөр-дүрс нь өнгөц буюу зураглал, гүн буюу өөрчлөлт гэсэн хоёр хэлбэрээр үүсдэг. Жишээ нь: гарын мөр, модон шал дээрх гутлын улны тоосон мөр, цас, нойтон шавар дээр үүссэн тээврийн хэрэгслийн мөр, модон хаалганы хүрээн дээр хөшсний улмаас үүссэн хонхойсон мөр.

Мөр-эд гэдэг нь хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулж байгаа, хэргийн газарт нэмэгдсэн болон хэргийн газраас хасагдсан биет юмсыг хэлнэ. Хэргийн газарт байх эвдлэгч багаж, галт зэвсэг, сум, хонгио, тээврийн хэрэгслийн салж үлдсэн эд анги г.м.

Энэ мөр нь ямагт гэмт үйлдлийн талаарх мэдээллийг агуулж байдаг бөгөөд тэрхүү мэдээллийг нь криминалистикийн техникийн мэдлэгийн салбарууд гаргаж өгдөг.

Мөр-бодис гэдэг нь гэмт үйлдлийн улмаас үүссэн физик, биологи, химийн гаралтай бодисын гурван төлөв. Жишээ нь: цус, үрийн шингэн, шүлс, үнэр, ялгадас болон хар тамхи, хүнсний зүйл, эм бэлдмэл, хөрс, шороо, ургамлын наалдац, дарь тортог г.м.

Бодисыг бүрдүүлэгч бөөмсийн харилцан байрлал өөр өөр байдаг тул бодис хатуу, шингэн, хий гэсэн төлөвтэй. Хатуу мөр-бодис нь гэмт үйлдлийн тухай мэдээллийг удаан хадгалах чадвартай байдаг. Шингэн мөр бодис нь тодорхой үйлдлийн хүч, чиглэлийн дагуу янз бүрийн хэлбэрийг үүсгэдэг. Энэ нь болж өнгөрсөн үйл явдлын өрнөлийг илэрхийлэх чадвартай байдаг. Тухайлбал, цусны дусал, цацралт, туналт, арчигдалтаар үйлчилсэн хүч, тээврийн хэрэгслээс дуссан зүйлээр явсан чиглэл зэргийг тогтооно. Хий бүхий зарим мөр-бодис хүний нүдэнд үл харагддаг, хүний үнэрлэх эрхтэнд мэдрэгддэггүй тул гэмт этгээдүүд уг мөрийг баллаж чаддаггүй.

11 Р.С.Белкин., Криминалистик, Москва., 1999., 206 дахь тал.

12 юм-аливаа байгаа бүх зүйлийг ерөнхийлөн нэрлэх үг. Я.Цэвэл., “Монгол хэлний товч тайлбар толь”, 1966 он., 895-р тал.

Иймд хүний үнэрийн мөр нотолгооны чадал их байдаг.

Мөр-дүрс, мөр-эд, мөр-бодис нь дангаараа оршихоос гадна нэгдмэл байж болно. Жишээ нь, хутга-цус, хувцас-цус, галт зэвсэг-гарын мөр, гутал-хөрс, үнэр-малгай гэх мэт хэлбэрээр оршино.

Мөрний ангилал түүний бий болсон механизмыг зөв тогтоох, ингэсний үр дүнд мөр бий болгосон тодорхой үйлдлийн арга, объектын онцлогийн тухай дүгнэлт хийх бололцоо олгодог<sup>13</sup> ба мөрийг ангилан, төрөлжүүлэх нь:

- мөр үүссэн зүй тогтлыг танин мэдэх,
- мөр унших,
- таамаглал дэвшүүлэх,
- хэргийн газраас илрүүлсэн мөрийг үзлэгийн тэмдэглэлд зөв тодорхойлон бичих,
- мөрийг зөв бэхжүүлж, битүүмжлэх,
- мөрийг зөв үнэлэх, ашиглах зэрэгт ач холбогдолтой.

3. Материаллаг ертөнцийн үзэгдлүүд түгээмэл холбоотой, харилцан бие биенээсээ шалтгаалж байдаг учраас гэмт хэргийн мөр бий болох нь зайлшгүй. Үүнээс үндэслэн мөр яаж бий болов, гэмт хэрэг үйлдсэн процесс, арга, гэмт этгээдийн бүх үйлдэл нь тодорхой зүй тогтолд захирагдаж байгаа эсэхийг тогтоох зүй ёсны шаардлага гарч ирнэ.<sup>14</sup>

Иймд мөр үүсэх зүй тогтлыг нарийн судласнаар “гэмт хэрэг гарсан байдал \гэмт хэрэг хэдийд, хаана, яаж үйлдсэн болон бусад байдал, уг гэмт хэргийг хэн үйлдсэн, гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр, яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдал, түүнд хүлээлгэх хариуцлагын хэр хэмжээ, шинж чанарт нөлөөлөх нөхцөлүүд, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл”<sup>15</sup> зэрэг хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг шинжлэх ухааны үндэстэй тогтоох боломжтой.

Мөр үүсэх нийтлэг зүй тогтол. Мөр нь физик, хими, биологийн объектив үйлчлэлийн үр дүнд ердийн явцаар үүсэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, мөр үүсгэгч этгээд нь мөрийг субъектив байдлаар өөрчлөөгүй гэсэн үг. Үүссэн мөр нь болж өнгөрсөн үйл явдлын бодит үнэнийг илэрхийлж чадах мэдээллийг агуулсан, үйлдэл, түүний үр дүнд үүссэн мөр нь хоорондоо логиктой, шалтгаант холбоотой байх ёстой.

13 Ж.Хурцгэрэл., Криминалистик-1., УБ., 2002., 253 дахь тал.

14 Ж.Хурцгэрэл., Криминалистик-1., УБ., 2002., 16 дахь тал.

15 Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйл.



Зүй тогтол гэдэг нь жам ёс, логиктой байх гэсэн агуулгыг илэрхийлдэг байна.

### **Мөр үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:**

1. Мөр үүсгэгчийн онцлог.
2. Мөр хүлээн авагчийн онцлог.
3. Мөр үүсгэгчийн санаа, зорилго.
4. Мөр үүсгэгчийн үйлдэл, хөдөлгөөн.
5. Мөр хүлээн авагчийн үйлдэл, хөдөлгөөн.
6. Мөр үүссэн орчин, нөхцөл.

Гэмт этгээд мэргэших явдал байгааг криминологичид тогтоосон байдаг. Мэргэшсэн гэмт хэрэгтэн нь гэмт үйлдлээ нуух, мөрдөгчийг төөрөгдүүлэх, буруу шийдвэр гаргуулах зорилгоор үүсгэсэн мөрөө баллах, эсвэл мөрийг гаж үүсгэж болно.

Гаж тогтол буюу парадокс гэдэг нь гаж буруу, логикгүй, зөрчилдөөнтэй гэсэн агуулгыг илэрхийлдэг байна. Өөрөөр хэлбэл, болж өнгөрсөн үйл явдлын бодит үнэн нь хэргийн газарт байх мөрүүдтэй логикгүй байхыг хэлнэ. Гаж тогтлыг 3 хуваан ойлгож болно.

- Зүй тогтлын дагуу бий болсон мөрийг санаатайгаар өөрчлөх. Жишээ нь: цонхны шилийг гаднаас нь хагалж ороод, дотор унасан хагархай шилийг гадаа гаргах, мөн галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэргийг амиа хорлосон мэт зохион байгуулах гэх мэт.
- Мөрийг санаатайгаар гаж үүсгэх. Жишээ нь: ирсэн, явсан чиглэлээ мэдэгдүүлэхгүйн тулд гэдрэг алхах, хажуугаар гишгэж явах, багадсан, эсвэл томдсон гутал өмсөх, мөн хүний гарын хээг полимерын технологи ашиглан хувилж, хиймэл хуруугаар хэргийн газарт дардас үүсгэх гэх мэт.
- Хэргийн газарт буй мөрийг дутуу буюу буруу судлаж, болж өнгөрсөн явдлын бодит үнэнийг буруу таамаглан, шийдвэр гаргах. Хэргийн газарт үүссэн мөрний объектив шинж болон гэрч, хохирогч, сэжигтний мэдүүлгийн субъектив шинж хоорондын ялгааг зөв үнэлээгүйн улмаас хэн нэгнийг хэлмэгдүүлэх, эсвэл ял завшуулдаг.

Иймд мөр үүсэх зүй тогтлыг нарийн сайн судлаагүйгээс болж мөртэй харьцдаг эрх бүхий этгээд (мөрдөгч, шинжээч, эрүүгийн төлөөлөгч, хэрэг бүртгэгч, прокурор, шүүгч)-ийн ажил үр дүнгүй болох, мөр нотлох баримтын ач холбогдлоо алдах аюултай байдаг.

Гэмт этгээдүүд хэвийн байх үедээ хэзээ ч хийхгүй гэж бодож, төлөвлөж байсан зүйлээ гэмт хэрэг үйлдэх үедээ сандарч догдолсондоо хийчихдэг явдал түгээмэл байдаг учир хаана, ямар мөр үлдээснээ тэр болгон санаж, баллаж чаддаггүй.

Иймд зүй тогтол, эсвэл гаж тогтлын дагуу үүссэн мөрийг нотлох баримт болгож чадах, эс чадах нь зөвхөн хуульч, мөрдөгчөөс хамаарна.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Мөр гэж юу вэ? Мөр нь үлддэггүй юмс, үзэгдэл орчлонд бий юу?
2. Криминалистикийн мөр судлалыг тодорхойлно уу.
3. Мөрийг үндсэнд нь хэдэн бүлэгт хуваадаг вэ? Тэдгээрийн онцлогийг дурьдана уу.
4. Мөр судлалын шинжилгээгээр хэрэгт ач холбогдолтой ямар асуудлуудыг шийдвэрлэдэг вэ?
5. Мөр судлалын шинжилгээнд тавих нийтлэг асуултууд?

### Бодлого

2011 оны 3 дугаар сард буюу хаврын хуурайшилтай өдөр орон сууцны 1-р давхарт байх нэгэн айлд хулгайн гэмт хэрэг үйлдэгджээ. Хэргийн газрын үзлэгээр вакум цонхны гадна талын хүрэн дээрээс “сажа” нунтаг ашиглан гарын мөр илрүүлжээ. Уг гарын мөрийг ШШҮХ-ийн “Гарын мөрний нэгдсэн сан”-д оруулан хайлт хийж үзэхэд Бат гэгчийн гарын мөр болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдов. Батыг баривчлан мэдүүлэг авахад, сэжигтэн этгээд: “Би өнгөрсөн намар 9 дүгээр сард энэ айлын цонхыг солисон. Тэгэхлээр миний гарын мөр байх нь дамжиггүй биздээ” гэсэн мэдүүлэг өгчээ. Мөрдөн байцаагч мэдүүлгийг баримтлан сэжигтнийг шалгах шаардлагагүй юм байна гэсэн шийдвэр гаргав. Бат нь вакум цонхны үйлдвэрт ажилладаг бөгөөд тухайн айлд захиалгаар цонх суулгасан нь үнэн болно.

### Асуулт:

1. Та мөрдөн байцаагч байсан бол ямар шийдвэр гаргах вэ?
2. Цонхноос илрүүлсэн гарын мөр, сэжигтний мэдүүлэг хоорондын шалтгаант холбоонд криминалистикийн мөр судлалын үүднээс үнэлэлт өгөх.
3. Мөр үүсэхэд улирал, цаг агаар хамааралтай юу?



## СЭДЭВ 2. МӨРТЭЙ АЖИЛЛАХ АРГА ЗҮЙ

1. Мөртэй ажиллах арга зүйн ойлголт, зарчим
2. Мөртэй ажиллах үе, шат

1. Мөртэй ажиллах гэдэг нь мөрийг мөрдөн байцаалтын болон шүүхийн шийдвэрийн үндэслэл (нотлох баримт) болгохын тулд түүнтэй тогтсон үе, шат, стандарт-аргачлалын дагуу харьцах үйл юм.

Байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчид, шинжээч, мэргэжилтэн, эрүүгийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас мөртэй харьцахдаа заавал баримтлах зан үйлийн чиг шугамыг мөртэй ажиллах зарчим гэнэ. Мөртэй ажиллах зарчмыг баримтлахгүй бол уг мөр нь гэмт хэрэг илрүүлэх нотолгооны ач холбогдлоо алддаг.

### Дараах зарчимтай:

1. Мөр устгахгүй байх. (мөртэй болгоомжтой, мөр-эдийг ердийн хэрэглээний явцад хүний гар хүрдэггүй хэсгээс барьж харьцах)
2. Өөрийн мөрийг нэмж үүсгэхгүй байх. (өөрийн мөрийг үүсгэхгүйн тулд ариутгасан хувцас, малгай, амны хаалт, бээлий, улавч зэргийг өмсөх)
3. Аюулгүй байх. (халдварт өвчин тусах, бэртэж, гэмтэхээс сэргийлж, болгоомжлох шаардлагтай)
4. Тогтсон үе, шатыг баримтлах. (Тогтсон үе, шатыг алгасах, дэс дарааллыг алдагдуулахгүй байх)
5. Стандарт-аргачлалын дагуу харьцах. (Аль болох дэвшилтэд технологи, баталгаажсан арга, хэрэгсэл ашиглан ажиллах)

2. Мөртэй ажиллах дараах үе байдаг ба үе бүрт мөртэй харьцах шат, аргачлал гэж бий.

Мөн мөртэй ажиллах үе болгонд мөр үүссэн зүй тогтлыг сайтар анзаарч, мөрийг хамгаалж байвал зохино.

- 1 дэх үе: Мөр илрүүлэх.
- 2 дахь үе: Мөр мөшгөх.
- 3 дахь үе: Мөр бэхжүүлэх.
- 4 дэх үе: Мөр битүүмжлэх.
- 5 дахь үе: Мөр зөөвөрлөх.
- 6 дахь үе: Мөр шинжлэх.
- 7 дахь үе: Мөр ашиглах.
- 8 дахь үе шат: Мөр хадгалах.

## **МӨР ИЛРҮҮЛЭХ АРГА ЗҮЙ**

“Ил” гэдэг үг нь далд биш, дотор биш, нууц биш, илэрхий, тодорхой гэсэн утгатай.<sup>16</sup>

Мөр илрүүлэх гэдэг нь хэрэгт ач холбогдолтой байж болох мөрүүдийг илэрхий болгохыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, тодорхой үйлийн улмаас бий болсон өөрчлөлт, хөдөлгөөний байж болох газрыг тогтоох, тогтоосон газартаа эрэх, эрсэн зүйлээ тодорхойлох, ил болгох идэвхтэй үйлдэл юм.

### **Мөрийг дараах зүйлсээс илрүүлж болно.**

1. Хэргийн газар. Энэ нь гэмт үйлдэл эхэлсэн, өрнөсөн, төгссөн орон зай, хүрээлэн буй орчин тул мөр илрүүлэх хамгийн боломжит объект юм.
2. Цогцос. Биед үүссэн шарх, биологийн өөрчлөлт, хувцсанд үүссэн гэмтэл, бусад мөр зэрэг нь гэмт үйлдлийн арга, хэрэгсэл, хэрэг үйлдэгдсэн цаг, хугацаа болон хэрэгт ач холбогдолтой олон мэдээллийг агуулж байдаг.
3. Хохирогч. Түүний хувцас, бие, гэр, тээврийн хэрэгсэл зэрэгт сэжигтний мөр үүссэн байдаг.
4. Сэжигтэн. Харилцан үйлчлэлийн дүнд сэжигтний хувцас, бие, гэр, тээврийн хэрэгсэл зэрэгт хохирогч болон хэрэг болсон орчноос мөр үүсдэг.

### **Мөр илрүүлэх үе нь дараах шатаар явагдана:**

А. Мөр эрэх. Энэ нь хэргийн орчин, болж өнгөрсөн үйл явдал, үзэгдэл, гэрч хохирогчийн мэдүүлэг, мөр илрүүлэх ажилтны мэдлэг, чадвар, туршлага, дадал, авьяаст тулгуурлан гэмт үйлдлийн үр дүнд үүссэн бүхий л өөрчлөлт, хөдөлгөөнийг тодорхой арга, хэрэгслийн тусламжтайгаар идэвхтэй хайхыг хэлнэ.

Б. Мөр тодорхойлох. Хэргийн газар байгаа энгийн нүдэнд ил харагдах мөрийг хэрэгт хамааралтай болохыг тогтоож, дугаарлах, ялгаж ангилахыг хэлнэ.

В. Мөр ил болгох. Тодорхой арга, хэрэгсэл ашиглан үл үзэгдэх мөрийг илэрхий болгох, бүдэг мөрийг тод болгох үйлдэл юм.

### **Мөр илрүүлэх дараах арга байдаг.**

- Энгийн. Энэ нь хэргийн газрын орчинд байх, гэмт үйлдлийн улмаас бий болсон өөрчлөлт, хөдөлгөөн, түүнийг баллах, нуух гэсэн мөрийг хүн энгийн нүдээрээ харж, байгалийн болон тасалгааны ердийн гэрэлд эрэх, тодорхойлохыг хэлнэ.
- Физикийн. Энэ нь төрөл бүрийн гэрлийн долгион үүсгэгч төхөөрөмжөөс бий болдог ойсон, хугарсан, нэвтэлсэн гэрлийн туяа, юмсын бусдаас ялгагдах шинж чанарыг (өнгө, дүрс зэрэг гадаад төлөв) тодруулах, ялгаруулах бодис,

---

16 Я.Цэвэл., Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 302 дахь тал.



хэрэгсэл, өсгөгч, томруулагч болон эрэгч төхөөрөмжүүдийг ашиглан мөр эрэх, тодорхойлох, ил болгохыг хэлнэ.

- Химийн. Энэ нь энгийн болон фикикийн аргаар ил болохгүй бүдэг болон үл үзэгдэх мөрийг тухайн мөр байж болох газарт, уг мөрний химийн бүтэц, найрлага, молекулын шинж чанараас хамаарч түүнтэй урвалд орж хүний нүдэнд харагдах болон бусад төхөөрөмжинд мэдрэгдэх бодис, урвалжаар эрэх, тодорхойлох, ил болгохыг хэлнэ.

### **МӨР МӨШГӨХ АРГА ЗҮЙ**

Мөр мөшгөх гэдэг нь мөрөнд агуулагдаж буй шинжийг уншин, мөр үүсгэгчийг мөрөөр нь хөөхийг хэлнэ. Мөр мөшгөх нь гэмт хэргийг хурдан шуурхай халуун мөрөөр нь илрүүлэх боломжийг олгодог.

#### **Мөр мөшгөх үе нь дараах шатаар явагдана:**

А. Мөр унших. Энэ нь мөрөнд агуулагдаж буй шинж тэмдэгт үндэслэн мөр үүсгэгчийн тухай мэдээллийг гарган авах тогтсон аргачлал. Жишээ нь: Хөлийн мөрнөөс гутлын төрөл, зориулалт, өмсгөл, хийц, ул бэхэлсэн арга, өмсөж яваа хүний хүйс, биеийн галбир, чац, явдлын онцлог, явсан, ирсэн чиглэл зэргийг тогтоож болно.

Б. Мөр хөөх. Мөр үүсгэгчийн талаар төсөөлөлтэй болсны дараа цуваа мөрийг дагах үйлдэл юм. Цуваа мөрийг дагахдаа мөр үүссэн зүй тогтол, гаж тогтлыг сайтар анхаарах хэрэгтэй. Мөр хөөснөөр гэмт хэрэгтнийг шуурхай эрэн сурвалжилж баривчлах ач холбогдолтой.

В. Мөр хүлээлгэн өгөх. Мөр хөөж байх явцад цуваа мөр хамгаалалттай зурвас, бүс (хилийн зурвас, дипломат байгууллагын хашаа)-рүү нэвтрэн орсон байвал зохих эрх бүхий этгээдэд мөр үүсгэгчийн талаарх мэдээлэл, мөрийг хүлээлгэн өгч, цааш үргэлжлүүлэн мөшгүүлнэ.

### **МӨР БЭХЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ**

Мөр бэхжүүлэх гэдэг нь мөрөнд агуулагдаж буй мэдээлэл, шинж тэмдгийг тодорхойцаг хугацаа, орон зайд алдагдуулахгүй байхаар батжуулах, баримтжуулахыг хэлнэ.

Мөр бэхжүүлэхдээ хэдий чинээ олон аргыг хослуулна төдий чинээ нотлогооны ач холбогдол их болно. Хэргийн газраас илрүүлсэн мөр бүрийг эхлээд хэмжихүйн гэрэл зургаар бэхжүүлсний дараагаар тодорхойлон бичнэ. Үүний дараа тухайн мөрний онцлогт тохирсон бусад аргуудаар бэхжүүлэх ёстой.

Хэргийн газраас тэр орчны хөрс, шороо, ургамал, байшингийн будаг, шохой, цементнээс заавал дээж авч байх ёстой.

Учир нь сэжигтэн этгээдийг тогтоож, баривчилсны дараагаар гутал, хувцаснаас мөр илрүүлэн эдгээр дээжтэй адилтгаснаар уг этгээд тухайн хэргийн газарт байсан гэдэг нь нотлогдох юм.

### **Мөр бэхжүүлэх арга:**

- Гэрэл зураг. Хэргийн газрын үзлэг, мөрдөн байцаалтын ажиллагаа болон шүүх-шинжилгээний үед бүх төрлийн мөр бэхжүүлэхэд энэ аргыг түгээмэл ашигладаг. Зарим тохиолдолд мөр-дүрсийг биет болгон бэхжүүлэх явцад мөрний шинж тэмдгийг баллах тохиолдол багагүй гардаг тул өмнө нь заавал гэрэл зургаар бэхжүүлдэг. Мөрний хэмжээ, хэлбэр, өнгө, гадна дүрс зэргийг тодорхой харуулахын тулд хэмжихүйн гэрэл зургийн аргыг ашигладаг. Хэмжихүйн гэрэл зургийг авахад дараах барилыг анхаарна. 1) эгц дээрээс нь буюу аппаратны дуран, мөр хоорондоо перпендикуляр байх, 2) мөр кадрт дүүрэн байх, 3) мөр кадрт багтсан байх, 4) мөрний хажууд масштабын шугам байрлуулах, 5) гэрэлтүүлэг, мөрний өнгө, гадаргуун онцлог, зай зэргээс хамаарч аппаратны тохиргоог (өрц, хурд, фокус, гүний тодрол) зөв хийх ёстой
- Дүрс бичлэг хийх. Дүрс бичлэг нь байцаан шийтгэх ажиллагааны явц, үр дүнг бэхжүүлэх нэмэлт хэрэгсэл бөгөөд мэдээллийг бүрэн, бодитой дамжуулах давуу талтай.<sup>17</sup> Дүрс бичлэг хийж байх явцаа тайлбарыг цэгцтэй, дараалалтай, сонсогдохуйц, зөв үгээр унших ёстой.
- Хэмжих. Мөрний тоон үзүүлэлтийг төрөл бүрийн хэмжих хэрэгслийн тусламжтайгаар тодорхойлох арга юм. Тоон үзүүлэлтэд шугамын ба өнцгийн хэмжээ, жин, эзлэхүүн, харьцаа, температур, хугацаа, хурд, даралт хамаарна.
- Тодорхойлон бичих. Энэ арга нь хэргийн газрын үзлэгийн болон байцаан шийтгэх бусад ажиллагааны тэмдэглэлд тусгагдан хэлбэрждэг. Мөн тусгайлан бэлтгэсэн хэвлэмэл маягтад мөрийг бүртгэн тэмдэглэж болно. Дараах зүйлийг тоочин бичсэнээр тодорхойлон бичих аргаар мөр бэхжүүлсэн гэж үзнэ. Үүнд: а) мөр илрүүлсэн газар, огноо, б) мөр хүлээн авагч, в) мөр үүсгэгч, г) мөрний байрлал, зай, д) мөрний физик шинж, төлөв, өнгө, хэлбэр, хэмжээ, дүрс, е) ерөнхий шинж, ё) хувийн онцлог шинж, ж) мөр үүссэн зүй тогтол, з) мөр илрүүлсэн арга, хэрэгсэл, и) мөр бэхжүүлсэн арга, хэрэгсэл, й) мөртэй ажилласан албан тушаалтан, нэр, гарын үсэг, к) хөндлөнгийн гэрч. Мөрийг тодорхойлон бичих аргаар бэхжүүлэхдээ криминалистикийн хэлээр бичих шаардлагатай.
- Гар зураг үйлдэх. Мөр бэхжүүлэх энэ аргыг практикт ихэвчлэн зам тээврийн хэрэг, ослын үзлэгийн үед ашигладаг ч бүх төрлийн хэргийн газрын үед ашиглах нь зүйтэй. Учир нь хэргийн газрын хүрээ, хэргийн газарт байсан зүйлс, хаанаас ямар төрлийн хэдэн мөр илрүүлсэн, хэргийн бусад байдал зэрэг олон мэдээллийг нэг дор харуулах боломжтой байдаг тул ихээхэн ач холбогдолтой. Гар зургийг

17 Б.Бат-Эрдэнэ., Криминалистик., 2003., УБ., 41 дэх тал.



масштаб хэрэглэхгүйгээр, энгийн, ойлгомжтой, цэргийн байр зүйн таних тэмдэг ашиглан үйлддэг.

- Хэв авах. Паста-К, эмнэлгийн гипс, хиймэл шүдний материал, нам температурт хайлах металл, лааны тос, селикон зэргээр гүн мөр-дүрсний хэвийг авдаг. Хэвийг цутгах, цацах гэсэн 2 хэлбэрээр авч болно.
- Хуулбар авах. Энэ аргаар өнгөц мөр дүрсийг бэхжүүлдэг. Жишээ нь, гарын мөрийг нунтгаар тодруулсны дараа тунгалаг өнгийн наалдамхай туузаар мөр тээгчээс нь хуулан авч, мөрний эсрэг өнгийн дэвсгэр дээр наан бэхжүүлдэг. Мөн цахилгаанаар цэнэгжүүлсэн нимгэн металл ялтсаар хивс, давуун бүрээстэй сандал зэрэг дээр үүссэн тоосон мөр-дүрсийг бэхжүүлэн авдаг.
- Нэвчүүлэх. Биологийн гаралтай шингэн мөр-бодисыг ариутгасан хуурай самбайнд шингээж авна. Хуурай, хатсан мөр-бодисыг нэрмэл усаар норгосон самбайгаар арчиж бэхжүүлнэ. Шингээж авсан болон арчиж авсан самбайгаа нарны гэрлийн тусгалгүй, цэвэр газар сайтар хатаана.
- Загварчлах. Бодит зүйлийн маш адил хэлбэртэй, хэмжээг нь тодорхой масштабаар багасгасан хуулбар нь түүний тухай мэдээлэл дутуу байгаа үед хэрэглэгдэх ба энэхүү дутуу байгаа зүйлийг дээр нь гүйцээн хийсэн моделийн тусламжтайгаар чухам юу, ямар үе шат, үйлдэл хаана нь дутуу байгааг гүйцээн «харах» боломж олгодог.<sup>18</sup> Бодит зүйлийн шинж чанар, шинж тэмдгийг хуулбарлан бий болгох арга. Ингэхдээ биет загвар үүнд: макет, дардас гэрэл зураг, математик загвар үүнд: юмсын шинж тэмдгийг математик аргаар дүрслэх, тэмдэглэх-ыг бий болгодог.

## МӨР БИТҮҮМЖЛЭХ АРГА ЗҮЙ

Мөр битүүмжлэх гэдэг нь мөрний нотлогооны ач холбогдлыг хангах, аливаа эрсдлээс сэргийлэх зорилгоор хамгаалахыг хэлнэ.

### Мөр битүүмжлэх үе нь дараах шаттай.

- Савлах. Мөрийг түүний шинж чанарт тохирсон зориулалтын болон ахуй хэрэглээний хайрцаг, сав, боодолд хийх бөгөөд зөв савлаагүйгээс болж мөр нотлогооны ач холбогдлоо алдах аюултай байдаг.
- Хаяглах. Мөрний төрөл, ангиллыг ялган таних, өөр хэргийн газраас илрүүлсэн мөртэй солихоос сэргийлэх, мөр зөөвөрлөх, хадгалах зэрэгт ашиглах зорилгоор мөрний сав дээр тэмдэглэл бичихийг ойлгоно. Дараах зүйлийг сав дээр тоочин бичнэ. а) мөр илрүүлсэн огноо, газар, б) хэргийн болсон байдал, в) мөрний төрөл, г) мөрний онцлог, д) тоо, ширхэг, е) мөр битүүмжилсэн албан тушаалтан, нэр, гарын үсэг, огноо, ё) мөр зөөвөрлөх явцад анхаарах таних тэмдэг (шүхэр, шилэн аяга, дээш харсан сум, аюултай бодис гэх мэтийг харуулсан зураг).

18 Б.Жаргалсайхан., Криминалитсикийн техник., УБ., 1998., 13 дахь тал.

- Лацдах. Мөрийг савнаас нь авах, солих, устгах зэргээс сэргийлэн тусгай тэмдэглээ хийх, савны амсар, тагийг бэхэлж, лац, ломбо тавина.

### **Зарим төрлийн мөр битүүмжлэх арга:**

- Биологийн гаралтай мөр-бодис. Мөр-бодистой харьцахдаа бүх үйлдлийг нэг удаагийн бээлий өмсөж хийнэ. Мөртэй ажилласан багаж, хэрэгслээ спирттэй хөвөнгөөр нэг чиглэлд сайтар арчаад, хуурай хөвөнгөөр арчиж цэвэрлэнэ. Энэ нь мөр-бодис багаж, хэрэгслээр зөөвөрлөгдөн өөр мөртэй холилдохоос сэргийлж буй үйлдэл юм. Илрүүлсэн мөр-бодисоо шингэн, хуурайгаар нь ялгана. Шингэн мөр-бодисыг хуруу шилэнд хийхээс гадна ариутгасан самбайнд шингээж аваад, хатаасны дараа цаасан уутанд хийнэ. Хатуу, хуурай мөр-бодисыг арчиж авсан самбайгаа (арчдас) хатаасны дараа цаасан уутанд хийнэ.
- Цусаар бохирлогдсон утаслаг эдлэл. Хувцас болон даавуу, бүрээс, хивс зэргийг салхигүй орчинд, тасалгааны хэмд хатаан, болгоомжтой эвхэн, 2 талд нь цоолсон цаасан хайрцганд хийнэ. Хэрхэвч гялгар уутанд хийж болохгүй!
- Галт зэвсэг. Эхлээд галт зэвсэгт хүрэлгүйгээр байлдааны байдалд байгаа эсэх, гарын мөр бий эсэхийг ажиглалтын аргаар тогтооно. Үүний дараагаар бээлийтэй гараар харьцаж, галт зэвсгийг аюулгүй болгоно. Дараа нь гол төмрийн сувгийг 2 талаас нь бөглөж, хатуу хайрцганд хөдөлгөөнгүй бэхлэнэ.
- Буудагдсан хүний хувцас. Цусыг хатаасны дараа, сумны хошууны гэмтэлтэй \орсон нүх\ хэсгийг 20x20 см-ийн хэмжээтэй цэвэр даавуугаар бүрж, бэхлэнэ. Үүний дараагаар 2 талд нь цоолсон цаасан хайрцганд хийнэ.
- Гарын мөр. Дакто хальсаар бэхжүүлсэн гарын мөрийг цаасан дугтуй, гялгар уутанд хийж болно.
- Гарын мөр бүхий мөр-эд. Хатуу хайрцганд хөдөлгөөгүй, хайрцагны гадаргуутай шүргэлцэхээргүй байхаар битүүмжлэнэ.
- Тэсрэх бодис, тэслэгээний хэрэгсэл. Төмөр чингэлгэд хийнэ. Таних тэмдэг, тайлбарыг сайтар бичнэ.
- Хорт бодис. Зориулалтын эсвэл битүүмжлэл сайтай саванд хийнэ. Таних тэмдэг, тайлбарыг сайтар бичнэ.

### **МӨР ЗӨӨВӨРЛӨХ АРГА ЗҮЙ**

Мөр зөөвөрлөх гэдэг нь мөрийг хэргийн газраас цагдаагийн байгууллагын мөр хадгалах өрөө болон шүүх-шинжилгээний байгууллагад аюулгүй хүргэх үйлдэл юм.

#### **Мөр зөөвөрлөхөд дараах зүйлийг анхаарвал зохино.**

- Бусдын халдлагаас сэргийлэн, хамгаалах.
- Өөр хэргийн мөртэй хольж, солихгүй байх.
- Зөөвөрлөх арга, тээврийн хэрэгслээ зөв сонгох.



- Мөрийг цагдаагийн байгууллага, эсвэл шүүх-шинжилгээний байгууллагад хүргэнэ.
- Тэсрэх бодис, хорт бодисыг цэргийн тусгай полигон, агуулах зэрэгт хүргэнэ.
- Мөрийг гэртээ авч очих, олон нийтийн газраар хэсүүчлэн авч явахаас аль болох зайлсхийх хэрэгтэй.
- Холын зайнд ъорон нутгаас нийслэл рүү мөр хүргэхдээ мөрний төрөл, улирал, зай, цаг агаар, хугацааг харгалзан тээврийн хэрэгсэл, хариуцах албан тушаалтанг сонгоно.

### **МӨР ШИНЖЛЭХ АРГА ЗҮЙ**

Мөр өөрөө шууд нотлох баримт болохгүй, харин шинжилгээ хийж байж нотлох баримт болох учиртай.

Гэмт хэргийг мөрдөж нотлох ажиллагаа буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд криминалистикийн шинжилгээ онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Криминалистикийн шинжилгээ гэж мөрдөгч, шүүхийн даалгавраар, эрүүгийн болон иргэний хэргийн болж өнгөрсөн бодит байдлыг тогтоох зорилгоор тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч, урьдчилан боловсруулсан аргачлалаар мөрийг нотлох баримт болгож буй техник-сэтгэхүйн үйл ажиллагаа.<sup>19</sup>

Криминалистикийн шинжилгээ нь хэрэгт холбоотой мөрийг шинжлэх, улмаар нотолгоог бий болгодог байцаан шийтгэх ажиллагааны онцгой хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийг криминалистикийн шинжилгээгүйгээр “мөрдөж нотлох” боломж огт үгүй. Харин гэмт хэргийг “залхаан байцааж” нотлоё гэвэл криминалистикийн шинжилгээ хийлгэх шаардлагагүй. Залхаан байцаах нь хүний эрхийг хамгийн бүдүүлгээр зөрчиж буй эрүү шүүлтгийн нэг хэлбэр.

Криминалистикийн шинжилгээний зорилт нь шинжээчээс асуусан асуулт байдаг ба шинжилгээний зорилт биелэх, эс биелэх нь асуултыг зөв, үндэслэлтэй асуух, шинжилгээг зөв аргачлалаар хийхээс ихээхэн хамаардаг.

#### **Шинжээчээс асуулт асуухад анхаарах зүйл:**

1. Тухайн хэргийн илрүүлэлт, нотолгоонд ач холбогдолтой байх.
2. Орчин үеийн шинжлэх ухааны хүрсэн түвшинд хариулах боломжтой байх.
3. Утга, найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаагүй байх.
4. Криминалистикийн нэр томъёог зөв хэрэглэсэн байх.

---

19 Б.Лхагвасүрэн., Криминалистикийн шинжилгээ судлал., УБ., 2010., 25 дахь тал.

## **МӨР АШИГЛАХ АРГА ЗҮЙ**

Мөр ашиглах гэдэг нь мөр илрүүлэх, мөшгөх, бэхжүүлэх, битүүмжлэх, зөөвөрлөх, шинжлэх ажиллагааны үр дүнг үндэслэн мөрдөгч, прокурор, шүүгч нараас байцаан шийтгэх ажиллагааны шийдвэр гаргаж буйг хэлнэ.

Хийсвэр, аман нотлох баримтыг чухалчлах бус харин мөр ашиглан шийдвэр гаргах нь хэргийг шуурхай, бүрэн бодитой, тал бүрээс нь тогтоох гэсэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт, зарчимыг илүүтэйгээр хангах болно.

Шинжилгээний эцсийн үр дүн болох шинжээчийн дүгнэлтийг мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч үнэлэхдээ 1-рт хууль зүйн, 2-рт шинжлэх ухааны, 3-рт техник шалгуурыг харгалзана.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 85-р зүйлийн 85.4-т заасан “Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүх заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал зохино” гэснийг ухаж ойлговол шинжээчийн дүгнэлтийг үнэлэхгүй байх үндэслэл нь ердөө л дор дурдсан 3 шалгуурын аль нэг үзүүлэлтийг хангаагүй байх тохиолдол юм.

### **Хууль зүйн шалгуур:**

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155 дугаар зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэслэл, журмыг баримтлах. Түүнчлэн тогтоол, захирамжийг баталгаажуулсан байгууллагын тамга, тэмдгийн дардас, шинжилгээ хийлгэхээр даалгасан албан тушаалтны гарын үсэг нь эх хувь байх ёстой. Мөн эрүүгийн, иргэний хэргийн дугаарыг заавал бичсэн байна.
2. Эрх бүхий албан тушаалтны даалгавраар шинжилгээ хийх. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн шинжилгээ хийнэ. Мөн төрийн эрх бүхий байгууллагын хүсэлтээр шинжилгээ хийх тухай Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан байдаг. Хувь хүн болон хэн нэгэн албан тушаалтны гуйснаар шинжилгээ хийхгүй.
3. Шинжилгээ хийх эрх мэдэл бүхий субъектийг шинжээчээр томилсон байх. Энэ нь криминалистикийн шинжилгээний онолын суурь болон тусгай мэдлэгтэй, туршлагатай этгээд юм.
4. Шинжээчид шинжилгээг хийхээс нь өмнө Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан эрх, үүргийг нь тайлбарлан өгч, Монгол Улсын Эрүүгийн хуулийн 254, 255-р зүйлд заасан хариуцлагыг сануулж, «Шинжилгээ хийлгэх тогтоол»-д гарын үсэг зуруулсан байх.
5. Шинжилгээний зүйлийн чухал бүрдэл болох харьцуулах загварыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 160 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулан шинжилгээнд хүргүүлсэн байх.



### **Шинжлэх ухааны шалгуур:**

1. Шинжээчээс асуусан асуултад орчин үеийн шинжлэх ухааны арга, хэрэгсэл хариулт өгөх боломжтой байх.
2. Шинжилгээнд хүргүүлсэн зүйлс шинжээчээс асуусан асуултад хариулт өгөхөд хангалттай, боломжтой байх.
3. Шинжээч өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийсэн байх.
4. Шинжилгээний аргачлал нь шинжлэх ухааны үндэстэй, найдвартай байхын зэрэгцээ баталгаажсан байх.
5. Шинжилгээ хийх тогтсон үе шатыг баримталсан байх.
6. Шинжилгээ хийх аргыг зөв сонгож, хослуулсан байх.
7. Шинжилгээнд шаардлагатай багаж, хэрэгслийг дүүрэн ашигласан байх.
8. Оношлогооны болон адилтгалын ач холбогдол бүхий шинж тэмдгүүдийн нийлбэр цогцыг үндэслэн дүгнэлтэд хүрсэн байх.

### **Техник шалгуур:**

1. Монгол хэл, шинжилгээ судлалын тогтсон нэр томъёог хэрэглэсэн байх.
2. Утга, найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаагүй байх.
3. Дүгнэлтийн хуудас бүрт шинжээч гарын үсэг зурж, хувийн тэмдгээр баталгаажуулсан байх.
4. Гэрэл зургийн үзүүлэлтэд тайлбар, хаяг, тэмдэглэгээ хийсэн байх. Жич: зарим төрлийн шинжилгээний гэрэл зургийн үзүүлэлтэд тэмдэглэгээ хийхгүй байх талаар стандарт тогтоох.

### **МӨР ХАДГАЛАХ АРГА ЗҮЙ**

Адилтган шинжлэх “харьцуулах загвар” тодорхой бус байгаа тохиолдолд мөрийг стандарт шалгуур хангасан байр, агуулахад тодорхой хугацаагаар байлгахыг ойлгоно.

Түүнчлэн эрүүгийн хэрэг эцэслэн шийдсний дараагаар зарим мөрийг биет байдлаар нь криминалистикийн сан, цуглуулгад бүртгэн авч, баяжилт хийн хадгалах шаардлага байдаг. Учир нь мөр судлах, бусад хэргийн газраас илрүүлсэн мөртэй адилтгах зэрэг онолын болоод практик ач холбогдолтой.

### **Ажилбар хийх:**

#### **Үйл ажиллагааны дараалал:**

Багш хичээлийн зорилго, явагдах дэс дарааллыг тайлбарласны дараа оюутнуудыг 1-5 хүртэл тоолуулж жижиг багуудад хуваана.

Баг бүр зохиомол хэргийн газар үүсгэнэ. Хэргийн газарт гарын мөр, хөлийн мөр, архины шил, хутга, тамхины иш зэрэг мөрүүдийг бэлтгэнэ.

Багуудад хэргийн газарт мөртэй ажиллахад шаардагдах техник хэрэгсэл, гарын мөр илрүүлэх нунтаг, өсгөгч шил зэргийг хуваарилан өгнө.

Багш эхлээд мөртэй ажиллаж харуулна. Үүний дараа багууд өөрсдийн үүсгэсэн зохиомол хэргийн газар ажиллаж, үүсгэсэн мөрөө илрүүлж, бэхжүүлж, битүүмжлэнэ.

Оюутнууд хэргийн газар мөртэй ажиллаж байх үед багш багууд дээр очин зөвлөгөө өгнө.

Мөртэй ажиллаж дууссаны дараа баг бүр илрүүлж, бэхжүүлж, битүүмжилсэн мөрөө багшид шалгуулан, мөртэй ажиллахад гарсан хүндрэл, бэрхшээлээ бусдадаа ярьж өгнө.

Эцэст нь багш тайлбар хийж, амьдрал дээр тохиолдсон алдаа, оноотой бодит жишээг ярина.



## СЭДЭВ 3. КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ ЗҮЙ

1. Шинжилгээ зүйн ойлголт
2. Шинжилгээний ангилал, төрөл, хэлбэр
3. Шинжээч ба мэргэжилтэн

1. Криминалистикийн буюу «шүүх- шинжилгээ зүй нь орчин үед өөрийн гэсэн онол, судлах зүйл, арга зүй бүхий бие даасан шинжлэх ухаан болсон»<sup>20</sup> гэж эрдэмтэн, судлаачид баталсан байдаг.

Криминалистикийн шинжилгээ зүй гэдэг нь хүн, байгаль, юмсын аливаа зүй тогтлын сургаалд үндэслэн мөрөнд шинжилгээ хийх онолын үндэс, зарчим, хэл, нийтлэг аргачлалыг боловсруулдаг мэдлэгийн цогц.

Хүн, байгаль, юмсын аливаа зүй тогтлыг шинжлэх ухааны тодорхой аргаар судалж танин мэдсэнээр гэмт үйлдлийн мөрнөөс хэргийн бодит үнэнийг тогтоох боломж гарч ирдэг. Жишээ нь, хүний гарын алга, хуруун дээр байх нарийн шугамны онцлог шинж хүн бүрт давтагдашгүй өөр, харьцангуй тогтвортой, нөхөн төлждөг, тэр нь мөр болон үлдэх чадвартай гэсэн зүй тогтлыг танин мэдсэнээр гарын мөрөнд шинжилгээ хийх аргачлалыг боловсруулж, улмаар түүнийг гэмт хэрэг илрүүлэх нотлох баримт гэж үзэх болсон байна.

Криминалистикийн шинжилгээ судлалын зорилго нь шинжилгээний нийтлэг аргачлалыг улам боловсронгуй, шинжлэх ухаанч болгох явдал юм. Ингэснээр амьдрал дээр бодитоор үйлдсэн хэргийн үнэн мөнийг илчлэн тогтоох шинжлэх ухааны үндэстэй нотлох баримт бий болно.

Криминалистикийн шинжилгээ судлалын судлах зүйл нь шинжилгээ хийхэд танин мэдэх зайлшгүй шаардлагатай бодит үнэний зүй тогтол болон гаж тогтлын цогц юм.

- Шинжилгээний онолын үндэс (Хүн, байгаль, юмсын аливаа зүй тогтол)
- Шинжилгээний зарчим
- Шинжилгээний хэл
- Шинжилгээний нийтлэг аргачлал
- Шинжилгээний субъект
- Шинжилгээний нийтлэг болон тусгай аргачлалд тулгамдаж буй асуудал
- Шинжлэх ухааны ололт амжилт, түүнийг криминалистикийн шинжилгээнд ашиглах боломж

20 Н.П.Майлис., Моя профессия-судебный эксперт., Москва., 2006., 10 дахь тал.

Шинжилгээний онолын үндэс. Суурь болон бусад шинжлэх ухааны нээж, танин мэдсэн хүн, байгаль, нийгмийн үзэгдлийн зүй тогтол нь шинжилгээний онолын үндэс байдаг.

Зүй тогтол гэдэг нь жам ёсны, логиктой байх гэсэн агуулгыг илэрхийлдэг байна. Мөр үүсэх зүй тогтол гэж мөр физик, хими, биологийн объектив үйлчлэлийн дүнд ердийн явцаар бий болох үзэгдэл, өөрчлөлт, хөдөлгөөний цогцыг хэлнэ.

Мөр, түүнийг бий болгосон үйлдлийн хооронд шалтгаант холбоо байдаг нь криминалистикийн шинжилгээний онолын нэг үндэс юм.

Шалтгаант холбоо гэдэг нь үйлдэл, түүний улмаас бий болсон мөр нь хоорондоо харилцан хамааралтай, нэг нэгнийхээ тухай мэдээллийг агуулж чадах шүтэлцээ.

2. Криминалистикийн шинжилгээ гэж мөрдөгч, шүүхийн даалгавраар, эрүүгийн болон иргэний хэргийн болж өнгөрсөн бодит байдлыг тогтоох зорилгоор тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч, урьдчилан боловсруулсан аргачлалаар мөрийг нотлох баримт болгож буй техник-сэтгэхүйн үйл ажиллагаа.

Криминалистикийн шинжилгээний ангилал, төрөл, хэлбэрийг зөв тодорхойлж, нэг мөр ойлгох нь онолын болон практик ач холбогдолтой юм. Тухайлбал: мөрдөгч, прокурор болон шүүгчээс ямар ангилал, төрөл, хэлбэрийн шинжилгээ хийлгэхээ зөв сонгох, шинжээчээс хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх асуулт асуух, мөн шинжлэх ухааны судлагааны явцад шинжилгээний шинэ төрөл, арга бий болоход тэдгээрийг боловсруулах, боловсон хүчнийг мэргэшүүлэн бэлтгэх зэрэгт ач холбогдолтой.

### **Криминалистикийн шинжилгээг шийдвэрлэж байгаа асуудлын агуулгаар нь:**

1. Оношлогооны шинжилгээ (диагностическая экспертиза),
2. Адилтгалын шинжилгээ (идентификационная экспертиза),
3. Нөхцөл байдлын шинжилгээ (ситуационная экспертиза)
4. Ангиллын шинжилгээ (классификационная экспертиза)<sup>21</sup> гэж ангилдаг.

### **Мөн зарим судлаачид:**

1. Оношлогоо ба нөхцөл байдлын шинжилгээ.
2. Адилтгал ба ангиллын шинжилгээ гэж ерөнхийд нь 2 ангилдаг.

---

21 А.И.Винберг., Н.Т.Малаховская., “Судебная экспертология”, Волгоград.г., 1979.г. Стр 155.



### **Шинжилгээний төрөл:**

- Хүний мөр судлалын шинжилгээ
- Тээврийн хэрэгслийн мөр судлалын шинжилгээ
- Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр судлалын шинжилгээ
- Материал судлалын шинжилгээ
- Үйлдвэрийн механизмын мөр судлалын шинжилгээ
- Даавуун эдлэлд үүссэн гэмтэл тогтоох шинжилгээ
- Галт зэвсэг судлалын шинжилгээ
- Тэсэлгээ судлалын шинжилгээ
- Бичиг судлалын шинжилгээ
- Бичиг баримт, үнэт цаас судлалын шинжилгээ
- Хүний дүр, төрх судлалын шинжилгээ
- Мал, амьтны мөр судлалын шинжилгээ
- Дуу авиа судлалын шинжилгээ
- Үнэр судлалын шинжилгээ
- Физикийн шинжилгээ
- Биологийн шинжилгээ
- Химийн шинжилгээ
- Шүүх-эмнэлгийн шинжилгээ
- Эдийн засгийн шинжилгээ
- Шүүх-сэтгэц судлалын шинжилгээ
- Авто-техникийн шинжилгээ
- Галын техникийн шинжилгээ
- Барилгын хийц, бүтээцийн шинжилгээ
- Хөдөө аж ахуйн шинжилгээ
- Хор судлалын шинжилгээ
- Шавьж судлалын шинжилгээ
- Компьютерийн шинжилгээ
- Бараа судлалын шинжилгээ
- Урлагийн зүйлд хийх шинжилгээ гэх мэт

Криминалистикийн шинжилгээ “дагнасан”<sup>22</sup> болон “хамтарсан”<sup>23</sup> гэсэн хэлбэртэй. Энэ нь байцаан шийтгэх ажиллагаатай илүү холбоотой ойлголт ба шинжилгээний төрөл, шинжээчийн мэргэшил, бүрэлдэхүүн болон шинжилгээний дамжлагыг харгалзсан явдал юм. Өөрөөр хэлбэл, шинжилгээний зорилго, шинжээчээс асуусан асуултаас хамаарч шинжилгээнд ирүүлсэн зүйлд дагнасан эсвэл хамтарсан шинжилгээ хийлгэхийг мөрдөгч, шүүгч, эсвэл шүүх-шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан шийдвэрлэдэг.

Дагнасан шинжилгээ гэж нэг төрлийн шинжилгээг нэг шинжээчид даалгасныг хэлнэ. Жишээ нь, гутлын улны мөрийг гутлын улны дардастай адилтгах, гарын мөрийг гарын дардастай адилтгах гэх мэт.

Хамтарсан шинжилгээ гэж нэг болон хэд хэдэн төрлийн шинжилгээг 2 ба түүнээс дээш тооны шинжээчид даалгасныг хэлнэ. Шийдэж байгаа асуудлын агуулгаар нь хамтарсан шинжилгээг:

- Хамтарсан нэг төрлийн шинжилгээ. Энэ нь шинжилгээний зүйлийг нэг чиглэлээр мэргэшсэн шинжээчид хамтарч шинжлэхийг хэлнэ. Жишээ нь, хуурамчаар үйлдсэн олон тооны баримт бичгийг бичиг-техникийн шинжилгээгээр мэргэшсэн хэд хэдэн шинжээч шинжилж болно.
- Хамтарсан иж бүрдэл шинжилгээ. Энэ нь шинжилгээний зүйлийг хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн шинжээчид зэрэгцэн шинжлэхийг хэлнэ. Нэг чиглэлээр гаргасан дүгнэлт нь нөгөө чиглэлийн дүгнэлттэй заавал нөхцөлдөх шаардлагагүй. Өөрөөр хэлбэл, тус тусдаа гаргасан дүгнэлт нь дангаараа нотлогооны ач холбогдолтой гэсэн үг. Жишээ нь, буудуулж нас барсан хүний хувцсанд биологийн, физикийн, галт зэвсэг судлалын, мөр судлалын зэрэг шинжилгээ хийлгэх шаардлагатай байдаг ба эдгээр шинжээчид зөвхөн өөрсдийн гаргасан дүгнэлтийн агуулгыг хариуцна.
- Хамтарсан цогц шинжилгээ. Энэ нь шинжилгээний зүйлийг хэд хэдэн чиглэлээр мэргэшсэн шинжээчид нэгдэж шинжлэх ба гаргасан дүгнэлтүүд нь нэг нэгэнтэйгээ нөхцөлдөнө. Өөрөөр хэлбэл, тус тусдаа дүгнэлт гаргах боломжгүй бөгөөд хийсэн шинжилгээ нь зөвхөн нэг асуудлыг шийдэхэд чиглэгдэнэ. Чиглэл чиглэлээр хийсэн шинжилгээ дангаараа дүгнэлтэд хүрэх боломжгүй, харин нэг нэгэнтэйгээ уялдаж байж нотолгооны ач холбогдолтой болно гэсэн үг. Жишээ нь, шүүх-эмнэлэг, физик, галт зэвсгийн шинжээчид хамтарч цогцсонд үүссэн шарх сумны хошуунаас үүссэн байна гэж дүгнэнэ.

22 Дагнах гэдэг үг “халаа солиогүй ганцаар хийх” гэсэн утгатай., Я.Цэвэл., Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 179 дэх тал.

23 Хамтрах гэдэг үг “нийлэх, нэгдэх, хамт болох” гэсэн утгатай., Я.Цэвэл., Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 656 дахь тал.



Дагнасан болон хамтарсан шинжилгээг анхны, нэмэлт, дахин, бүрэлдэхүүнтэй гэсэн дамжлагаар (шатлал) хийж болно.

Анхны шинжилгээ гэдэг нь шинжилгээний зүйлийг анх удаа буюу урьд нь ямар нэг байдлаар шинжилж байгаагүй зүйлийг шинжлэхийг хэлнэ. Анхны шинжилгээгээр шинжилгээний зүйл оношлол зүй болон адилтгалын шинжилгээнд тэнцэх, эсхүл тэнцэхгүй гэдгийг лавтай тогтоолгох ёстой.

Нэмэлт шинжилгээ гэдэг нь анхны шинжилгээгээр дутуу тогтоосон зүйлийг нэмж тогтоолгох, эсхүл шинэ нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хийлгэж буй шинжилгээ юм. Нэмэлт шинжилгээний мөн чанар нь анхны шинжилгээгээр тогтоосон зүйлийг үгүйсгэдэггүй, харин өөр асуудлыг нэмж тогтоож өгдөгт оршино. Энэ шинжилгээг анхны шинжилгээ хийсэн шинжээч хийж болно.

Дахин шинжилгээ. Анхны болон нэмэлт шинжилгээний үр дүнг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдоос хүлээн зөвшөөрөхгүй эсхүл эргэлзэж байгаа үндэслэлээ тодорхойлсон тохиолдолд дахин шинжилгээ хийлгэнэ. Энэ нь нэмэлт шинжилгээнээс өөр ойлголт ба анхны болон нэмэлт шинжилгээ хийсэн шинжээчээр хийлгэхгүй. Дахин шинжилгээний дүгнэлтийн агуулга анхны болон нэмэлт шинжилгээний дүгнэлтийн агуулгатай ижил байвал бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийлгэх шаардлагагүй.

Бүрэлдэхүүнтэй шинжилгээ. Анхны \нэмэлт\ болон давтан шинжилгээний дүгнэлтийн агуулга зөрүүтэй байгаа тохиолдолд туршлагатай шинжээчээр ахлуулсан, нэг төрлөөр мэргэшсэн хэд хэдэн шинжээчээр шинжилгээ хийлгэж буйг бүрэлдэхүүнтэй шинжилгээ гэнэ. Энэ хэлбэрийн шинжилгээний мөн чанар нь анхны болон дахин шинжилгээний аль нь шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв хийгдсэн болохыг тогтоох явдал юм. Бүрэлдэхүүнтэй шинжилгээгээр асуудлыг эцэслэн тогтоохын тулд анхны болон дахин шинжилгээгээр шинжилсэн зүйлс бүгдэд нарийвчлалтай, тал бүрээс хандах ёстой.

Бүрэлдэхүүнтэй шинжилгээ, хамтарсан шинжилгээ нь өнгөц харвал ижил мэт боловч агуулгын хувьд маш том ялгаатай ойлголтууд билээ. Тухайлбал, хамтарсан шинжилгээг анхны удаа хийж болдог бол бүрэлдэхүүнтэй шинжилгээг анхны удаа хийнэ гэсэн ойлголт байхгүй. Бүрэлдэхүүнтэй шинжилгээгээр мөрийг анх удаа шинжилж байгаа биш, харин урьд нь уг мөрөнд хийсэн анхны болон давтан шинжилгээний аль нь чухам шинжлэх ухааны үндэстэй байсныг тогтоодог.

3. Шинжлэх ухаан, нийгмийн бараг бүх салбарт шинжээч байдаг. Эдгээр нь бүгд л тухайн салбартаа мэргэшсэн, туршлагатай хүмүүс юм. Шинжээч гэдэг нь “expertus”-туршлагатай, дадлагатай, хашир хүн гэсэн латин үгнээс үүсэлтэй<sup>24</sup>. (Шинжээч-шинжийг мэддэг, туршлагатай хүн) Шинжээч гэж хэн бэ гэдэг талаар онол, эрх зүйн

24 Юридический энциклопедический словарь., 1984., Москва., 410 дахь тал.

эх сурвалжуудад янз бүрийн агуулгаар тодорхойлсон байдаг бөгөөд эдгээр нь угтаа нэг л ойлголт. Эдгээрийг нэгтгэвэл: Шинжээч гэдэг нь тусгай мэдлэг эзэмшсэн, тухайн мэдлэгийн салбартаа мэргэшсэн, судлан шинжилж буй зүйлийнхээ талаар нэвтэрхий мэддэг, туршлагатай хүн гэж ойлгож болно.

ОХУ-ын криминалист эрдэмтэн Н.П.Майлис: “Криминалистикийн шинжээч гэдэг нь шинжилгээний онол, аргачлал, дадлын тусгай мэдлэгийг эзэмшсэн, шинжлэх ухаан, практикийн үйл ажиллагааг сайн мэдэх туршлага, мэдлэгтэй хүн”<sup>25</sup> гэж тодорхойлжээ.

Шинжээч гэсэн үгийн үндэс нь “шинж” гэдэг үг ба шинж гэсэн үгээр эхэлсэн “шинжлэх ухаан”, “шинжилгээ”, “шинж тэмдэг” гэсэн ойлголтууд байдаг. Эдгээр ойлголтууд нь санамсаргүй тохиолдол биш юм. Аливаа зүйлд шинжлэх ухаанч аргачлалаар шинжилгээ хийж, тухайн зүйлээс илэрсэн шинж тэмдэгт үндэслэн дүгнэлт гаргадаг.

Монголчууд нэр үгэнд “чин” дагавар залгаж эзэн биеийг үүсгэдэг. Жишээ нь, мал сайн мэддэг хүнийг малчин, барилга сайн мэддэг хүнийг барилгачин, адуу сайн мэддэг хүнийг адуучин гэх мэт. Мөн зарим үгэнд “чин” биш сунжирсаар “ч”-г залгадаг. Тухайлбал, эм сайн мэддэг хүнийг эмч, жолоо сайн мэддэг хүнийг жолооч, мөр сайн мэддэг хүнийг мөрч гэхчилэн хэлдэг. Үүний адилаар юмсын шинжийг сайн мэддэг хүнийг шинжээч гэдэг. Зүй нь шинжээч хүн шинжлэх ухаанаар боловсруулсан шинжилгээний аргачлалаар шинжилж буй зүйлийнхээ шинж тэмдгийг илрүүлэн, уг шинж тэмдэг бий болсон бодит зүй тогтлыг тусгай мэдлэгээ ашиглан үнэлж, дүгнэлт гаргах учиртай.

Хэн нэгэнд хэд хэдэн зүйлийг хооронд нь адилтгах аргачлалыг заан өгч, тэр нь зааж өгсөн аргачлалын дагуу адилтгал хийж чадах боловч, шинж тэмдэг бий болох зүй тогтлыг мэдэхгүй. Энэ хүн бол шинжээч биш.

Харин шинжээч нь шинж тэмдэг бий болох, хадгалагдах, өөрчлөгдөх зүй тогтол, шинж тэмдгийн тоон болон чанарын ач холбогдлыг үнэлж чадах мэдлэг, чадвар, дадлагыг эзэмшсэн байдаг ба түүнийг тусгай мэдлэг гэнэ.

Тусгай мэдлэг нь тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшиж мэргэшсэн, эсхүл олон жилийн ажил, амьдрал туршлага, сонирхлоор олж авсан нийтлэг бус шинжтэй байна.

Тусгай мэдлэг эзэмшиж, олж авсан байдлыг харгалзан:

- Албан ёсны тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч,
- Албан бус тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч гэж ангилна.

Албан ёсны тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч дараах шинжийг агуулна.

---

25 Майлис.Н.П., Моя профессия-судебный эксперт., Москва., 2006.,



1. Тусгай мэдлэг ба мэргэжил олгох сургалтын байгууллагад сурсан, (Төрийн эрх бүхий байгууллага магадлан итгэмжилсэн байна.)
2. Шинжилгээний онол, аргачлалыг сургалтын стандарт, төлөвлөгөөний дагуу танхимийн хичээл, дадлагын сургалтаар эзэмшсэн,
3. Тусгай мэдлэгээ төгсөлтийн шалгалтаар баталгаажуулсан, эсхүл дипломын ажил хамгаалж мэргэшсэн байх.

Албан ёсны тусгай мэдлэг нь дээрх шалгуурыг хангаснаар зогсохгүй, байнгын хичээл зүтгэл, туршлагыг шаардаж байдаг.

Албан бус тусгай мэдлэг эзэмшсэн шинжээч дараах шинжийг агуулна.

1. Ажил, амьдрлын туршид, эсхүл сонирхлоор тусгай мэдлэгийг олсон,
2. Уг мэдлэг нь олон жилийн дүнд хуримтлагдаж туршлага болсон.

Төрийн байгууллагад ажиллаж буй шинжээчийг мэргэшил, туршлага, ажилласан жил, боловсролын зэрэг, ёс зүйг нь харгалзан дараах албан тушаалд томилдог.

- Шинжээч
- Ахлах шинжээч
- Тэргүүлэх шинжээч

Практикт “мэргэшсэн шинжээч” гэсэн албан тушаал байдаг. Энэ нь оновчгүй нэр оноолт ба угтаа тусгай мэдлэг эзэмшиж, мэргэшсэн хүн шинжээч болдог. Мэргэшсэн байна гэдэг нь шинжээчийн гол шалгуур юм. Жишээ нь, шүүх-эмч бол хүний их эмчийн бакалавр зэрэгтэй, түүнчлэн эмгэг патанатомийн чиглэлээр резентурт суралцаж мэргэшсэн байх ёстой байдаг. Үүний адилаар шүүх-нягтлан бодогч нь мэргэшсэн нягтлан бодогч байх ёстой.

Шинжээч нь эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаа болох үзлэг, нэгжлэг, загвар авах зэрэгт мөрдөгчийн урилгаар оролцож байгааг мэргэжилтэн гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, шинжээч тусгай мэдлэгээ ашиглан мөрдөгчид мэргэжилтний хувьд туслаж байгаа явдал юм.

**ХЯНАЛТЫН АСУУЛТ:**

1. Криминалистикийн шинжилгээний ойлголтын талаар ярина уу?
2. Ямар тохиолдолд шинжилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай вэ?
3. Ямар субъект, ямар хуулийн дагуу шинжилгээ хийлгэх эрхтэй байдаг вэ?
4. Шүүх-шинжилгээг хэн хийдэг вэ? Мөрдөн байцаагч шинжилгээ хийж болох уу?
5. Шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд ямар шалгуурыг харгалзах ёстой вэ?
6. Шинжээчийн дүгнэлт нотлох баримт мөн үү?

**Бодлого**

Хэргийн газар дээрх байдал: Үдэш 23.00 цагийн үед замын цагдаагийн үзлэгийн баг “-машинд мөргүүлсэн хүн байна” гэсэн дуудлагаар очив. Хэргийн газарт нэг эрэгтэй хүн нас барсан байх ба Тоёота маркын жиип автомашин, 55 орчим хижээл насны эрэгтэй, 25 орчим насны залуу уг автомашин дотор байх ажээ. Тэр 2 эцэг, хүү байв.

Анхны сэжиг, таамаг, тогтоогдсон байдал: Тэд мэдүүлэхдээ: Эцэг нь, - автомашин жолоодож явахад өөдөөс ирэх машин их гэрлээ асаасан байсан. Тэгээд гэрэлд цохиулан тухайн үед юу ч харагдахгүй болсон. Урдуур зам хөндлөн гарах гээд зогсож байсан хүнийг огт хараагүй гэжээ. Харин хүү нь, -би арын суудал дээр унтаад явж байсан. Нэг мэдэхэд түс тас хийх чимээ гараад замын хажууд гарчихсан зогсож байсан гэв. Ийм агуулгатай мэдүүлгийг тэд дараа, дараагийн байцаалтад өгч байлаа.

Хэргийн бодит үнэн: Автомашиныг хүү жолоодож байсан ба эцэг нь жолоочийн хажууд сууж явсан байна. Эцэг нь хүүгээ шоронд оруулахгүйн тулд өмнөөс нь хэргийг хүлээхээр хүүтэйгээ хуйвалдсан байжээ.

**Асуулт:**

1. Энэ хэргийн бодит үнэнийг тогтооход хаанаас ямар мөр илрүүлж, бэхжүүлэх вэ?
2. Илрүүлж, бэхжүүлсэн мөрүүдэд ямар, ямар төрлийн шинжилгээ хийлгэснээр уг гэмт хэргийг бодитойгоор шийдвэрлэх боломжтой вэ?



## СЭДЭВ 4. ХҮНИЙ МӨР СУДЛАЛ

1. Хүний мөр судлалын ойлголт, мөрний ангилал, төрөл
2. Хөлийн мөр судлал
3. Гарын мөр судлал

1. Гэмт хэргийг хүн үйлддэг учраас хэргийн газарт хүний мөр хамгийн түгээмэл үлдэх магадлалтай юм. Иймээс криминалистикт хүний мөр судлал томоохон байр суурь эзэлдэг. Мөн хүний мөр судлалын судлагдахуун болох хөлийн мөр судлал, гарын мөр судлал нь биеэ даан салбарлан хөгжсөөр байна.

Хүний мөр судлал гэдэг нь хүнээс үүсч болох мөрний нийтлэг зүй тогтлыг судалж, хүний мөртэй ажиллах арга зүйг боловсруулдаг криминалистикийн техник зүйн салбар юм.

Уламжлалт криминалистикт хүнээс үүсэх мөр-дүрсийг түлхүү судалдаг байсан бол шинжлэх ухааны мэдлэгийн ялгарах ба нэгдэх процесс чанарын өөр шинжтэй болсон орчин үед хүний мөр-бодис, хүний эдлэлийн мөр-эд зүйлийг шинжлэх ухааны олон салбарын мэдлэгийг ашиглан судалж байна.

Хүнээс үүсэх мөрийг “хүний өөрийн”, “хүний эдлэлийн” гэж ангилдаг.

Хүний өөрийн мөр гэдэг нь эхээс заяасан биенээс үүсч байгаа өөрчлөлт, хөдөлгөөн юм. Иймд хүний биеэс зөвхөн мөр-дүрс, мөр-бодис бий болдог.

### **Хүний өөрийн мөр-дүрс:**

- Нүцгэн хөлийн мөр
- Гарын мөр
- Шүдний мөр
- Уруулын мөр
- Чихний мөр
- Өвдөг, тохойны мөр
- Хумсны мөр
- Биеийн бусад хэсгийн мөр гэх мэт

## **Хүний өөрийн мөр-бодис:**

- Үнэр
- Шүлс
- Нус
- Цус
- Үрийн шингэн, салай
- Ялгадас
- Хөлс
- Үс гэх мэт.

Хүний эдлэлийн мөр гэдэг нь хүний өдөр тутмын зан үйлд зайлшгүй шаардлагатай байдаг эдлэлээс үүсч байгаа өөрчлөлт, хөдөлгөөн юм.

## **Хүний эдлэлийн мөр-дүрс:**

- Гутлын улны мөр
- Оймстой хөлийн мөр
- Бээлийний мөр
- Таяг, хиймэл эрхтний мөр
- Утаслаг эдлэлийн нэхээс, сүлжмэлийн мөр гэх мэт.

## **Хүний эдлэлийн мөр-эд:**

- Гутал, өсгий, тах, үдээс
- Хувцас, малгай, эдгээрийн тасархай хэсэг
- Ам, хамар, хөлсний алчуур
- Нүдний шил
- Ээмэг, бөгж, зүүлт
- Асаагуур, чүдэнз гэх мэт.

## **Хүний эдлэлийн мөр-бодис:**

- Хувцасны будаг
- Хүний эдлэлийн үнэр
- Сэмэрдэс гэх мэт.

2. Хөлийн мөр судлал. Хэргийн орон зай, түүний орчинд хүний хөлийн үзэгдэх, бүдэг үзэгдэх, үл үзэгдэх мөр үүсэх нь зайлшгүй байдаг. Хэргийн газарт үзлэг хийж, мөр эрэхдээ хамгийн түрүүнд хөлийн мөрийг илрүүлж, бэхжүүлэх ёстой.



Ингэснээр хэргийн газарт үзлэг хийх маршрут, чиглэлээ тогтооно.

Хөлийн мөрөнд үзлэг, шинжилгээ хийснээр гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах, илрүүлэх, гэмт үйлдлийн дараалал зэрэг хэргийн нотолгоонд ач холбогдолтой олон асуудлыг тогтоодог. Энэ нь хүний хөлийн тавхайн анатоми, морфологийн онцлог, гутлын бүтэц, улны онцлог, алхах, гүйх зуршил гэсэн шинжүүдээр тогтоогдоно.

Хөлийн мөр судлал гэдэг нь хөлийн мөр үүсэх зүй тогтлыг судалж, хөлийн мөртэй ажиллах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

Хөлийн мөр үүсэх зүй тогтлыг анатоми, морфологи, антропологи, антропометр зэрэг мэдлэг ашиглан судалдаг.

Хөлийн мөрийг дараах шалгуураар төрөлжүүлдэг.

#### **Үүсгэсэн үйл хөдлөлөөр нь:**

- алхсан, гүйсэн, харайсан, гулгасан.

#### **Үүсгэгчээр нь:**

- нүцгэн хөлийн, оймстой хөлийн, гутлын улны.


#### **Хөлийн мөрөнд хийх хэмжилт**



*Зураг №1. Нүцгэн хөлийн мөрөнд хийх хэмжилт.*


- 1. Тавхайн урт, 2. Өлтийн өргөн,*
- 3. Нутын өргөн, 4. Өсгийн өргөн.*

Гутлын улны мөр: ерөнхий шинж тэмдэгт ул, түүний хэсгийн хэмжээс, хэлбэр, улны хийц, хээний зураглал, ул-өсгийний бүтэц, ул бэхэлсэн арга, хадаасны эгнээ, тоо, үйлдвэрийн тэмдэг, бичээс, размерын заалт, хувийн онцлог шинж тэмдэгт уланд үүссэн гэмтэл, сэтэрхий, элэгдэл тэдгээрийн хэлбэр, хэмжээ, харилцан байрлал, тах, хадаасны байрлал зэрэг хамаарна.



Зураг №2. Гутлын уланд хийх хэлжилт.

AB-улны нийт урт, DE-өллийн өргөн, GH-нулын өргөн, IJ-өсгийн өргөн, AC-өллийн урт, CF-нулын урт, FB-өсгийн урт.



Зураг №3. Хөлийн цуваа төрний элементүүд.

AB-цуваа төрний голч шугал, CD, EF, GH-зүүн алхамын урт, DE, FG-баруун алхамын урт, SE-баруун алхааны урт, DF-зүүн алхааны урт. (2 алхам = 1 алхаа), c-алхамын өргөн



Хөлийн мөр илрүүлэх: Үзэгдэх гүн мөрийг энгийн ажиглалтын аргаар илрүүлэх боломжтой. Харин бүдэг, үл үзэгдэх өнгөц мөрийг төрөл бүрийн гэрлийн долион гаргах хэрэгсэл ашиглан илрүүлдэг.

Хөлийн мөр бэхжүүлэх: Ямар ч байдлаар үүссэн хөлийн мөрийг хэмжихүйн гэрэл зургаар бэхжүүлсний дараа гүн мөрийг хэв (гипс) цутгах, өнгөц мөрийг хуулбар (наалдамхай тууз) авах аргаар батжуулж бэхжүүлнэ.

### **Хөлийн мөрөнд шинжилгээ хийснээр дараах байдал тогтоогдоно:**

- Хүний анатоми шинж: нас, хүйс, биеийн галбир, чац, жин, согог.
- Үйл хөдлөлийн шинж: алхамын онцлог, зогссон гүйсэн үйлдэл, согтуу, хэвийн бус байдал.
- Сэтгэл зүйн шинж: тайван эсвэл ядарч тэвдсэн, айж цочирдсон, болгоомжилсон байдал.
- Нийгмийн шинж: өмсөж буй гутлын үнэ, хэлбэр хийц нь гэмт хэрэгтэн нийгмийн аль давхаргад хамаарагдахыг илэрхийлэх байдал.
- Хэргийн нөхцөл байдал: гэмт хэрэгтний тоо, тэдний объектог ажил байдал, явсан ирсэн чиглэл, гэмт хэргийн газар дээрх үйлдэл хөдөлгөөн, дараалал, цаг хугацаа, хэд хэдэн гэмт хэргийг нэг, эсвэл бүлэг хүмүүс үйлдсэн эсэх,
- Мөр үүсгэгчийг: хэргийн газраас илрүүлсэн хөлийн мөрийг сэжигтэн этгээдээс хураан авсан гуталтай харьцуулах.

3. Гарын мөр судлал. Хүний гарын алга, хуруу, өндөгний арьсанд дээш өргөгдөн өгнэсэн хөлсний сүв (папилляр шугам)-ний зураглал дахин давтагдашгүй, харьцангуй тогтвортой, нөхөн төлждөг шинж чанарыг XIX зууны үеэс шинжлэх ухааны хувьд тогтоосноор гарын хээг гэмт хэрэг илрүүлэх, нотлоход ашиглахаас гадна иргэний бүртгэл, цахим цоож зэрэгт хүртэл үр дүнтэйгээр ашигласаар байна.

Гарын мөр гэдэг нь гарын алга, хуруунд байх хөлсний сүвнээс ялгарч буй хөлс (тос) ямар нэгэн зүйлтэй харьцах үед папилляр шугамны зураглалын дагуу хуулбарлагдан үлдсэнийг хэлнэ.

Гарын дардас гэдэг нь хэргийн газраас илрүүлсэн гарын мөртэй харьцуулах, эсвэл хүнийг эрүүгийн болон иргэний бүртгэлд бүртгэх зорилгоор тусгай техник, арга зүйгээр гарын хээг нь хуулбарлан авсныг ойлгоно.

Гарын мөрийг гарын дардастай адилтгахдаа нэгдүгээрт: хээний ерөнхий шинжээр нь адилтгалын хүрээг тодорхойлж, хоёрдугаарт: хувийн шинж тэмдгээр харьцуулан адилтгалын зорилгыг хангадаг.

Гарын хээний ерөнхий шинж тэмдэг – Хурууны өндгөн хэсгийн хээг папилляр шугам, гурвалсан уулзварын (дельта) бүтцээр нь нум, гогцоо, дугуй гэж үндсэн 3 бүлэгт ангилах ба үүнийг гарын хээний ерөнхий шинж тэмдэг гэдэг.

Нуман хээ – Хээний төв нумарсан байх ба хээний урсгалууд гурвалсан уулзвар буюу дельта үүсгэдэггүй.




*Зураг №4.*

Гогцоо хээ – Хээний төв хэсэгт гогцоорсон урсгал байх ба дээд, доод, төвийн урсгалууд уулзан 1 дельта үүсгэсэн байна. Гогцооны хөл нь \төгсгөл\ эрхий хурууны зүгт хандсан байвал радиал буюу эрхийн гогцоо, чигчий хурууны зүгт хандсан байвал ульнар буюу чигчийн гогцоо гэнэ.




*Зураг №5.*

Дугуй хээ – Хээний төв хэсэгт дугуйрсан урсгал байх ба дээд, доод, төвийн урсгалууд уулзан 2 дельта үүсгэнэ. Дугуй хээ нь зууван, мушгаа, зуузай хэлбэрээр зөрж мушигсан эргүүлэг гэх мэт хэлбэртэй байдаг.



*Зураг №6.*

Папилляр шугам нь эхлэл, төгсгөл, тасралт, нийлэлт, салаалалт, мурий, эгц, өнцөг, цэг, хэсэг, гүүр, нүд, арал, дэгээ зэрэг онцлогтой ба түүнийг гарын хээний хувийн шинж тэмдэг гэдэг.



*Зураг №7.*

Гарын мөр илрүүлэх – Хүний гар хүрсэн байж болох зүйл дээрээс энгийн, физикийн, химийн аргаар гарын мөрийг хайж, ил болгоно.

Гарын мөр бэхжүүлэх – Криминалистикийн гэрэл зураг, тодорхойлон бичих, хуулбар авах, хэв авах аргаар гарын мөрийг батжуулна. Мөн мөр тээж буй зүйлийг биет байдлаар нь тусгаарлаж авах аргыг хэрэглэнэ.

**Гарын мөрөнд хийх шинжилгээгээр:**

- Гарын мөр харьцуудах шинжилгээнд тэнцэх эсэх,
- Хохирогчийн гарын дардастай тохирох эсэх,

- Сэжигтний гарын дардастай тохирох эсэх,
- Санд байгаа гарын дардас, эзэнгүй хэргийн мөртэй тохирох эсэх,
- Хэд хэдэн хэргийн газраас бэхжүүлж авсан гарын мөр нь нэг хүнийхүү, өөр өөр хүнийх үү зэрэг асуудлыг тогтооно.

### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Хүний мөрийг судлахын ач холбогдол юу вэ?
2. Хүний мөрийг хэрхэн ангилдаг вэ?
3. Хүнээс ямар ямар мөр үүсдэг вэ?
4. Хөлийн мөрөөр уг хүний биеийн чац тогтоох ямар томъёо байдаг вэ? Улны урт нь 28 см өвлийн гутлын мөрөөр уг хүний өндрийг тогтоо.
5. Гэмт хэрэг илрүүлэх, нотлоход хөлийн мөрийг хэрхэн ашиглах вэ?
6. Архины шилэн дээрээс гарын мөрийг ямар арга, хэрэгслээр илрүүлж, бэхжүүлдэг вэ?
7. Гэмт хэрэг илрүүлэх, нотлоход гарын мөрийг хэрхэн ашиглах вэ?

### Ажилбар хийх:

Бэлтгэх зүйл: Гарын мөр илрүүлэх нунтаг, багс, бичгийн цаас, хайч, наалдамхай тууз, бал, дугтуй.

Гарын мөр бүхий зүйлс: Лонх, лааз, толь, хуванцар сав, шил, мод, аяга, төмөр гэх мэт.

Гүйцэтгэл: Оюутан бүр гарын мөр бүхий зүйлсээс гарын мөр илрүүлж, бэхжүүлнэ. Илрүүлсэн гарын мөрний шинж тэмдгийг тодорхойлон бичиж, шинжилгээ хийлгэх тогтоол үйлдэнэ.



## СЭДЭВ 5. ХҮНИЙ ДҮР, ТӨРХ СУДЛАЛ

1. Хүний дүр, төрх судлалын ойлголт, хүний дүр, төрхийн шинж тэмдэг
2. Хүний дүр, төрх судлалаар шийдвэрлэх асуудал

1. Хүний дүр, төрх судлал. Хүний биеийн гадаад бие эрхтний бүтэц, хэлбэр янз бүрээр дүрслэгдэх анатоми, морфологи, физиологийн зүй тогтлыг судалж, бие хүний тухай мэдээлэл цуглуулах, шинжлэх, ашиглах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

### Дүр-царай, овор

Төрх-биеийн хэв, маяг, хэлбэр, галбир.

Хүний дүр, төрх дүрслэгдэх зүй тогтолц:

- a) Дүр, төрх бүрэлдэх: 0-16 насанд,
- b) Дүр, төрх төлөвших: амьдралын тодорхой хугацаанд тогтвортой байх,
- c) Дүр, төрх өөрчлөгдөх: насжих, өвчин, гэмтэл, мэс ажилбар зэргээс хамаарна.

### Гадаад дүр, төрхийн анатоми шинж

- Хүйс: Эрэгтэй, эмэгтэй. Мөн эр төрхтэй эмэгтэй, эм төрхтэй эрэгтэй хүн байж болно. Зориуд эсрэг хүйсний дүрд хувирах, мэс ажилбараар хүйс солиулах тохиолдол бий.
- Нас: Физиологийн ба бичиг баримт бүртгэлийн нас гэсэн ойлголт байдаг.
- Үндэстэн: Хүн төрөлхтөнг антропологи хэв шинжээр нь монголоид, европеид, негроид гэж хуваадаг.
- Биеийн галбир: Гадна бие эрхтний хэлбэр, өөхлөгийн түвшин бөгөөд хэт туранхай, туранхай, хэвийн, тарган, хэт тарган гэж ангилна.
- Бие бялдарын хөгжилт: Яс, булчингийн хөгжлөөр илэрхийлэгдэнэ. Сулбагар, чийрэг, булчинлаг, ясархаг гэж ангилна.
- Биеийн чац: Хүнийг бие болон эрхтний хэмжээгээр нь намхан, хэвийн (эрэгтэй 165 см), өндөр чацтай гэж ангилдаг. Мөн урт гар, хөлтэй, өргөн цээжтэй хүмүүс бий.
- Биеийн онцлог: Биеийн өвөрмөц байдлыг илэрхийлэх шинж тэмдэг. Тухайлбал, доголлон, бөгөтөр, хиймэл эрхтэнтэй гэх мэт.
- Толгойн элемент: Толгой, үс, нүүр, дух, хөмсөг, нүд, хамар, ам, уруул, шүд, эрүү, чих, хүзүү зэргийг байрлал, хэлбэр, хэмжээ, гаднах дүрс, өнгө, тэгш хэм, онцлог гэсэн шалгуураар авч үздэг.

## Гадаад дүр, төрхийн үйл хөдлөлийн шинж:

- Биеийн хэв маяг: Бие толгойн хэвшсэн байрлал.
- Биеийн хэлэмж: (bodylanguage) Бодол, санаагаа биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэхийг хэлнэ.
- Биеийн хэвшсэн хөдөлгөөн: Алхах, гүйх, зогсох үед илрэх биеийн цогц хөдөлгөөн.
- Алхаа: Явдлын шинж тэмдэг.
- Нүүрний хэлэмж: Сэтгэл хөдлөл, хүслээ илэрхийлэх нүүрний булчингийн хөдөлгөөн.
- Уруулын өгүүлэмж: Авиа үүсгэх үе дэх уруулын хөдөлгөөн, хэлбэр.
- Хурууны хэлэмж: Хурууны дохилтоор ярилцах арга.
- Зуршил: Орчинтой харьцах, тодорхой үйлдэл хийх үед илрэх байнга давтагдах хөдөлгөөн.
- Дадал: тодорхой ажил, үйлдэл хийх дадлага, ур дүй.
- Ярианы хам хөдөлгөөн: Ярих үе дэх гар, толгой, мөрийн дагалдах хөдөлгөөн.
- Үнэр: Биеээс ялгарах тогтвортой үнэр. Мөн дагалдах үнэр гэж бий.

Хүний дагалдах шинж. Энэ нь хүний тогтмол эдлэх хувцас, хэрэглэл, гоёл чимэглэл бөгөөд анатоми, үйл хөдлөлийн шинжийг тодотгож байдаг.

- Үйлдвэрлэлийн шинж: Зориулалт, загвар, хийц, материал, чанар, өнгө, хэмжээ, өмсгөл, онцлог зэргээр илэрхийлэгдэнэ.
- Эдэлгээний шинж: Ханзралт, цооролт, бохирдсон, үрчийсэн, өнгөө алдсан, гажсан, агшсан, сунасан, загвар хуучирсан зэрэг эдэлгээний явцад бий болдог шинжүүд юм.

2. Хүний дүр төрх судлал нь аман зураг гаргах, зургийг бие хүнтэй адилтгах, гавлын ясыг сэргээх зорилгоор хүний анатоми, үйл хөдлөл, дагалдах шинж тэмдгийг судалж, шинжилгээ хийх арга зүйг боловсруулдаг.

## Дараах асуудлыг шийдвэрлэнэ:

- Гэрч, хохирогчийн ой ухаанд хадгалагдсан гэмт этгээдийн дүр, төрхийг системтэйгээр сэргээн мэдүүлэг авах. Дараа нь аман зураг гаргаж, тодорхой этгээдүүдийг сэжиглэн баривчилсан тохиолдолд гэрч, хохирогчоор таниулах процессын ажиллагаа явуулна.
- Анх удаа эрэн сурвалжлагдаж байгаа болон оргон зугтсан этгээдийн дүр, төрхийг тодорхойлон бичиж эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулах. Хүний дүр, төрхийн шинж тэмдгийг эрүүгийн процессын үед хаана ч адил утгаар ойлгож, хэрэглэх ёстой. Ингэж байж эрэн сурвалжлах ажиллагаа амжилттай болно.



- Аман зураг гаргах шинжилгээ. Хүний ой санаанд хадгалдагдсан субъектив дүрийг бодит дүрс болгож буй үйл ажиллагаа юм. Ингэхдээ гараар зурах, зураг эвлүүлэх, компьютерын программ ашигладаг.
- Зургийг хүн, зурагтай адилтгах шинжилгээ. Хэрэгт холбоотой гэрэл зураг дээрх хүнийг бие хүн болон зурагтай адилтгаж, нэг хүн мөн эсэхийг тогтооно.
- Дүрс бичлэгийг оношлох, хүн, зурагтай адилтгах шинжилгээ. Хэрэгт холбоотой дүрс бичлэг дээрх хүнийг бие хүн, дүрс бичлэг болон зурагтай адилтгаж, нэг хүн мөн эсэхийг тогтооно. Мөн оношлогооны шинжилгээгээр хүний анатоми, үйл хөдлөлийн шинжийг тогтооно.
- Гавлын ясыг зурагтай адилтгах, сэргээх шинжилгээ. Хэн болох нь мэдэгдэхгүй хүний араг ясны гавлыг ор сураггүй алга болсон гэж тооцогдсон хүмүүсийн гэрэл зурагтай адилтгах, мөн адилтгах зураг байхгүй үед түүний дүрийг сэргээн тогтооно.

### **Ажилбар хийх**

**Бэлтгэх зүйлс:** Зургийн хэрэгсэл (балын харандаа, баллуур, үзүүрлэгч гэх мэт).

**Гүйцэтгэл:** Оюутан бүр давхцахгүйгээр олны танил нэг хүний гадаад дүр, төрхийн анатоми, үйл хөдлөл, дагалдах шинжийг тодорхойлон бичнэ. Үүний дараа тухайн хүнийхээ хөрөг зургийг зурна.

## СЭДЭВ 6. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МӨР СУДЛАЛ

1. Тээврийн хэрэгслийн мөр судлалын ойлголт
2. Тээврийн хэрэгслээс үүсэх мөр
3. Тээврийн хэрэгслийн мөртэй ажиллах арга зүй, шийдвэрлэх асуудал

1. Тээврийн хэрэгсэл нь гэмт хэргийн халдлагын зүйл болохоос гадна гэмт хэрэг үйлдэхэд ашиглах хэрэгсэл болдог тул криминалистикт тээврийн хэрэгслийн мөрийг судлах зайлшгүй шаардлага бий болжээ.

Тээврийн хэрэгслийн мөр судлал гэдэг нь тээврийн хэрэгслээс үүсэх мөрний нийтлэг зүй тогтлыг судалж, тээврийн хэрэгслийн мөртэй ажиллах арга зүйг боловсруулдаг трасологийн салбар юм.

Тээврийн хэрэгслийн мөр судлал нь ихэвчлэн газраар явдаг тээврийн хэрэгслийн мөрийг судалдаг ба зарим тохиолдолд агаарын, усан, төмөр замын тээврийн хэрэгсэлтэй холбоотой мөрийг судлана.

Тээврийн хэрэгслийн мөр гэдэг нь тээврийн хэрэгслийн явагч, явагч бус эд ангиас, эсвэл харилцан үйлчлэлийн нөлөөгөөр тухайн тээврийн хэрэгсэл дээр үүссэн мөрдүрс, мөр-эд зүйл, мөр-бодис.<sup>26</sup>

Тээврийн хэрэгсэл гэдэг нь хүн, ачаа тээвэрлэхэд зориулагдсан, явагч хэсэгтэй, бүх төрлийн механикжсан төхөөрөмж.

Тээврийн хэрэгслийг дараах байдлыг харгалзан ангилдаг.

### **Зориулалтаар нь:**

- Суудлын (Нийтийн болон нэг бүрийн),
- Ачааны,
- Спортын,
- Хөдөө аж ахуйн,
- Уул уурхайн,
- Үйлдвэрийн,
- Барилгын,
- Цэргийн,
- Хамгаалалт, тусгай албаны (банк, эмнэлэг, цагдаа, галын гэх мэт),
- Ердийн хөсөг,

26 Б.Бат-Эрдэнэ., Криминалистик., УБ., 2003., тал 60.



- Унадаг дугуй, мопед, мотоцикль,
- Ахуйн (усны тэрэг, чарга, тэргэнцэр),

### **Явагч хэсгээр нь:**

- Өнхөрдөг (дугуйт бүх төрлийн тээврийн хэрэгслүүд),
- Гулсдаг (чарга),
- Гинжит (трактор, экскаватор, танк),
- Холимог (цасны мотоцикл нь гулгач, гинжит 2 явагч хэсэгтэй байдаг)


Явагч хэсэг гэдэг нь тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулахын тулд эргэх, гулсах үйлдэл хийж газартай харьцах эд анги юм.

2. Тээврийн хэрэгслээс үүсэх мөрийг дараах байдлаар ангилна.

- Явагч хэсгийн мөр-дүрс. Өнхөрдөг, гулсдаг, гинжит явагч хэсгийн гадаргуун онцлог шинж тэмдэг мөр хүлээн авагчийн гадаргууд хуулбарлагдан үлдсэн гүн болон өнгөц зураглал. Эдгээр нь динамик, статик байдаг.
- Түрж байрласан хэсгийн мөр-дүрс. Тээврийн хэрэгслийн нүүрэвч, хаалт, тэвш, толь, чирэгч зэрэг харьцангуй илүү түрж байрласан эд ангиудаас мөргөлт, шүргэлтийн үйлчлэлээр хохирогчийн биед болон бусад зүйл дээр үүсэх динамик болон статик өөрчлөлт.
- Мөр-эд. Хэргийн газар, түүний орчинд үлдсэн, хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулж байгаа, тээврийн хэрэгслээс салж унасан эд анги, түүний хэсэг.
- Мөр-бодис. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дунд, эсвэл зогсож байхад асгарсан, дуссан, арчигдсан шатах, тослох, хөргөөх материалын үлдэц, мөн гэмт үйлдлийн улмаас хохирогчийн биед болон бусад зүйл дээр үүсэх хатуу будагч бодисын хэлтэрхий.
- Харилцан үйлчлэлийн мөр. Замын байгууламж, бусад зүйлийг мөргөж шүргэсний улмаас тээврийн хэрэгслийн эд ангийн гадаргууд үүссэн мөр дүрс, мөр-бодис.

### **Явагч хэсгийн мөрний ерөнхий шинж тэмдэг**

- Тэнхлэгийн өргөн. Баруун зүүн явагч хэсгийн мөрний дундаж цэг хоорондын зай.




- Тэнхлэг хоорондын зай. Гол төлөв зогсож байгаад хөдөлсөн тээврийн хэрэгслийн мөрөнд илрэх ба хонхойлтын төв цэгийг баримжаа болгоно.



- Дугуйны өргөн. Дугуйны хамгаалагч резиний нэг ирмэгээс нөгөө ирмэг хүртлэх хэмжээ.



- Дугуйны хээ. Дугуй хамгаалагч резиний гадаргуун зураглал, хэлбэр, хэмжээ, харилцан байрлал.



- Гинжний үе, үе хоорондын зай, үений тоо,
- Гулгагч хэсгийн өргөн.  
Явагч хэсгийн мөрний хувийн онцлог шинж тэмдэг:
- Резиний цууралт,
- Үйрэлт,
- Имтрэлт,
- Тасралт,



- Элэгдэл,
- Товруу,
- Нөхөөс,
- Гулгагч хэсгийн өргөн дотор байх зураас.

Хувийн онцлог шинж тэмдгийн харилцан байрлал, хэмжээс, хэлбэр нь адилтгалын шинжилгээгээр тохирч байвал мөр үүсгэгчийг шууд тогтооно.

3. Тээврийн хэрэгслийн мөр-дүрс, мөр-эд зүйл нь ихэвчлэн макро хэмжээтэй байдаг тул энгийн аргыг ашиглан илрүүлдэг.

Нарны болон гэрэлтүүлгийн хэрэгслийн 30-45 хэмийн өнцгийн тусгалаар гүн болон өнгөц мөрүүд нүдэнд тод харагдана.

Бичил хэмжээт мөр-бодис, мөр-эд зүйлийг өсгөгч шил, металл хайгч, хэт ягаан туяаны хэрэгсэл ашиглан илрүүлнэ.

### **Мөр бэхжүүлэх:**

- Гэрэл зургийн арга
- Тодорхойлон бичих арга
- Хэв цутгах арга
- Хуулбар авах
- Гар зураг үйлдэх
- Дүрс бичлэг хийх

Адилтгал хийх. Явагч хэсгийн мөр-дүрс болон явагч хэсэг түүний дардсанд нэг бүрчилсэн үзлэг, шинжилгээ хийж ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгийг илрүүлнэ. Дараа нь харьцуулах, хэмжих, давхцуулах, зүсэж эвлүүлэх аргуудыг ашиглан адилтган шинжлэнэ.

Мөр-эд, макро будагны хэлтэрхийд хэсгээр бүхлийг тогтоох, ерөнхий гарал үүслийн адилтгалын аргачлалыг ашиглан шинжилгээ хийнэ.

Адилтгалын шинжилгээг хийснээр тухайн мөрийг үүсгэсэн тээврийн хэрэгслийг шууд тогтооно.

Оношлол зүйгээр мөр үүсгэгч тээврийн хэрэгслийн зориулалт, марк, явсан чиглэл, хурд, гэмт үйлдлийн дараалал, хэргийн бусад байдлыг тогтоосноор эрлийн хүрээг багасгах, таамгалал дэвшүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах, хэргийн бодит үнэний талаар мэдээлэл өгөх ач холбогдолтой юм.

Тээврийн хэрэгслийн зориулалт, маркийг тогтооход тэнхлэг хоорондын зай, өргөн, явагч хэсэг, түүний онцлог зэрэг шинж тэмдгийг ашиглан санд байгаа өгөгдөхүүнтэй харьцуулан тогтооно.

## Тээврийн хэрэгслийн явсан чиглэл тогтоох:

- Ус гаталсан мөрөөр. Ус явсан чиглэлд цацрана.
- Шингэн зүйл дусах. Явсан чиглэлд дусал сарнина.
- Өвсний налалт. Явсан чиглэлд өвс нална.
- Чулуу хөдлөх. Явсан чиглэлд чулуу байраа өөрчлөнө.
- Тээврийн хэрэгслээс унасан зүйлээр. Унаад газарт хонхойлт үүсгэн, уг хонхойлтоос явсан чиглэлд дагаж өнхөрнө. Энэ нь энерги буюу хөдөлгөөнөө хадгалах чадварын хуулиар тайлбарлагдана.
- Мөчир дайрах үед. Өнхрөгч явагч хэсгээр дайрч хугалсан бол мөчрийн 2 талын үзүүр явсан чиглэлд, гулсдаг явагч хэсгээр дайрч хугалсан бол мөчрийн 2 талын үзүүр явсан чиглэлийн эсрэг харна.

## Сорил:

### 1. Тээврийн хэрэгсэл гэдэг нь: .....

- А. Автомашин юм.
- Б. Бүх төрлийн явагч хэсэгтэй, хүн, ачаа тээвэрлэхэд зориулагдсан механикжсан төхөөрөмж.
- В. Ус, агаар, төмөр замын бус өөрөө явагч механикжсан төхөөрөмж.
- Г. Ердийн хөсөг, усны тэрэгнээс бусад тээврийн хэрэгсэл.

### 2. Аль нь ахуйн зориулалттай тээврийн хэрэгсэл биш вэ?

- А. Унадаг дугуй.
- Б. Усны тэрэг.
- В. Чарга.
- Г. Морин тэрэг.

### 3. Тээврийн хэрэгслийн явагч хэсгийн мөрний ерөнхий шинж тэмдэг аль нь биш вэ?

- А. Тэнхлэгийн өргөн.
- Б. Дугуйны өргөн.
- В. Дугуйны хээний элэгдэл.
- Г. Тэнхлэг хоорондын зай.



4. Тээврийн хэрэгслээс шингэн зүйл дусвал дусал нь.....

- А. явсан чиглэлд сарнина.
- Б. явсан чиглэлийн эсрэг сарнина.

5. Тээврийн хэрэгслийн явагч хэсгийн мөрөнд хийх адилтгалын шинжилгээний хэдэн арга байдаг вэ?

- А. Харьцуулалт, зүсэж эвлүүлэх.
- Б. Харьцуулалт, хэмжилт, давхцуулалт.
- В. Давхцуулалт, хэмжилт.
- Г. Харьцуулалт, зүсэж эвлүүлэх, давхцуулалт, хэмжилт.

#### **Ажилбар хийх**

**Бэлтгэх зүйлс:** Гадна орчинд ажиллана. Зөөлөн хөрс, цасан дээр тээврийн хэрэгслийн мөр үүсгэнэ. Гипс, ус, гипс зуурах сав, гипс батжуулах савхан мод, хэмжих хэрэгсэл (мужааны 5 м хүртэл), бичгийн хэрэгсэл, харандаа, шугам, гэрэл зургийн аппарат (10 МР-ээс дээш).

**Гүйцэтгэл:** Оюутнуудыг 5 хүнтэй баг болгоно. Баг тус бүрдээ ажилбар гүйцэтгэнэ. 2 оюутан тээврийн хэрэгслийн мөрөнд хэмжилт хийж, гар зураг үйлдэнэ. 3 нь тээврийн хэрэгслийн мөрийг гэрэл зургийн болон хэв цутгах аргаар бэхжүүлнэ.

## СЭДЭВ 7. БИЧИГ БАРИМТ СУДЛАЛ

1. Бичиг судлалын ойлголт
2. Бичиг-техник судлалын ойлголт

1. Хүмүүсийн төрөл бүрийн харилцааны хүрээнд өргөнөөр хэрэглэгддэг бичиг баримт нь гэмт явдлын объект болдог бөгөөд үүнийг судалж, шинжилдэг шинжлэх ухааны салбарыг Криминалистикийн бичиг баримт судлал гэх бөгөөд үүнийг судалгааных нь объектоос хамааруулаад:

- Криминалистикийн бичиг судлал,
- Криминалистикийн бичиг-техник судлал гэж хоёр ангилдаг

Бичиг судлал: Бичгийн агуулга зүй, үсэг зүй болон хувь хүнд бичгийн хэл, хэв бүрэлдэх, төлөвших, өөрчлөгдөх зүй тогтлыг судалж, эрүүгийн, иргэний хэрэгт холбоотой бичиг, гарын үсгийг шинжлэх арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар юм.

Бичиг гэдэг нь хүн бодол санаагаа тусгайлан боловсруулсан үсэг, тэмдэгт, дүрс, тэдгээрийг холбох дүрмийн тусламжтайгаар илэрхийлснийг хэлнэ. Бичиг нь утгын хэсэг буюу бичгийн хэл, дүрслэлийн хэсэг буюу бичгийн хэв гэсэн бүтэцтэй.

Хүн бүр өөрийн эзэмшсэн боловсрол, мэргэжил болон анатоми, сэтгэл зүйн шинжээсээ хамаарч бичгийн тодорхой дадалтай болсон байдаг. Бичих дадал гэдэг нь хүн бодол санаа, мэдээллийг бусдад дамжуулах зорилгоор түүнийгээ тусгай тэмдэгтийн тусламжтайгаар дүрслэн буулгах бичгийн хэл, хэв тогтож, төлөвшсөн хэвшмэл чадварыг хэлнэ. Бичих дадлыг дотор нь:

- Техник дадал. Энэ нь гарт үзэг барих, цаас байрлуулах, ширээнд суух дадал.
- Дүрслэх дадал. Энэ нь үсэг, элемент үйлдэх, холбох, зөв дүрслэн гаргах дадал.
- Утгачилах дадал. Энэ нь үг өгүүлбэр бүтээх, бичгийн эх зохиох, боловсруулах дадал.

Бичгийн хэл, хэвийн шинж тэмдэг дахин давтагдашгүй, харьцангуй тогтвортой, хувилбартай байх мөн чанарт түшиглэн бичиг судлалын онолын мөрдлөгийг үндэс болгон бичгийн эх зохиогч, гүйцэтгэгчийг тогтоодог. Бичгийн зохиогч, гүйцэтгэгч нь ихэвчлэн нэг хүн байдаг боловч заримдаа өөр өөр тусдаа байх тохиолдол бий.



### **Бичиг судлалын шинжилгээгээр дараах асуудлыг шийдвэрлэдэг:**

- Зохиогч судлалын шинжилгээ. Оношлогооны шинжилгээгээр бичгийн хэл, агуулга, найруулга, утгыг зохиосон хүний анатоми, нийгэм, сэтгэл зүйн шинж, боловсорсон түвшин, адилтгалын шинжилгээгээр зохиогчийг тухайлан тогтооно.
- Гүйцэтгэгч судлалын шинжилгээ. Оношлогооны шинжилгээгээр бичгийг гүйцэтгэсэн хүний анатоми, нийгэм, сэтгэл зүйн шинж, бичсэн нөхцөл, адилтгалын шинжилгээгээр гүйцэтгэгчийг тухайлан тогтооно.
- Гарын үсэгт хийх шинжилгээ. Гарын үсгээ тухайн хүн өөрийн дадлаар, эсвэл зориуд гуйвуулан зурсан алин болох, эсвэл өөр хүн дуурайж хуурамчаар үйлдсэн эсэх, хуурамчаар үйлдсэн аргыг оношилж, адилтгаж тогтооно.
- Нууц бичиг (криптограмм, гэмт графит)-т хийх шинжилгээ. Гэмт бүлэг, гэмт хэрэгтнүүд хоорондоо харилцдаг, нууц арга, түлхүүрээр тайлж уншдаг үсэг, элемент, тэмдэгтүүдээс бүтсэн бичгийг шинжлэнэ.
- Эвлүүлсэн бичигт хийх шинжилгээ. Эвлүүлсэн бичгийг үйлдэгч этгээдийн анатоми, нийгэм, сэтгэл зүйн шинж, үйлдсэн арга, нөхцөлийг тогтоохын тулд криминалистикийн иж бүрэн шинжилгээний аргачлалыг ашиглан хийх шинжилгээ юм.

Бичиг судлалын адилтгалын шинжилгээний үр дүн бодитой байх нь харьцуулах загварыг хэрхэн цугуулснаас ихээхэн хамаардаг. Харьцуулах загвар гэдэг нь шинжилж буй бичигтэй адилтган шинжлэх зорилгоор байцаан шийтгэх ажиллагааны үед хураан авсан, бичгийн зохиогч, гүйцэтгэгчийн онцлогийг тусгасан, гарал үүсэл нь тодорхой бичиг, гарын үсгийг хэлнэ.

Харьцуулах загварыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөгч тогтоол үйлдэн, тэмдэглэл хөтлөж цуглуулан авдаг. Энэ нь харьцуулах загварыг хууль зүйн хувьд нотлогооны хэмжээнд үнэлэх үндэс болж өгдөг.

Харьцуулах загварыг шинжилгээний шаардлага хангахуйцаар авахын тулд ЭБШХ-ийн 160 дугаар зүйлийн 160.3-д заасны дагуу мэргэжилтнийг оролцуулах нь илүү ач холбогдолтой.

### **Харьцуулах загварыг:**

- чөлөөт,
- харьцангуй чөлөөт,
- туршилтын гэж ангилдаг.

Чөлөөт загвар гэж нь цаг хугацааны хувьд хэргийг үйлдэхээс өмнө бий болсон, тухайн хэрэгт холбогдолгүй зүйлсийг хэлнэ. Энэ загвар нь адилтгалын ач холбогдол хамгийн өндөр байдаг буюу субъектив нөлөөлөлгүй тул адилтгалын шинжилгээнд

аль болохоор ихээр ирүүлбэл сайн. Уг загварт хэрэг үйлдэхээс өмнө бичиж байсан гар бичмэл, гарын үсэг зэргийг оруулж ойлгоно. Чөлөөт загварын хугацааг тооцохдоо шинж тэмдэг өөрчлөгдөх зүй тогтлыг харгалзана.

Харьцангуй чөлөөт загвар гэж цаг хугацааны хувьд хэргийг үйлдсэнээс хойш бий болсон, тухайн хэрэгт холбогдолгүй зүйлсийг хэлнэ. Энэ загвар нь хэргийг үйлдсэн буюу мөр үүссэн хугацаатай хамгийн ойрхон бий болдог онцлогтой тул шинж тэмдэг өөрчлөгдсөн эсэхийг тогтоох ач холбогдолтой. Харьцангуй чөлөөт загварт цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, хүсэлт дээрх гарын үсэг, гар бичмэл, байцаалтын тэмдэглэл дээрх гарын үсэг зэргийг оруулж ойлгоно.

Туршилтын загвар гэж гэмт үйлдлийн мөртэй харьцуулан шинжлэх зорилгоор мөрдөгчийн санаачлага, эсвэл шинжээчийн гаргасан хүсэлтээр байцаан шийтгэх ажиллагааны үед бий болгосон зүйлсийг хэлнэ. Туршилтын загварыг бий болгохдоо шинжилж буй мөр үүссэн орчин, нөхцөлд аль болох ихээр дөхүүлэн, хэд хэдэн удаа давтан “туршилтын мөр” үүсгэдэг. Сэжигтэн нараар мөрдөгчийн хяналтын дор бичүүлэн авсан гар бичмэл, гарын үсэг зэргийг ойлгоно.

### **Харьцуулах загварт дараах шаардлагыг тавьдаг:**

1. Гаралүүсэл нь тодорхой байх. (Баримт бичиг, гэрэл зураг, эрх бүхий байгууллагын тодорхойлолт, лавлагаа зэргээр баталгаажна)
2. Цаг хугацааны хувьд шинжилж буй бичигтэй аль болох ойролцоо хугацаанд үүссэн байх. (Чөлөөт загварын хувьд хэрэг үйлдэхээс 10-аас дээшгүй жилийн өмнө үүссэн бол сайн)
3. Тооны хувьд хангалттай байх. (10-15 гарын үсэг, 3-аас доошгүй хуудас гар бичмэл)

2. Бичиг-техник судлал: Бичиг баримт, үнэт цаас үйлдвэрлэх хэвлэлийн технологи болон тэдгээрийг хуурамчаар үйлдэх аргыг судалж, шинжилгээ хийх арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

### **Бичиг баримтыг хуурамчаар үйлдэх арга:**

- Хэсэгчлэн хуурамчаар үйлдэх,
- Бүхэлд нь хуурамчаар үйлдэх.

### **Бичиг-техник судлалын шинжилгээгээр дараах асуудлыг шийдвэрлэдэг.**

- Иргэний бичиг баримтад хийх шинжилгээ. Оношлогооны шинжилгээгээр бичиг баримтыг үйлдсэн хэвлэлийн технологийг, адилтгалын шинжилгээгээр санд байгаа загвартай харьцуулан жинхэнэ эсвэл хуурамчийг тогтооно.



- Мөнгөн тэмдэгтэд хийх шинжилгээ. Оношлогооны шинжилгээгээр мөнгөн тэмдэгтийг үйлдсэн хэвлэлийн технологийг, адилтгалын шинжилгээгээр санд байгаа загвартай харьцуулан жинхэнэ эсвэл хуурамчийг тогтооно.
- Тамга, тэмдэгний дардсанд хийх шинжилгээ. Оношлогооны шинжилгээгээр дардсыг үүсгэсэн зүйлийн онцлог, төрөл, адилтгалын шинжилгээгээр загвар дардастай харьцуулан жинхэнэ эсвэл хуурамчийг тогтооно.
- Бүдэг, дарсан болон устгасан бичиг, тамга, тэмдэгний дардсанд хийх шинжилгээ. Хүний энгийн нүдэнд харагдахгүй бичиг, тамганы дардасыг гэрэл шүүгч, өсгөгч багаж, төрөл бүрийн гэрлийн долгион үүсгэгч багажны тусламжтайгаар сэргээн тогтооно.
- Хэвлэмэл хуудсанд хийх шинжилгээ. Албан байгууллагын хэвлэмэл хуудас ашиглан үйлдсэн бичиг баримт \албан бичиг, тодорхойлолт, лавлагаа г.м\ жинхэнэ эсвэл хуурамчийг тогтооно.
- Үнэт цаасанд хийх шинжилгээ. Цаас нь байгалийн гаралтай эсвэл нийлэг, үнэт буюу жирийн гэдгийг тогтооно.

#### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Бичиг судлалын тухай тодорхойлно уу?
2. Бичиг, гарын үсгийг шинжлэх шаардлага бий юу? Ямар төрлийн гэмт хэргийг нотлох боломжтой вэ?
3. Харьцуулах загвар хэдэн төрөлтэй вэ? Аль нь ямар ач холбогдолтой вэ?
4. Бичиг судлалын шинжилгээнд тавих нийтлэг асуултауд?
5. Бичиг-техник судлалын адилтгалын шинжилгээгээр юуг тогтоох вэ?
6. Бичиг-техник судлалын оношлогооны шинжилгээгээр юуг тогтоох вэ?

#### Бодлого

Шинээр баригдсан “Цамхаг” хотхонд байр худалдан авсан оршин суугчдад “Байр чөлөөлөх тухай мэдэгдэх хуудас” иржээ. Мэдэгдэх хуудсын утга нь: “Гэрээнд зааснаар орон сууц худалдан авах төлбөр төлөх хугацаа хэтэрсэн тул байрыг чөлөөлнө үү” гэсэн байна. Гэтэл тухайн мэдэгдэл хүлээн авсан оршин суугчид бүгд байр худалдан авах төлбөрөө төлсөн тухайгаа хэлж “Байрны төлбөр төлсөн тухай баримт” гаргаж үзүүлэв. Гэтэл уг баримтыг барилгын компаний ерөнхий захирал Н.Чинхүү үгүйсгэж, мөнгө өгсөн, аваагүй хэмээн 2 талаас маргаан үүсжээ.

Мэдэгдэл авсан оршин суугчид мөрдөн байцаах албанд хандан “Ерөнхий захирал Н.Чинхүү биднээс мөнгө авсан хэрнээ байрнаас хөөлөө” гэж гомдол гарган эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулсан байна.

## Асуулт:

1. Энэ хэрэг, маргаанд ямар зүйл нотлох баримт болох вэ?
2. “Байрны төлбөр төлсөн тухай баримт”-ыг шинжилгээнд хүргүүлэхдээ ямар асуудлыг тогтоолгох ёстой вэ?
3. Уг баримтууд хуурамч байна гэсэн шинжээчийн дүгнэлтэд үндэслэн та ямар шийдвэр гаргах вэ?



## СЭДЭВ 8. ГАЛТ ЗЭВСЭГ СУДЛАЛ

1. Галт зэвсэг судлалын ойлголт, галт зэвсгийн төрөл, ангилал
2. Буудлагын улмаас мөр үүсэх зүй тогтол (Дотоод, гадаад баллистик)
3. Галт зэвсгийн мөрөөр тогтоож болох нөхцөл байдал

1. Галт зэвсэг судлал гэдэг нь галт зэвсгийн бүтэц, буудлага явагдах зүй тогтлыг судалж, галт зэвсгийн мөртэй ажиллах арга зүйг боловсруулдаг мэдлэгийн салбар.

Криминалистикийн практикт галт зэвсэг бэлтгэсэн аргыг тогтоох экспертиз хийх шаардлага гарч ирдэг. Гаднаасаа галт зэвсэгтэй төсөөтэй мөртлөө галт зэвсэг биш, огт төсөөгүй боловч галт зэвсэг болох төхөөрөмж байдаг. Ийм төхөөрөмжийг галт зэвсэг, сум хэрэгсэлд хамааруулах криминалистикийн шалгуур нь цэрэг-техникийн ойлголтоос ялгаатай.

Хий үүсгэгч бодисын (дарин цэнэг) дулааны задралын энергиэр сум нь чиглэлт хөдөлгөөнд орж бай оноход бүтээцийн хувьд зориулагдсан төхөөрөмжийг галт зэвсэг гэнэ.

### **Галт зэвсгийг зориулалтаар нь дараах байдлаар ангилна:**

- Байлдааны галт зэвсэг – үйлдвэрийн аргаар хийгдсэн, олон цэнэглэгддэг, бянт бүхий нэг гол төмөртэй, гулсдаг замагтай, сумаар буудлага үйлддэг.
- Спорт-сургалтын галт зэвсэг – бага калибрын, богино ба дунд зэргийн гол төмөртэй, цагирган очлууртай сумаар буудлага үйлддэг.
- Ангийн галт зэвсэг – үйлдвэрийн аргаар хийгдсэн, нэг эсвэл хэд хэдэн урт гол төмөртэй, сум, үрэл, хорголжоор буудлага үйлддэг.
- Иргэний галт зэвсэг – нэг бүрийн хамгаалалтын зориулалттай, бага калибрын, байлдааны ба пластик сум, мэдрэл саатуулагч хийгээр бууддаг, эсвэл дуу чимээ гаргагч богино гол төмөртэй байдаг.
- Тусгай галт зэвсэг – хадаас хадагч, дохио өгөгч, гэрэлт сумаар буудагч зэрэг бусад зориулалтаар ашигладаг.
- Гэмт хэргийн (зориуд бэлтгэсэн) галт зэвсэг – гэмт хэрэг үйлдэхэд тохиромжтой болгон загвар, хийцийг өөрчилсөн галт зэвсэг.

Төрлөөр нь: винтовка, карабин, пистолет, ружьё, штуцер, автомат, пистолет, пульмёт, револьвер гэж хуваана.

Гол төмрийн уртаар нь: богино (20 см), дунд зэрэг (20-50 см), урт (50 см дээш) гол төмөртэй гэж ангилна.

Цэнэглэх механизмын үйлчлэлээр нь: гар ажиллагаатай, хагас автомат, автомат гэнэ.

Галт зэвсэг, түүний сум хэрэгслийг ийнхүү ангилах нь хэргийн газарт үүссэн мөрийг оношлож галт зэвсгийн зориулалт, төрлийн тогтоох, улмаар эрэн сурвалжлах ажиллагааны эрлийн хүрээг хумих, байцаан шийтгэх ажиллагааны тэмдэглэлд галт зэвсгийг зөв тодорхойлон бичих зэрэгт ач холбогдолтой.

2. Буудлага гэдэг нь галт зэвсэг ашиглан тэсрэлтийн энерги бий болгох замаар сумны хушуут хонгионоос суллаж чиглэлт хөдөлгөөнд оруулах үйлдэл юм. Буудлага хийгдэх үйл явц нь дотоод, гадаад баллистик үзэгдэлээр тайлбарлагдана.

Дотоод баллистик нь галт зэвсгийн цохих буулгах механизм гох дарснаар ажиллаж, цохилуур шөвөг төмөр сумны бялтан дээр цохих үед дарин цэнэгт оч хаяж гал авалцсанаар эхэлнэ. Дарь огцом шатаж сумны дотоодод хүчтэй даралт үүссэнээр сумны хушуу хонгионоос чөлөөлөгдөн гол төмрийн сувгаар гүйж бянтанд зүсэгдэн тэнхлэгээрээ эргэлдэх хүчийг авч гол төмрийн амсраас сугарах хүртэл үргэлжилнэ.

Гадаад баллистик нь сумны хушуу түүнийг дагалдан дутуу шатсан дарь, тортог, гал, утаа гол төмрийн амсараас гарах үеэс эхэлж, сумны хушуу саадыг нэвтэлж гэмтэл үүсгэх хүртэл үргэлжлэх нислэгийг хэлнэ.

Буудлагын улмаас буюу дотоод, гадаад баллистикийн үед дараах мөр үүснэ.

### **Сумны хонгион дээр:**

- Дайзны мөр
- Хүхээгний мөр
- Шөвөг төмрийн мөр
- Хонгио хаягч хумсны мөр
- Тортог, хөө, дутуу шатсан дарь.

### **Сумны хушуун дээр:**

- Хонгионы амсрын бичил зураасан мөр
- Бянтны анхдагч мөр
- Бянтны хоёрдогч мөр
- Тортог, хөө, дутуу шатсан дарь
- Хатуу байнд тусах үед хушуу эвдрэх.



### **Байн дээр:**

- Гэмтэл, шарх
- Арчилтын бүслүүр
- Тулгаж буудсан үед штанцмарк
- Тортог, хөө, дутуу шатсан дарь.

### **Буудагч дээр:**

- Тортог, хөө, дутуу шатсан дарь.

3. Буудлагын улмаас үүссэн дээрх мөрүүдэд оношлол, адилтгал хийснээр галт зэвсэг ашиглан үйлдсэн гэмт хэргийг илрүүлж, нотолдог.

### **Оношлол зүйн чиглэлээр дараах асуудлыг шийдвэрлэнэ:**

- Төхөөрөмж нь галт зэвсэг мөн эсэх?
- Ямар марк, моделийн галт зэвсэг болох?
- Ямар зориулалтын, ямар калибрын сум хэрэглэдэг болох?
- Галт зэвсэгт бүтээцийн өөрчлөлт хийсэн эсэх?
- Галт зэвсгээр буудлага үйлдэж болох эсэх?
- Галт зэвсэг бүрэн ажиллагаатай эсэх?
- Галт зэвсгээр буудлага үйлдсэн эсэх ?
- Гох дээр дараагүй үед доргилтоос буудлага үйлдэх эсэх?
- Сүүлчийн цэвэрлэгээ хийснээс хойш хэдэн удаа буудсан байна вэ?
- Буудагчийн байрлал, зай.

### **Адилтгалын чиглэлээр дараах асуудлыг шийдвэрлэнэ:**

- Хэргийн газраас илрүүлсэн болон сэжигтнээс хураан авсан хонгио санд хадгалагдаж буй хонгиотой тохирох эсэх?
- Хэргийн газраас илрүүлсэн болон цогцосноос авсан сумны хушуу санд хадгалагдаж буй хушуутай тохирох эсэх?
- Хонгио, хушуу нь урьд нэг бүхэл сум байсан эсэх?
- Галт зэвсгийн эд ангиуд урьд нэг бүхэл байсан эсэх?

## ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Галт зэвсэг судлал гэж юу вэ?
2. Буудлагын улмаас хаана ямар мөрүүд үүсдэг вэ?
3. Буудлагын мөрийг илрүүлэх, бэхжүүлэх аргуудаас ярина уу?
4. Галт зэвсгийн адилтгалын шинжилгээгээр юуг тогтоох вэ?
5. Галт зэвсгийн оношлогооны шинжилгээгээр юуг тогтоох вэ?

## Бодлого:

Өглөөний 08 цагт БЗД-н 18-р хороо 35-р байрны гадаа нас барсан хүн байна гэсэн дуудлагаар цагдаагийн бүрэлдэхүүн очиж үзлэг хийхэд иргэн Э нь дагзан тус газраа буудуулсны улмаас нас барсан байна гэсэн анхны оношийг шүүх-эмч гаргав.

## Асуулт:

1. Энэ хэргийн газраас ямар, ямар мөрийг хэрхэн илрүүлж, бэхжүүлэх ёстой вэ?
2. Цогцосонд үзлэг хийж, ямар мөр, дээж авах ёстой вэ?



### III БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН ТАКТИК ЗҮЙ

#### СЭДЭВ 1. КРИМИНАЛИСТИКИЙН ТАКТИК ЗҮЙН ОЙЛГОЛТ, МӨН ЧАНАР

1. Криминалистикийн тактик зүй нь криминалистикийк шинжлэх ухааны бие даасан хэсэг болох нь
2. Тактикийн үе шатууд

1. Криминалистикийн тактик зүй нь өөрийн өмнөх хэсэг-криминалистикийн техник, дараах хэсэг - зарим төрлийн гэмт хэрэг мөрдөн байцаах арга зүйтэй нягт холбоотой, криминалистикийн шинжлэх ухааны бие даасан хэсэг мөн.

Мөр, нотлох баримт цуглуулах, шинжлэхэд зориулж криминалистикийн шинжлэх ухааны боловсруулсан техникийн хэрэгсэл, арга зүй, арга барил нь криминалистикийн тактик зүйгээр дамжиж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн практикт биелэлээ олдог.

Криминалистикийн тактик нь шинжлэх ухааны үзэл баримтлал, түүн дээр үндэслэсэн, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг (investigatory actions - англи) зохион байгуулах, төлөвлөх, явуулах тактик зүйн тухай практик зөвлөмжийн систем юм.

Нотолгоо явуулж байгаа албан тушаалтны зан үйлийн чиг, нотлох баримт цуглуулах, шинжлэхэд чиглэсэн мөрдөн байцаах тодорхой ажиллагааны арга барилыг тодорхойлох зөвлөмж ч мөн адил криминалистикийн тактикт хамаарна.

Байцаан шийтгэх ажиллагаа явуулах тактикийн арга барил нь криминалистикийн тактикийн цорын ганц элемент биш боловч, түүний хамгийн чухал хэсэг, харин тактикийн арга барилын ойлголт, зөвлөмж түүний үндсэн ойлголтод хамаарна. Тактикийн арга барилын хувьд криминалистикийн арга барил төрлийн шинжтэй.

Криминалистикийн арга барил нь үйл ажиллагааны хамгийн үр ашигтай, оновчтой арга, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шинжлэх, үнэлэх, ашиглахад баримтлах илүү тохиромжтой чиглэл юм.

Арга барилыг техник - криминалистикийн ба тактик - криминалистик (тактик)-ийн гэж ангилна.

Техник - криминалистикийн хэрэгсэл (учрал болсон газар гэрэл зураг авах гэх мэт), криминалистикийн техникийн шинжлэх ухааны үзэл баримтлал (мөр бий болох механизмын тухай шинжлэх ухааны үзэл баримтлалд үндэслэсэн мөр

илрүүлэх арга барил)-ыг техник - криминалистик гэнэ.

Тактик-криминалистик (тактик)-ийн гэж мөрдөн байцаалт зохион байгуулах, төлөвлөх, байцаан шийтгэх ажиллагаанд бэлтгэх, явуулах арга барилыг хэлнэ.

Үүнээс гадна тактикийн арга барил «зан төлөв»-ийн, өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч зан үйлийн тодорхой чиг сонгож авах, түүнийгээ баримтлах шинжтэй байж болно.

Монгол улсын Үндсэн хууль, Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль криминалистикийн тактикийн эрх зүйн үндэс юм.

Тактикийн арга барил, зөвлөмж ашиглах эрх зүйн үндсийг зөв тодорхойлох нь гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаахад хуулийн шаардлага биелүүлэхийн баталгаа.

Эрүүгийн хэргийн шүүхийн ажиллагаанд тактикийн арга барил хэрэглэх эрх зүйн үндэс нь хууль, эрх зүйн бусад актаар тогтоосон, энэ арга барил, зөвлөмж хэрэглэх нөхцөл, агуулга, зорилго, дэгийг тодорхойлсон зарчим, журмын систем мөн.

Криминалистикийн тактикийг боловсруулахад хуулийг дээдлэж, түүнийг хэлбэрэлтгүй сахих нь эрүүгийн хэргийн бодит үнэнийг танин мэдэх, нотлох бололцоог хангадаг зайлшгүй нөхцөл болдог.

Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тактик-криминалистикийн арга барил, криминалистикийн техникийн хэрэгсэл, арга зүй, арга барил ашиглах журам тогтоосон эрх зүйн хэм хэмжээний үндсэн акт юм. Энэ чиглэлээр ЭБШХ-ийн хэм хэмжээг дараах бадлаар ангилж болно:

- а) тактикийн арга барилын агуулгыг тодорхойлсон;
- б) тактикийн арга барил хэрэглэх зорилгыг агуулсан;
- в) тактикийн арга барилыг гүйцэтгэх журам тогтоосон;
- г) тактикийн арга барил хэрэглэсэн үр дүнг үнэлэх үзүүлэлтийг тусгасан
- д) тодорхой нөхцөлд тактикийн ямар нэг арга барил хэрэглэхийг хориглосон буюу хязгаарласан.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарчимд тохирсон тийм л арга барилыг хэрэглэнэ. Гэхдээ дураар аашилж болохгүй.

Ямар ч хууль, хуульчилсан актаар гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаахад ашиглах, эсхүл ашиглаж болох тактикийн арга барилын төгс жагсаалтыг тогтоож чадахгүй. Нөгөө талаар энэ арга барилыг хэрэглэх журмын тухай түгээмэл заалттай байж чадахгүй.



Зарчмын энэ үзэл баримтлалыг дараах үндэслэлээр тайлбарлаж болно:

1. Эрх зүйн нэг акт буюу эрх зүйн хэм хэмжээний системд тактикийн арга барилын төгс жагсаалтыг илэрхийлэх ямар ч оролдлого гэмт явдалтай тэмцэх тактикийн шинжлэх ухааны үндсийг хөгжих, боловсронгуй болох, түүний үр ашиг дээшлэх процессыг зогсоох сөрөг үзэгдэл болно. Шинжлэх ухааны мэдлэгийн бүх салбарын нэг адил криминалистикийн тактикийн хөгжлийг юугаар ч зогсоож, сааруулж болохгүй.
2. Тактикийн арга барил, зөвлөмж ашиглах бодит бүх байдал (амьдралд тохиолдох)-ыг нэг бүрчлэн тоочих боломжгүй учир тактикийн арга барил хэрэглэх журмын тухай түгээмэл заалтыг хуульд тусгах бололцоогүй.
3. Криминалистикийн тактикийн арга барил хэрэглэх эрх зүйн үндэс нь хуулийн хэм хэмжээг хэлбэрэлтгүй баримтлахыг шаардана. Гэмт хэрэг үйлдсэн этгээд бүрт ял шийтгэлийг шударгаар оногдуулах, гэм буруугүй нэг ч хүнийг эрүүгийн хариуцлагад татаж, ял шийтгэж болохгүй гэсэн зарчмыг л баримтлана.
4. Эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах гэдэг нь болж өнгөрсөн үйл явдлыг, түүний мөрөөр танин мэдэх, гэм буруутай хүнийг эрүүгийн хариуцлагад татаж, ялыг шударгаар оногдуулах албаны үүргээ биелүүлэхэд чиглэсэн албан тушаалтны үйл ажиллагаа.
5. Криминалистикийн тактикийн шинжлэх ухааны үзэл баримтлал, практик зөвлөмж нь нотлох баримт бий болох, хадгалагдах, үгүй болох объектив процессын болон нотолгооны процессын зүй тогтолд үндэслэнэ.
6. Гэмт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн биш, эрүүгийн байцаан шийтгэх процессын бүх субъектийн үйл ажиллагаанаас тогтдог өргөн хүрээтэй ойлголт. Нэгэнт хүмүүс оролцож байгаа болохоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад мөрдөн байцаах ажиллагааны сэтгэл судлалын үндэс, оролцогчдын сэтгэл зүйн онцлогийг мэдэж байх (хэн бэ гэдгийг мэдэх) нь ажлын амжилтын нэг үндэс.
7. Сэтгэл судлал нь криминалистикийн таамаглал дэвшүүлэх, мөрдөн байцаах ажлыг зохион байгуулах, төлөвлөх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах хамгийн үр ашигтай арга барил боловсруулахад туслана.

2. Мөрдөн байцаах ажиллагааны зорилгыг хангахын учир тактикийн бүтэц, тодорхой шат болох салбар системийн агуулгыг урьдчилан тодорхойлох нь чухал. Энэ шатлалын дарааллыг ерөнхийд нь дараах байдлаар илэрхийлж болно:

1. мөрдөн байцаах ажиллагаанд бэлтгэх;
2. мөрдөн байцаах ажиллагаа явуулах;
3. мөрдөн байцаах ажиллагааны явц, үр дүнг бэхжүүлэх;

4. хүрсэн үр дүнг үнэлэх, эрүүгийн тухайн хэрэгт нотлох баримтын мэдээллийн систем дэхтүүний ач холбогдол, эзлэх байрыг тодорхойлох.

**А. Мөрдөн байцаах ажиллагаанд бэлтгэх.** Энэ шатанд мөрдөн байцаах ажиллагааны зорилгыг тодорхойлж, түүнийг явуулах хугацаа, оролцогчид, ашиглах техник криминалистикийн арга барил, хэрэгсэл, гүйцэтгэх ажлын боломж ашиглах хэлбэр, хязгаар, мэргэжилтний туслалцаа авахтай холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

Энэ шатанд заавал байх нэг нөхцөл нь явуулах ажиллагааны бүх процессын уян хатан загварыг санаандаа дэвшүүлэх явдал юм. Загвар нь янз бүрийн байдлыг урьдчилан харах, мөрдөн байцаах ажиллагааны явцад ашиглаж болох хувилбар, харгалзан үзэх хүчин зүйлийн болзошгүй нөлөөг цаг тухайд нь бодож боловсруулахад туслана. Ийм загварын бүрэн дүүрэн байдал, түүний хувилбар нь гэмт явдлын тухай мэдээллийн хэмжээнээс шууд шалтгаална. Мэдээлэл их байх тусам загварын хувилбар цөөн байна.

Анхны мэдээллийн хэмжээ мөрдөн байцаах ажиллагаа явуулж байгаа газраас бас шалтгаална. Хэрэв мөрдөн байцаах ажиллагаа бүхий л ажиллагааны системд анхных болж байгаа бол мэдээлэл бага байна. Ийм байдал эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө учрал болсон газар хийх үзлэгт бэлтгэхэд ихэвчлэн илэрнэ. Энэ тохиолдолд санааны загвар байгуулахад нийтлэг шинжтэй, өөрөөр хэлбэл учралын шинжийг хамгийн ерөнхий хэлбэрээр авч үзэхэд хэрэглэдэг таамаглалд үндэслэнэ. Ийм таамаглалыг мөрдөн байцаах ажиллагааны явцад нэмэгдэл мэдээлэл олсон хэмжээгээр бодит болгоно.

Мөрдөн байцах ажиллагааны тодорхойлсон зорилгыг төлөвлөгөөнд тусгана. Мөрдөн байцаах ажиллагааны төлөвлөгөө зорилго, хугацаа, газраас гадна дараах зүйлийг агуулсан байна:

- мөрдөн байцаах ажиллагаа чиглэн явагдах хүн, объектын тухай мэдээлэл;
- мөрдөн байцаах ажиллагаанд ашиглах шаардлага гарч болох нотлох баримт;
- энэ нотлох баримт, гүйцэтгэх ажлыг мэдээлэл ашиглах арга барил;
- болзошгүй нөхцөлт байдлыг харгалзсан мөрдөн байцаах ажиллагаа явуулах тактикийн арга барил, түүнийг хэрэглэх дараалал, шаардлагатай техникийн хэрэгсэл.

Оролцогчдыг тодорхойлох нь мөрдөн байцаах ажиллагааны бэлтгэлийн нэг чухал элемент.

Хуулийн талаас авч үзвэл мөрдөн байцаах ажиллагаанд заавал байх ба байж болох оролцогчид гэж байдаг. Мөрдөн байцаагчаас гадна зохих тохиолдолд хендленгийн гэрч, мэргэжилтэн, өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, насанд хүрээгүй



байцаагдагчийн төрөл төрөгсөдийг заавал байх оролцогчид гэж хуульд тодорхойлсон. Гэвч практик талаасаа бол гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, засаг захиргааны төлөөлөгчийг багтаавал ийм оролцогчид өргөн хүрээтэй. Ийм учраас оролцогчдыг тодорхойлохдоо хуулийн шаардлагаас гадна тодорхой категорийн эрүүгийн хэрэгт тухайн ажиллагааг явуулахад практикаар боловсорсон журмыг бас удирдлага болгоно.

**Б. Мөрдөн байцаах ажиллагаа явуулах.** Энэ шатанд төлөвлөгөө хэрэгжиж, тавьсан зорилго шийдвэрлэгдэх, хийсэн дүгнэлтийг батлах, эсхүл үгүйсгэх замаар таамаглалыг шалгана.

Мөрдөн байцаах ажиллагаа бол танин мэдэхүйн төрөл бүрийн арга зүй хэрэглэж байгаа хуулиар тогтоосон хэлбэр. Үүнээс үзвэл тактикийн арга барил нь зохих байдал, цаг үед нь зохицуулж, энэ арга зүйг хэрэглэж буй хувилбар болдог.

Эрүүгийн хэрэгт хийж байгаа ажиллагааны системд бидний гүйцэтгэж буй ажиллагааны эзлэх байр суурь мөрдөн байцаах ажиллагаа явуулах тактикт тодорхой нөлөө үзүүлнэ. Мөрдөн байцаах ажиллагааг гүйцэтгэж байгаа үүргээр нь анхны ба дараах гэж ангилна. Эрүүгийн хэрэг үүсгэхээс эхэлдэг, мөрдөн байцаалтын эхний шатанд явуулдаг анхны ажиллагаа нь:

- a. мөрдөгдөж байгаа үйл явдлын байдал, агуулгын тухай баримжаа, түүний механизм, үр дагаврын тухай мэдээлэл олох;
- b. гэмт хэргийг “халуун мөрөөр нь” илрүүлэх, гэмт этгээдийг тогтоох, эрэн сурвалжлахад шаардлагатай мэдээлэл олж авах;
- c. объектив, субъектив хүчин зүйлийн улмаас устаж, эсхүл үгүй болж болох нотлох баримт цуглуулах;
- d. нотолгооны зүйлийн бүх агуулгыг багтаасан мөрдөн байцаалтын дэлгэрэнгүй таамаглал дэвшүүлэх эхний мэдээлэл олох хэрэгсэл болно.

Хоёрдугаар шатанд гүйцэтгэдэг дараах ажиллагаа нь анхны шатанд цуглуулсан нотлох баримтад задлан шинжилгээ (анализ) хийх, түүнийг үнэлэх, ашиглах, таамаглалыг нарийвчлан шалгах, гэмт хэргийн бүрэлдэхүүний элементүүдийг нотлох, гэмт хэрэг үйлдэхэд бололцоо олгосон байдлыг тодорхойлоход чиглэнэ. Хэрэв мөрдөн байцаалтын анхны ажиллагааны тактикт цаг хугацааны болон гэнэт байх хүчин зүйл гол нь байдаг бол дараах шатны ажиллагааны тактик нэг зорилготой хэд хэдэн ажиллагааг нэг цогцод нэгтгэн явуулах хослолоор тодорхойлогдож, тактикийн хослол бий болгоно. Ийм тохиолдол мөрдөн байцаах нэг ажиллагаа нь өөр нэг ажиллагааны бэлтгэл байж болдог. Танигчийг таниулах объектын шинж тэмдгийн талаар урьдчилан байцаах нь энэ ажиллагааны бэлтгэлийн элемент, түүний үр дүн сэжигтэнг байцаах материал болох жишээтэй.

**В. Ажиллагааны явц, үр дүнг бэхжүүлэх.** Энэ шатны тактик мөрдөн байцаах ажиллагааны бүх агуулга, хүрсэн үр дүнг бүрэн, зөв тусгаж харуулахад оршино. Бэхжүүлэх тактикийн арга барил нь техник - криминалистикийн зохих хэрэгсэл, хуулиар тогтоосон хэлбэрээр нотолгооны мэдээллийг дүрслэн харуулах арга барил сонгон авах, хэрэглэх нөхцөлийг хангахад чиглэнэ.

Мөрдөн байцаах ажиллагааны журмын дагуу хууль ёсны болгоогүй мэдээлэл нотолгооны хүчгүй бөгөөд явуулсан ажиллагаа нь байцаан шийтгэх ямар ч үр дагаваргүй байна. Энэ шатны үр дүн нь нотолгооны эх сурвалж болох мөрдөн байцаах ажиллагааны бичиг баримт (эд мөрийн баримт, харьцуулах материалыг хууль ёсны баталгаатай болгохыг хамааруулан) бүрдүүлэх явдал мөн.

**Г. Хүрсэн үр дүнг үнэлэх, түүний ач холбогдлыг тодорхойлох.** Хийсэн ажил, хүрсэн үр дүнд хийх задлан шинжилгээ нь нотолгооны мэдээлэл үнэн эсэхийг шалгах, түүний нотолгооны ач холбогдол, цаашид ашиглах арга замыг тодорхойлоход чухал үүрэгтэй. Энэ шатанд мөрдөн байцаах ажиллагаанд гаргасан алдаа, түүний хор уршгийг тогтоож, ажиллагааг давтан хийх эсэхийг шийдвэрлэнэ. Ажиллагааны явц, үр дүнг тусгасан мөрдөн байцаах ажиллагааны бичиг баримтыг объектив, бүрэн дүүрэн, өгүүллийн логик, дараалал, тодорхой байдал, шаардлагатай баталгаа байгаа эсэхээр үнэлнэ. Дээр өгүүлсэн бүхэн зарим төрлийн мөрдөн байцаах ажиллагааны тактикийг тодорхойлоход бүтэц - системийн зүгээс хандахын чухлыг илэрхийлж байна. Мөрдөн байцаах зарим ажиллагааны тактикийг боловсруулах, боловсронгуй болгох нь криминалистикийн шинжлэх ухааны чухал зорилгын нэг.

#### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Криминалистикийн тактик зүй гэж юу вэ?
5. Криминалистикийн тактик зүй нь криминалистикийн шинжлэх ухааны бие даасан хэсэг болохыг батлана уу?
3. ЭБШ тодорхой ажиллагааг хэдэн үе шаттай явуулдаг вэ?
4. Мөрдөн байцаалтын үзлэгийн тактикийн аргуудыг нэрлэнэ үү?
5. Мөрдөн байцаалтын нэгжлэг явуулах тактикийн аргыг нэрлэнэ үү ?
6. МБДША-ны тактикийн арга гэж юу вэ?
7. Байцаалтын тактикийн аргуудын талаар ярина уу?



## **Бодлого**

Иргэн Болд нь хүн зодсон гэх шалтгаанаар эрүү үүсгэгдэн сэжигтнээр тооцогдон шалгагдаж байхдаа байцаагчдаа надад мөнгө төгрөг гээд байх юм байхгүй би орь ганцаараа хүн тэгэхдээ би өмгөөлөгч авмаар байна өмгөөлөгчгүй бол байцаагдахгүй гэж хэлжээ. Гэтэл мөрдөн байцаагч чи мөнгөгүй юм бол юугаараа өмгөөлөгч авах гэсэн юм. Одоо чамд өмгөөлөгч тус болохоосоо өнгөрсөн, зүгээр л хэргээ хүлээвэл харин чамд би хөнгөн ял оногдуулж болох юм гэж байгаад иргэн Болдоос байцаалт авсан байна .

## **Асуулт:**

1. Мөрдөн байцаагч криминалистикийн тактикийн арга хэмжээ авсан уу?
2. Хэрэв та мөрдөн байцаагч байсан бол криминалистикийн тактик зүйн хувьд ямар арга хэмжээ авах байсан бэ?

## **СЭДЭВ 2. МӨРДӨХ АЖИЛЛАГАА БА ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН АРГА ХЭМЖЭЭ**

Мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтан буюу эрүүгийн төлөөлөгч, мэргэжилтэн-шинжээч, цагдаагийн байгууллагын бусад албадын ажил хэрэгч, сайн зохион байгуулсан хамтын ажиллагаа гэмт хэрэг шуурхай илрүүлэх, мөрдөн байцаах ажлын амжилтыг хангах нэг чухал нөхцөл. Хамтын ажиллагаа нь хэрэгт үнэнийг тогтоох зорилго, хүч, хэрэгсэл, цаг хугацаа, газраар өөр хоорондоо зохицсон, хууль тогтоомжид үндэслэсэн, төлөвлөгдсөн үйл ажиллагаа мөн.

Хамтын ажиллагааг санаачлагч нь мөрдөн байцаагч. Энэ нь бусад оролцогчид мөрдөн байцаагчийн шийдвэрийг идэвхгүй гүйцэтгэгч байна гэсэн үг огт биш. Гүйцэтгэх ажилтан, эксперт гэмт хэрэг мөрдөн байцаахад өөрийн оролцоог ашигтай гэж үзвэл хамтын ажиллагааг санаачлагч байж, мөрдөн байцаагчид дэмжлэг үзүүлнэ. Гүйцэтгэх ажилтан гэмт хэргийн талаар олсон шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээний мэдээг мөрдөн байцаагчид мэдээлж, түүнийг шалгах, баримтжуулах асуудлаар хамтран ажиллана. Гүйцэтгэх ажлыг үр дүнд хүргэхийн тулд мөрдөн байцаагч өөрийн санаачлагаар буюу гүйцэтгэх ажилтны хүсэлтээр түүнийг эрүүгийн хэргийн материалтай танилцуулж болно.

Хамтын ажиллагааны эрх зүйн үндэс нь:

- Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль;
- Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль;
- Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хэм хэмжээний акт, заавар болно.

Хамтын ажиллагааны агуулга түүний зорилгоор илэрхийлэгдэнэ. Хамтын ажиллагааны үндсэн зорилго нь:

- гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах;
- түүнийг үйлдсэн этгээдийг хуулиар тогтоосон журмын дагуу эрүүгийн хариуцлагад татах, материаллаг хохирлыг арилгах;
- гэмт хэрэгтэнг эрэн сурвалжлах;
- гэмт хэрэг таслан зогсоох.

Эдгээрийг нэгтгэн авч үзвэл хамтын ажиллагааны зорилго нь: ЭБШ зарим тодорхой ажиллагаа явуулах; шаардлагатай мэдээллийг гүйцэтгэх ажлын шугамаар олж авах; сэжигтэн, яллагдагч, эд мөрийн баримт, бичиг баримт, үнэт зүйлс эрэн сурвалжлах явдал мөн.



Хамтын ажиллагаа нь нэг удаагийн, богино хугацааны буюу мөрдөн байцаалт дуусах хүртэл үргэлжлэх байнгын шинжтэй байна.

Хамтын ажиллагааны гол зорилго гэмт хэрэг илрүүлэх явдал. Ийм учраас хэрэв гэмт хэргийг далд нөхцөлд үйлдсэн бол түүнийг илрүүлэх биш, шууд мөрдөн байцаах шаардлагатай бөгөөд мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтны хамтын ажиллагаа зөвхөн даалгавар өгөх байдлаар илэрнэ.

### **Хамтын ажиллагааны зарчмыг авч үзэе:**

**1. Хамтын ажиллагаа хуулийн шаардлагад нийцсэн байх.** Оролцогчдын үйл ажиллагааг эрх зүйн хувьд нарийн тогтоох, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлын байгууллагын удирдлагын зүгээс тавих хяналтаар энэ зарчим хангагдана. Оролцогчид хуулиар тогтоосон өөрийн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах нь гол шаардлага. Мөрдөн байцаагч гүйцэтгэх ажлын байгууллагад гэмт хэрэг илрүүлэх, гэмт этгээдийг тогтооход зайлшгүй шаардлагатай гүйцэтгэх ажил явуулахыг даалгах эрхтэй. Энэ даалгаварыг бичмэл хэлбэрээр өгөх бөгөөд гүйцэтгэх ажлын аппарат заавал биелүүлэх үүрэгтэй.

**2. Мөрдөн байцаалтын харьяалалыг хатуу баримтлах.** Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мөрдөн байцаах ажиллагааны хоёр хэлбэрийг заасан ба хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэгч, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаагч мөрдөн байцаалт явуулна (ЭБШХ-ийн 28.1). Энэ хоёр субъектын эдлэх эрх, гүйцэтгэх үүрэг ижил, ямар ч зааг, ялгаагүй байхад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт гэж ангилах ямар шаардлага байсан юм бол. ЭБШХ-ийн дээр дурдсан зүйлд хэрэг бүртгэлт биш, чухамхүү “...мөрдөн байцаалт явуулна” гэснээс үзэхэд ийм тусгаарлалт огт хэрэггүй болохыг хууль өөрөө нотлож байна. Ийм учраас “мөрдөн байцаах, мөрдөн байцаагч” гэж энэ номонд дурдах бүхнийг “хэрэг бүртгэх, хэрэг бүртгэгч” гэж ойлгож болно. Байцаан шийтгэх хуулийн үзэл санаанаас үзвэл мөрдөн байцаагч өөрийн харьяаллын гэмт хэрэгт эрүүгийн хэрэг шууд үүсгэж, гэмт хэрэг, түүний мөр илрүүлэх, бэхжүүлэх, гэмт буруутай этгээдийг тогтоох, баривчлах, илчлэх зэрэг байцаан шийтгэх бүхий л ажиллагааг бие даан гүйцэтгэж, үр дүнг хариуцана. Хэрэг бүртгэх байгууллага хэрэг бүртгэлт явуулах өөрийн харьяаллын гэмт хэрэгт хуульд заасан мөрдөн байцаах бүх ажиллагаа явуулж, түүний төлөө хариуцлага хүлээнэ.

**3. Мөрдөн байцаагчийн удирдах, зохион байгуулах үүрэг, мөрдөн байцаалтыг цаг тухайд нь явуулах, түүний үр дүнг бүрэн хариуцах, шийдвэр гаргахад бие даасан байх.**

**4. Хамгийн ажиллагаа тодорхой зорилготой байх.**

**5. Хамтын ажиллагаа төлөвлөгөөтэй, тасралтгүй байх.** Хамтын үйл ажиллагаа төлөвлөгөөгөөр зохицуулагдана. Мөрдөн байцаалтын явцад хамтын ажиллагааны зорилго, агуулгад нэмэлт, өөрчлөлт хийж байна. Энэ процесст мөрдөн

байцаах байгууллагын удирдлага чухал үүрэгтэй. Хамтын ажиллагааны хэлбэр, агуулгын талаарх түүний заалт, чиглэлийг мөрдөн байцаагч заавал биеспүүлнэ.

**6. Гүйцэтгэх ажилтан хуулийн хүрээнд шуурхай-эрэн сурвалжлах үйл ажиллагааны хэрэгсэл, арга барилыг бие даан сонгож авах.** Гүйцэтгэх ажилтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, баривчлах шаардлагатай арга хэмжээг бие дааж тодорхойлох; арга хэмжээнд бусад албадын хүч, хэрэгслийг татан оролцуулах; шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээ, түүний үр дүнг бүрэн хариуцахад энэ зарчим оршино.

Гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах хамтын ажиллагааны зохион байгуулалт хэд хэдэн элементтэй:

Эхнийх нь хэргийн материалд задлан шинжилгээ хийх, хамтын ажиллагааны зорилго, тодорхой гүйцэтгэгчийг тодорхойлох. Нотлох болон бусад баримт, мөрдөн байцаалтын явцыг үндэслэн хамтын ажиллагааны шаардлага, субъектыг мөрдөн байцаагч тодорхойлно.

Хоёрдахь элемент ажлын явц, үр дүнгийн тухай мэдээлэл шуурхай солилцох.

Харилцан солилцох мэдээлэл нь мөрдөн байцаалт, шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт, зохицуулалт хийх, гүйцэтгэх ажил-тактикийн хослол төлөвлөхөд чухал шаардлагатай.

Цаг тухайд нь тасралтгүй, бүрэн хэмээжгээр мэдээлэл солилцох нь мөрдөн байцаах-шуурхай хэсэг байгуулсан үед бүр ч онцгой ач холбогдолтой. Үүний хэлбэр олон янз: хэсгийн зөвөлгөөн, гишүүд хоорондын харилцан холбоо гэх мэт. Энд мөрдөн байцаалтын нууц, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх үүсвэрийг задруулахгүй байх нь чухал.

Гуравдахь элемент гүйцэтгэсэн ажил, мөрдөн байцаалтын нөхцөлт байдлын өөрчлөлтөөс гарч ирсэн засвар хийх.

Хамтын ажиллагааг нэгдмэл, зохицуулсан төлөвлөгөөгөөр зохион байгуулна. Энэ төлөвлөгөө дараах зүйлийг агуулсан байна:

- мөрдөн байцаалтын ба эрэн сурвалжлах таамаглагч;
- таамаглалаас уламжлан гарч ирсэн бүхнийг тогтоох, тодруулах бүх байдал;
- энэ байдлыг тогтоох, шинжлэхэд шаардлагатай ажиллагааны жагсаалт, түүнийг гүйцэтгэх журам;
- мөрдөн байцаагчийн гүйцэтгэх эрэн сурвалжлах арга хэмжээний жагсаалт;
  - гүйцэтгэх ажлын шугамаар тогтоох байдал (шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээ, энэ байдлыг тогтоох аргыг төлөвлөгөөнд заахгүй);
- гүйцэтгэгчид.



Шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээг гүйцэтгэх ажилтан тусд нь төлөвлөнө. Төлөвлөгдөх арга хэмжээ, мөрдөн байцаах ажиллагаа цаг, газар, дуусгах хугацаа, оролцогчдын хувьд зохицуулагдсан байвал зохино. Нэгдсэн төлөвлөгөөг мөрдөн байцаах байгууллага, гүйцэтгэх албаны удирдлага батлана.

Гэмт хэргийг “халуун мөрөөр нь” илрүүлэх, гэм буруутай этгээдийг тогтоох, эрэн сурвалжлах ажлын амжилт шууд шалтгаалдаг, мөрдөн байцаалтын анхан шатны ажиллагааны зохицуулалт, цаг тухайд нь хийсэн өөрчлөлтөөс мөрдөн байцаах ажиллагааны амжилт бүхэлдээ шалтгаална. Эрүүгийн хэрэг түдгэлзүүлэхэд эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгэх ажилтанд бүрэн даалгах биш, мөрдөн байцаагч өөрөө шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээ идэвхтэй явуулах үүрэгтэй.

### **Хамтын ажиллагааны шаардлага бий болох нөхцөл:**

1. Далд үйлдэлтэй гэмт хэрэг үйлдэгдэх (гэмт хэрэг үйлдсэн этгээд тодорхой бус байх). Ийм тохиолдолд хамтын ажиллагаа зохион байгуулахыг цагдаагийн жижүүрийн хэсэг санаачилна. Учрал болсон газар ажиллаж байгаа мөрдөн байцаах-шуурхай хэсэг нь хамтын ажиллагааны нэг хэлбэр болно. Учрал болсон газар үзлэг чанартай хийх, гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутай этгээдийг эрэн сурвалжлах, баривчлах, ажлыг нэн даруй зохион байгуулах нь энэ хэсгийн зорилго нь болно.
2. Гүйцэтгэх ажлын баримтжуулсан материалаар эрүүгийн хэрэг үүсгэх. Мөрдөн байцаагч хооронд нь уялдуулсан мөрдөн байцаах ажиллагаа, эрэн сурвалжлах арга хэмжээ явуулна, эд мөрийн баримт илрүүлэх хамтын ажиллагааг зохион байгуулна.
3. Эрүүгийн төвөгтэй хэрэг мөрдөн байцаах. Энэ нь олон үйлдэлтэй, бүлэг, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн үйлдсэн гэмт хэрэг болон өнгөрсөн жилүүдийн илрээгүй гэмт хэрэг байна. Хамтын ажиллагааны хэлбэр нь мөрдөн байцаах - шуурхай хэсэг болно.

### **Бодлого**

2011 оны 05 сарын 27-28-нд шилжих шөнө СХД-ийн 12-р хороо дэнжийн 10-р гудамжийнд Ө.Нямсүрэн бусдад онц харгис хэрцгий аргаар зодуулж нас барсан.

Анхны сэжиг, таамаг, тогтоогдсон байдал: Уг хэргийг шалагахад түүний төрсөн хүү Г.Цэрэннадмид нь төрсөн аавтайгаа хэрэг болсон шөнө хамт явж байгаад үл таних 4 залууд зодуулсан, тэр залуусын царай зүсийг тогтоож чадаагүй ч өмссөн хувцасыг нь санаж байна гэж мэдүүлж байсан юм. Энэ хэрэг маш эргэлзээтэй, нотлоход ээдрээтэй байдалтай байв. Үл таних 4 залууг эрэн сурвалжилж байсан.

Хэргийн бодит үнэн: Хохирогчийн төрсөн хүү Г.Цэрэннадмид нь танхайн сэдэлтээр төрсөн эцэгээ зодож олон тооны гэмтэл шарх учруулан санаатай алсан.

## **Асуулт.**

1. Мөрдөх алба нь ямар, ямар албадтай хамтран ажиллах ёстой вэ?
2. Мөрдөгч нь хамтын ажиллагааны ямар төлөвлөгөө гаргах вэ?



### СЭДЭВ 3. КРИМИНАЛИСТИКИЙН ТААМАГЛАЛ

1. Таамаглалын тухай ойлголт
2. Таамаглал дэвшүүлэх үе шат

**1. Мөрдөн байцаах нь танин мэдэхүйн тусгай төрөл.** Үнэнийг илрүүлэх, өөрөөр хэлбэл, гэмт хэргийн бүх байдлыг бүрэн дүүрэн, бүх талаас нь, объектив (бодит) байдлаар тогтоох нь мөрдөн байцаалтын үндсэн зорилго юм. Зөвхөн энэ л тохиолдолд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүх хэргийн талаар зөв шийдвэр гаргаж чадна. Үүнтэй холбогдуулан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг танин мэдэхүйн процесс, объектив бодит үнэнийг танин мэдэхүйн тусгай төрөл гэж үздэг. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гэмт хэргийг бүрдүүлж байгаа бүх үйл явдал, хүмүүс (хохирогч, гэрч)-ийн санаа ба материаллаг эд юмст үлдсэн дүрслэл, гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, бололцоо олгосон нөхцөл, гэмт этгээдийн хувийн байдлыг танин мэднэ.

Гэмт хэргийн талаарх төсөөлөл төдий мэдлэг таамаглалын хэлбэрээр илэрнэ. Энэ таамаглалыг шалгаснаар нотлох баримтыг тогтоох, мөрдөн байцаалт явуулснаар үйл явдлын бүх байдлыг тайлбарлах, тэгснээр цорын ганц бодит үнэнд хүрнэ.

Криминалистикийн таамаглал (criminalistics version) нь бодит баримтад үндэслэсэн, гэмт үйл явдал болон түүний зарим байдлын мөн чанар, хэрэгт тогтоогдвол зохих дээрх баримт, нотлох баримтын тухай мэдээллүүдийн хоорондын шалтгаант холбооны тухай төсөөлсөн тайлбар мөн.

Мөрдөн байцаагч өөрийн үйл ажиллагааг төлөвлөх нь мөрдөн байцаалтыг зохион байгуулах арга зүй мөн. Төлөвлөлтийн үндэс нь криминалистикийн таамаглалын нэг төрөл болох мөрдөн байцаалтын таамаглал болно.

Криминалистикийн таамаглал нь хэрэгт ач холбогдолтой байж болох нэг буюу бүлэг үзэгдлийн тухай үндэслэлтэй төсөөлөл; таамаглал энэ баримт, үзэгдэл байгаа эсэх, түүний үүсэл, агуулга, өөр хоорондын холбоог тайлбарлаж, хэрэгт үнэнийг тогтооход үйлчилнэ.

Өөрийн логик мөн чанараар таамаглал нь бүрэн биш, төсөөлөл төдий мэдлэгээс бүрэн мэдлэгт хүрэх бололцоог хангадаг, сэтгэхүйн нарийн төвөгтэй хэлбэр болох таамнал (гипотез)-ын нэг төрөл. Таамнал шинжлэх ухааны, тусгай, ажлын (түр зуурын) гэж байна.

Шинжлэх ухааны таамнал нь байгаль, нийгэм буюу сэтгэхүйн хөгжлийн зүй тогтлын тухай төсөөлөл. Нэг буюу хэд хэдэн баримт, үзэгдэлд хамаарч, зөвхөн

тэдгээрийг тайлбарладгаараа тусгай таамнал шинжлэх ухааныхаас, ажлын буюу түр зуурын таамнал нэг буюу хэд хэдэн баримтад цаашид хийх шинжилгээнд чиглэсэн, түр зуурын шинжтэй болзолт (нөхцөлт) тайлбар өгдгөөрөө тусгайгаас тус тус ялгагдана.

Криминалистикийн таамаглалыг тусгай таамналын өвөрмөц төрөл гэж ойлгох хэрэгтэй. Криминалистикийн таамаглал тусгай бусад таамналаас дараах байдлаар ялгаатай;

- нийгмийн практикийн өвөрмөц хүрээ - эрүүгийн шүүн таслах ажиллагаанд бүтээгдэж ашиглагдана,
- хуулиар тусгайлан эрх олгогдсон албан тушаалтанд нийцүүлж шалгана;
- хэрэгт үнэнийг тогтооход ач холбогдолтой үйл явдал, үйлдлийг тайлбарлана,
- хуулиар тогтоосон хугацаанд шалгагдах учиртай,
- хуулиар тогтоосон нөхцөлд өвөрмөц арга зүйгээр,
- үнэнийг нуух сонирхолтой этгээдийн идэвхтэй эсрэг үйлдлийн нөхцөлд шалгагдана.

Таамаглалын төрөл. Криминалистикийн болон тооны таамаглалыг дараах үндсэн төрөлд хуваана

- дэвшүүлэх субъектээр нь - мөрдөн байцаалтын, шуурхай-эрэн сурвалжлах, шүүхийн, шинжилгээний;
- хэмжээгээр (тайлбарлах баримтын) нь - ерөнхий ба тусгай;
- нотолгооны зүйлд хамаарахаар нь - яллах, цагаатгах

Гэмт хэргийн зарим байдал: шалтаг, сэдэлт, арга, цаг, газар, гэмт хэрэгтний нуугдаж буй газар; хэн үйлдсэн байж болох; хохирогч хэн болох (жишээлбэл, хүн алах, үл танигдах хүүр илрүүлэх) зэрэг гэмт хэргийн зарим байдлын тухай төсөөлсөн сэтгэлэг агуулга нь болсон таамаглалыг тусгай гэнэ.

Тусгай таамаглал нь зарим мөрний үүсэл, гэмт хэрэгтний ашигласан багаж, зэвсгийн төрөл, шинж, учрал болсон газар байгаа бусад эд зүйл, тэр нь гэмт хэрэгтний үйлдэлтэй холбоотой эсэхийг тайлбарлана.

Ерөнхий ба тусгай таамаглал дэвшүүлэх, шалгах нь өөр хоорондоо холбоотой процесс. Зарим тохиолдолд мөрдөн байцаагч өөрийн бодлыг бодит байдал, түүний хэсгээс үйл явдлыг бүхэлд нь төсөөлөн тайлбарлахад; нөгөө тохиолдолд хэргийн бүх материалыг үнэлэх, ерөнхий таамаглал дэвшүүлэхээс зарим баримтын үүслийн төсөөлөл рүү чиглүүлнэ. Жишээлбэл, хүн алах зарим гэмт хэрэг мөрдөн байцаахад эхлээд гэмт хэрэг үйлдсэн арга, шалтаг, зарим мөрний талаар тусгай таамаглал дэвшүүлж болно. Хуучин хэргийг мөрдөн байцаахад ихэвчлэн эхлээд ерөнхий, дараа тусгай таамаглал дэвшүүлдэг.



Мөрдөн байцаалтын таамаглал агуулгаараа гэмт хэргийн бүрэлдэхүүн бий болгодог, нотлогдвол зохих байдлын нийлбэрийг өөртөө агуулсан байна. Энэ таамаглалыг дэвшүүлэх, шалгах процесс бүхэлдээ мөрдөн байцаалтын явцад нотлох баримт цуглуулах, шинжлэх, үнэлэх онцлогоос шалтгаална.

Шуурхай-эрэн сурвалжлах таамаглал нь эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө, эсхүл мөрдөн байцаалттай зэрэгцүүлэн шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээ зохиож байгаа гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааны явцад бий болно. Эрэн сурвалжлах таамаглал дэвшүүлж, шалгаснаар нотлох баримтын эх үүсвэрийг тогтоож, нуугдсан гэмт хэрэгтэн, хулгайлагдсан эд зүйлийг илрүүлж, сураггүй алга болсон хүнийг эрэн сурвалжлах жишээтэй. Мөрдөн байцаах, эрэн сурвалжлах таамаглал хоорондоо холбоотой. Шуурхай-эрэн сурвалжлах үйл ажиллагаа эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө зохиогдож байгаа бол эрэн сурвалжлах таамаглалыг харгалзан мөрдөн байцаалтын таамаглал дэвшүүлнэ. Мөрдөн байцаах ажиллагаа, шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээг хослон явуулахад мөрдөн байцаах, эрэн сурвалжлах таамаглалыг зэрэг шалгана. Шалгалтыг шуурхай-эрэн сурвалжлах, байцаан шийтгэх хэрэгслээр явуулна. Гэвч мөрдөн байцаах ажиллагаа явуулснаар олсон баримт нотолгооны ач холбогдолтой. Мөрдөн байцаах таамаглалыг шуурхай-эрэн сурвалжлах шугамаар шалгаж болох боловч олсон баримт нотолгооны ач холбогдолгүй. Ийм баримт нь нотлох баримт эрэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах замаар таамаглал шалгахад зөвхөн чиглэл болно.

Экспертийн таамаглалыг шинжилгээний объект, мөрний үүсэл, тэдгээрийг тодорхойлж байгаа шинж тэмдгүүдийн холбоо, үзэгдлийн шалтгааныг тайлбарлах зорилгоор дэвшүүлнэ. Ийм таамаглал нь экспертийн шинжилгээний органик хэсэг, бөгөөд түүнийг дэвшүүлэх, шалгах нь шинжилгээний объект, экспертэд тавьсан асуулт, шинжилгээний арга зүйгээс шалгаална. Экспертийн зөвшөөрсөн (баталсан) дүгнэлтийг мөрдөн байцаагч тусгай нэг таамаглал гэж үзэж мөрдөн байцаах, шуурхай-эрэн сурвалжлах ажиллагааны хэрэгсэл, арга барилаар шалгана.

Криминалистикийн таамаглалын энэ төрлүүдээс гадна загварчилсан таамаглал гэсэн ойлголт байдаг. Энэ нь гэмт хэргийг төрлөөр нь загвар болгож жишээлбэл, хүн алах гэмт хэрэгт: амиа хорлох, гэнэтийн осол, бусдад алагдсан гэх мэтээр дэвшүүлсэн таамаглал байна.

**2. Мөрдөн байцаах ажиллагаа дахь таамаглалын үндсэн шинж.** Гэмт хэрэг мөрдөн байцаахад таамаглал нь дараах үндсэн шинжийг агуулсан байх учиртай:

а) Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч (эксперт, гүйцэтгэх ажилтан) эд юмс, үзэгдэл; гэрч, хохирогч, яллагдагч, сэжигтний мэдүүлэг, бусад бичиг баримтыг өөрөө шууд судласны үр дүнд гаргаж авсан баримтын тухай мэдээ дээр үндэслэсэн байх. Баримтын тухай мэдээлэл таамаглалын суурь, түүний үндэслэл болно. Таамаглалын бодит эсэх нь баримтын тухайн мэдээллийн үндэслэлээс шалтгаална.

Мөрдөн байцаалтад зөвхөн бодит таамаглал дэвшүүлнэ;

- b) Шинжлэх ухааны баримтад тохирсон байх. Жишээлбэл, нас барсан шалтгаан нь шүүх эмнэлгийн дүгнэлттэй харшилж болохгүй, шаталтыг тайлбарласан шалтгаан, шатах мөн чанарын тухай химийн үзэл баримтлалтай нийцэх ёстой;
- c) Бодит төсөөлөл байх. Гэмт хэрэг бүрдүүлж буй бодит баримтыг тайлбарлах, нотлох баримт шинжлэхийн тулд таамаглал дэвшүүлнэ;
- d) Логикийн хувьд зөв дэвшүүлсэн, энгийн ба хоорондоо зөрчилгүй байх, сэтгэлгээний явц зөв байх. Хутгалдсан, өөр хоорондоо зөрчилтэй таамаглал хэзээ ч үнэнд хүргэхгүй.

Таамаглал дэвшүүлэх. Мөрдөн байцаалт, эрэн сурвалжлах таамаглал дэвшүүлэх асуудлыг бид урьд авч үзсэн учир зарим ерөнхий зүйлийн тухай ярилцая.

Таамаглал өөрийн үндэслэлээс шалтгаалахгүй шалгагдвал зохих төсөөлөл учраас түүний анхны баримтыг зохиомлоор явцууруулах нь зохисгүй юм гэж үзэх боллоо.

Таамаглал дэвшүүлэх суурь болсон бодит баримтыг байцаан шийтгэх (нотлох баримт), байцаан шийтгэх бус (чиглүүлэх мэдээлэл) эх сурвалжаас олж авч болно. Агуулагдсан мэдээлэл нь үнэний хувь багатай бол ямар ч эх сурвалж байцаан шийтгэх бус эх сурвалжид хамаарна.

Анхны баримтад тулгуурласан таамаглал нь түүнийг зүгээр л тайлбарлах биш, харин өөр хоорондын бүх төрлийн холбоог нээж байх шаардлагатай, хараахан тогтоогдоогүй үйл явдлын төсөөлөл байдаг учир түүний агуулга анхны баримтынхаас ямагт өргөн хүрээтэй байна. Иймд анхны баримтын агуулга бүрэн хэмжээгээр таамаглалын агуулгад багтаж байх ёстой. Хэрэв таамаглал түүнийг дэвшүүлэх үед байсан бүх бодит баримтыг тайлбарлаж чадахгүй бол энэ нь:

1. таамаглалын гадна байгаа байдал тухайн үйл явдалд хамаарахгүй, түүнтэй холбоогүй;
2. таамаглал бүхэлдээ бодит биш, баримт хоорондын объектив холбоог тусгаагүй, мөрдөн байцаалтын чиглэлийг тодорхойлж чадаагүй ба түүнийг солих хэрэгтэй;
3. таамаглалд засвар, нэмэлт, тодотгол хийх шаардлагатай гэсэн үг.

Таамаглал дэвшүүлэхэд задлага ба нийлэг, индукци ба дедукци гэсэн логик сэтгэхүйн арга барилыг өргөн ашиглана.

Гэмт хэрэг бүртгэх, мөрдөн байцаахад бололцоотой бүх таамаглал дэвшүүлэх хэрэгтэй. Таамаглал олон байснаар хэргийн байдлыг бүх талаас нь, бүрэн дүүрэн, объективноор шалган тогтоох шаардлага хангагдана. Ингэснээр алдаа гаргах, буруу таамаглахаас зайлсхийж чадна. Яллагдагчийн гэм буруу тогтооход нэг таамаглалаар



хязгаарлаж огт болохгүй. Заавал эсрэг таамаглал (гэм бурууг үгүйсгэсэн) байх хэрэгтэй. Таамаглалыг зөвхөн бодит байдлаас биш зарим нотлох баримт, түүний эх сурвалж үнэн мөнөөс дэвшүүлж болно. Ийм таамаглалыг шалгах нь нотлох баримтыг зөв үнэлэх бололцоо өгч мөрдөн байцаалтыг нэмэгдэл мэдээллээр баяжуулна.

Гэмт хэргийн байдал, шалтаг, зорилго, арга, түүнчлэн яллагдагчийн мэдүүлгээс дэвшүүлсэн таамаглал онцгой ач холбогдолтой. Хэргийн бодит байдал тодорхойгүйн үнэн, мэдүүлэг нь шалгавал зохих, байж болох тайлбар учраас түүнийг таамаглал гэж үзнэ.

Таамаглал шалгах. Таамаглалыг дараах байдлаар шалгана. Хэрэв таамаглал зөв бол ямар баримт байх ёстой, ямар баримт байх учиргүйг тодорхойлно. Энэ баримтууд байгаа эсэхийг тогтооход таамаглал шалгахын учир оршино. Шаардлагатай баримтыг байцаах шийтгэх шугамаар, өөрөөр хэлбэл мөрдөн байцаах ажиллагаа явуулснаар олж авна. Таамаглалыг мөн шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээ явуулах замаар шалгаж болох боловч энэ шалгалт нь зөвхөн урьдчилсан, чиглүүлэх шинжтэй байх ба түүний үр дүнг байцаан шийтгэх ажиллагаагаар баримтжуулсан байна.

Боломжтой бүх таамаглалыг дэвшүүлэх, шалгах шаардлагатайг бид энэ бүлэгт нилээд тодорхой өгүүлсэн болой. Мөрдөн байцаалтын таамаглалын тухайд бол таамаглал нь мөрдөн байцаалтын зохион байгуулалтын эхлэл, үйл ажиллагааны төлөвлөлтийн цөм мөн.

Бүх таамаглалыг чиглэсэн зорилготойгоор шалгах явдал төлөвлөгөөгүйгээр хангагдахгүй гэдгийн анхаарах ёстой.

## **Бодлого**

Хэргийн газар дээрх байдал: Цагдаагийн хэлтсийн жижүүрийн бүрэлдэхүүн онц хүнд гэмт хэргийн дуудлагаар ирж үзлэг хийж байв. Хэргийн газарт очиж үзлэг шалгалт явуулахад хохирогч эмэгтэй орон дээр хэвтсэн, хажуудаа гэрээслэл бичиж үлдээсэн, гэрийнхээ түлхүүрийг гэрээслэлийн хажууд тавьсан, түүний биед үүссэн гэмтэл шархгүй, ямар нэгэн зүйлээр бөөлжсөн байдалтай нас барсан байв.

Хохирогч эмэгтэй хүнсний цууны хүчил буюу “Уксус” уусаны улмаас хордсон нь үхлийн шалтгаан болсон, хохирогчийг зөөвөрлөсөн байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн, нөхөр “З”-гийн зан авир, болон хохирогчийг зодож дарамталдаг байсан зэрэг нь тогтоогдсон.

## **Асуулт:**

1. Энэ хэрэг дээр ямар, ямар таамаглалыг дэвшүүлэх вэ?
2. Дэвшүүлсэн таамаглал бүрийнхээ үндэслэлийг тайлбарлана уу?

## **СЭДЭВ 4. МӨРДӨХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

1. Мөрдөх ажиллагааны төлөвлөлт
2. Мөрдөх ажиллагааны төлөвлөлтийн зарчмууд
3. Мөрдөх ажиллагааны зохион байгуулалт

1. Төлөвлөлт нь мөрдөн байцаалтын чиглэл, зорилго, тэдгээрийг хуулийн хүрээнд шийдвэрлэх арга, хэрэгслийг тодорхойлоход мөн чанар нь оршдог сэтгэхүйн төвөгтэй процесс. Төлөвлөлт үнэнийг тогтоох хэрэгсэл болдоггүй учир мөрдөн байцаалтын арга зүй биш. Төлөвлөлт энэ үйл ажиллагааг гүйцэтгэснийг харуулахгүй, зөвхөн тавьсан зорилгод хүрэх утгар, нөхцөл өөрөөр хэлбэл, мөрдөн байцаалтын зохион байгуулалтын арга зүй. Энэ утгаар нь түүнийг мөрдөн байцаалтын зохион байгуулалтын үндэс гэж үзэх хэрэгтэй.

Зорилгоо дэвшүүлэх, түүнийг шийдвэрлэх арга, зам, шаардлагатай ажиллагааны дараалал тогтоох, хүч хэрэгсэл хуваарилахад төлөвлөлтийн зохион байгуулах үүрэг оршино. Энэ бүхнийг мөрдөн байцаалтын зохион байгуулалтын элемент гэнэ.

Төлөвлөлтийн логик ийм элементийг мөрдөн байцаалтын таамаглал гэж бид мэднэ. Гэхдээ таамаглал төлөвлөлтийн цорын ганц үндэс гэж үзэж болохгүй.

Таамаглал шалгахад шаардлагатай мөрдөн байцаах ажиллагааг төлөвлөх нь төлөвлөгөөний гол хэсэг байх нь мэдээж. Үүнээс гадна мөрдөн байцаалтын төлөвлөгөө байцаан шийтгэх бусад: ял сонсгох, хохирол барагдуулах явдлыг хангах, хохирогчоор тогтоох зэрэг ажиллагаа болон зохион байгуулалт - техникийн арга хэмжээг тусгасан байна.

Логикоос гадна мөрдөн байцаалтын төлөвлөлтөд байцаан шийтгэх ба тактикийн үндэс гэж байдаг. Тодорхой хугацаанд заавал гүйцэтгэсэн байх байцаан шийтгэх ажиллагааны тухай хуулийн хэм хэмжээг байцаан шийтгэх; өөрийн үйл ажиллагааны хугацаа, журам, таамаглал шалгах дараалал, хэн гүйцэтгэх, мэргэжилтэнтэй хамтран ажиллах хэлбэрийг тодорхойлсон, мөрдөн байцаагчийн удирдлага болгосон санааг тактикийн үндэс гэж тус тус нэрлэнэ.

Мөрдөн байцаалтын төлөвлөлтөд зорилго, зарчим, нөхцөл, агуулга (элемент), шат, хэлбэр гэж байна. Бүх шатанд үйл ажиллагааны чиглэл, агуулгыг тодорхойлох, түүний бүрэн дүүрэн, бүх талаас нь, объектив, түргэн шуурхай байх, цаг хугацаа, хүч, хэрэгслийг үр ашигтай ашиглах, хэмнэх явдлыг хангахад төлөвлөлтийн зорилго оршино. Төлөвлөлтийн бүх процесс хууль ёс хэлбэрэлтгүй сахих үзэл санааг удирдлага болгосон байх нь мэдээж.



### **Мөрдөн байцаалтын төлөвлөлтийн зорилго:**

- мөрдөн байцаалт бүрэн дүүрэн, бүх талаас нь, объектив байх;
- мөрдөн байцаалт тодорхой зорилготой, бодит зорилгыг биелүүлэх чиглэлтэй байх;
- энэ зорилгод цаг, хүч, хэрэгсэл бага хэмжээгээр зарцуулж хүрэх;
- мэргэжилтэн, шуурхай - эрэн сурвалжлах аппаратын ажилтантай хамтран ажиллах явдлыг хангахад оршино.

Төлөвлөлтийн зорилго нь мөрдөн байцаалтын зарчмын шаардлагад захирагдана.

Төлөвлөлтийн процесст баримтладаг, суурь болсон үзэл баримтлалыг төлөвлөлтийн зарчим гэнэ. Төлөвлөлт бодьгал, хөдөлгөөнтэй, бодит байх нь түүний зарчим.

Төлөвлөлт бодьгал байх гэдэг нь тодорхой гэмт хэргийг мөрдөн байцаах онцлогийг харгалзахын чухлыг хэлнэ. Эрүүгийн бүх хэрэгт мөрдөн байцаах төлөвлөгөөний нэгдсэн загвар боловсруулах бололцоо байхгүй. Гэвч мөрдөн байцаалтын төсөөтэй байдал байгаа үед тодорхой категорийн хэрэг мөрдөн байцаах загварчилсан төлөвөгөө байхыг үгүйсгэхгүй.

Мөрдөн байцаалтын бүх процессын туршид төлөвлөгөө уян хатан, хөдлөлтэй байх, мөрдөн байцаалтын ашиг сонирхолд нийцсэн засвар түүнд оруулах шаардлагыг төлөвлөлт тасралтгүй (хөдөлгөөнтэй) байх зарчим гэнэ. Бичсэн төлөвлөгөө бүрэн боловсорсон гэсэн үг биш. Төлөвлөгөө байнга өөрчлөгдөж, түүнд нэмэлт оруулж байх шаардлагатай. Энэ өөрчлөлт, нэмэлтийг урьдчлан харж чадахгүй. Жишээлбэл, нэг таамаглалыг шалгахад нөгөө нь шаардлагагүй болж, магадгүй шинэ таамаглал дэвшүүлэх шаардлага гарч болно. Байнга өөрчлөлт хийж байх шаардлага нь мөрдөн байцаах төлөвлөгөөг бусад төлөвлөгөөнөөс зарчмын хувьд эрс ялгаж өгнө.

Төлөвлөлт бодит байх нь энэ процессын чухал, гол чанарын нэг. Зөвхөн төлөвлөснөө зүгээр л нэг биелүүлэх биш, заасан хугацаанд нь тодорхойлсон хэрэгслээр гүйцэтгэх бодит бололцоонд энэ зарчим илэрнэ. Төлөвлөлт бодит байх нь тухайн байдлын нөхцөл урган гарсан байхыг мөн хэлнэ.

Төлөвлөгөөнд ямар нэг таамаглал шалгах бүх асуулт, хийх шаардлагатай мөрдөн байцаах ажиллагаа, шуурхай-эрэн сурвалжлах болон бусад бүх арга хэмжээ, түүнийг гүйцэтгэх хугацаа, гүйцэтгэгчийг заасан байна. Гэрчийг байцаах, сэжигтний гэрт нэгжлэг хийх гэх мэт мөрдөн байцаалтад ямар ч ач холбогдолгүй ерөнхий зүйл төлөвлөгөөнд байж болохгүй.

Хууль ёс сахих, шинжлэх ухааны үндэслэлтэй байх гэх мэт төлөвлөлтийн зарчмын тухай олон эрдэмтэд бичсэн байдаг. Гэвч тэр бүхэнд мөрдөн байцаалтын төлөвлөлтийг үйл ажиллагааны бусад хүрээний төлөвлөлтөөс ялгах тийм өвөрмөц

онцлог ажиглагдахгүй байна. Ямар ч төлөвлөгөө боловсруулахад хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомж, шинжлэх ухааны ололт, бусад хүчин зүйлийг харгалзан үзэх нь хэн бүхэнд ойлгомжтой хэрэг.

Төлөвлөлтийн нөхцөл нь төлөвлөгөөг биелүүлэх, биелэх бололцоотой болгож байгаа тодорхой байдал, хүчин зүйл, мэдлэг, чадварын цогц мөн.

**Ийм нөхцөл нь:**

- анхны мэдээлэл байх;
- төлөвлөлтийн үед мөрдөн байцаалтын байдлыг үнэлэх, төлөвлөсөн ажиллагааг биелүүлсний үр дүнд гарах түүний өөрчлөлтийг урьдчилан дүгнэх. Энэ үнэлэлт нь тактикийн эрсдэл (зайлшгүй буюу байж болох)-ийн хэмжээг тодорхойлох явдлыг өөртөө агуулна;
- төлөвлөсөн зорилгод хүрэх бодит бололцоо, хэрэгсэл, арга зүйг харгалзах. Хүч, хэрэгслийн бололцоог хэт үнэлвэл төлөвлөгөө үл биелэгдэх зүйл болох ба харин дутуу үнэлвээс төлөвлөгөө илүү ажил болж мөрдөн байцаалтыг сунжруулсан, хүч, хэрэгсэл үргүй зарцуулсан хэрэг болно.

**2. Төлөвлөлтийн агуулга (элемент):**

- анхны мэдээлэл задлан шинжлэх;
- таамаглал дэвшүүлэх, мөрдөн байцаалтын зорилгыг тодорхойлох;
- төлөвлөсөн зорилгоо шийдвэрлэх арга, замыг тодорхойлох;
- төлөвлөгөө болон шаардлагатай бусад бичиг баримт боловсруулах;
- гүйцэтгэлийг хянах, төлөвлөгөөнд засвар оруулахаас бүрдэнэ.

Энэ элементүүдийн нийлбэр нь төлөвлөлтийн шатны агуулга болно. Дараагийн шат бүрт урьд хүрсэн түвшнийн элементүүдийг нарийвчлан тодруулна. Төлөвлөлт нь нотолгооны бүх процессыг багтаадаг учир энэ элементүүд давтагдаж болно: шинэ таамаглап дэвшүүлэх, мөрдөн байцаах өөр ажиллагаа явуулах шаардлага гарах, шинэ мэдээлэл хүлээн авах гэх мэт. Төлөвлөлт мөрдөн байцаалтын шаттай зохицож байна.

Мөрдөн байцаах процесс нь анхан, дараах, төгсгөлийн гэсэн гурван шатанд хуваагдана. Энэ шатууд нь шийдвэрлэх зорилго, түүнд хүрэх зохион байгуулалт, хэлбэрээр өөр хоорондоо ялгагдана. Энэ ялгаа нь мөрдөн байцаагчийн үйл ажиллагааны зохион байгуулалтын эхлэл болсон шат бүр төлөвлөлтийн өвөрмөц онцлогтой байхыг шаардана. Ийм учраас мөрдөн байцаалтад байгаа шатыг мөн төлөвлөлтөд хамааруулж, шат бүрийн агуулгыг яаж ойлгож байгаагаас шалтгаалан хоёр буюу гурван (анхан, дараах буюу төгсгөлийн, дараах ба төгсгөлийн) шатаар авч үзэх хэрэгтэй болов:



Мөрдөн байцаалтын анхан шатны төлөвлөлт нь мэдээллийн тодорхой бус байдлаар тодорхойлогдоно. Анхны баримтын хомс байдал энэ шатны эхэнд нийтлэг шинжтэй таамаглалаар хязгаарлагдахад хүргэнэ. Энд төлөвлөлт, мөрдөн байцаалтын дараагийн шатанд шилжих нотолгооны үндсийг өргөтгөж өгдөг өөрийн мөн чанараараа мөрдөн байцаалтын хойшлуулшгүй тийм ажиллагаа хамаарна. Энэ нь учрал болсон газар үзлэг хийх, харсан хүн, бусад гэрчийг байцаах, сэжигтэнд нэгжлэг хийх гэх мэт. Анхан шатанд энэ ажиллагааны зорилго, дараалал, оролцогчид, зохион байгуулалтыг тодорхойлно.

Мөрдөн байцаалтын анхны үйл ажиллагааны зорилгыг тодорхойлох нь шийдвэрлэх асуулт, тэгснээр гарган авч болох нотлох баримтыг танин мэдэхийг шаардана. Үүнээс гадна төлөвлөсөн ажиллагааг хаана, хэзээ, хэн хэнийг оролцуулж, техникийн ямар хэрэгсэл ашиглаж явуулахыг заана.

Анхны баримтын хязгаарлагдмал байдал нь төлөвлөлтөд зөвхөн хувийн туршлага, криминалистикийн арга зүйд түшиглэн ажиллахад хүргэнэ.

Мөрдөн байцаалтын анхан шатны ерөнхий зорилгоос авч үзвэл төлөвлөгөөнд тусгагдах мөрдөн байцаах ажиллагааны үлгэрчилсэн дарааллыг дараах байдлаар илэрхийлж болно:

- Байгалийн хүчин зүйлийн нөлөө буюу түүнтэй болгоомжгүй харьцсанаас өөрчлөгдөх, эсхүл сонирхогч этгээд устгаж болзошгүй нотлох баримт, ялангуяа, эд мөрийн баримтыг бүрэн цуглуулах явдлыг хангах ажиллагаа. Энэ нь юуны өмнө учрал болсон газар хийх үзлэг. Янз бүрийн шалтгаанаар хожим нь байцаах боломжгүй хохирогч, гэрч (нас барж байгаа хүн, яаралтай ажил болон амьдрал, ахуйн хүндэтгэх шалтгаанаар яваа хүмүүс гэх мэт)-ийг байцаах нь дээрхтэй төсөөтэй зорилго бүхий хойшлуулшгүй ажиллагаанд хамаарна;
- Мөрдөн байцаалтын хугацааг удаашруулж болзошгүй урт хугацаа шаардах ажиллагаа. Жишээлбэл, зарим төрлийн экспертиз (шүүх эдийн засгийн, шүүх барилгын гэх мэт). Нөхцөл нь хангагдагмагц ийм экспертиз хийлгэж шийдвэрийг нэн даруй гаргана;
- Гүйцэтгэх хугацааг нь хуулиар тогтоосон ажиллагаа (таслан сэргийлэх арга хэмжээ авах, эд хөрөнгө битүүмжлэх, бичиг баримт хурааж авах гэх мэт);
- Хэд хэдэн таамаглал шалгах ажиллагаа.

Мөрдөн байцаалтын анхан шатны ажиллагаа төлөвлөхдөө түүнийг шуурхай - эрэн сурвалжлах арга хэмжээтэй зохицуулах хэрэгтэй. Үүнийг төлөвлөгөөнд гүйцэтгэх ажил эрхэлдэг албанд даалгавар өгөх хэлбэрээр заана. Тухайлбал, хүн, эд зүйл, бичиг баримт эрэн сурвалжлах гэх мэт.

Мөрдөн байцаах ажиллагаа, шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээг хугацаа, зорилгоор нь зохицуулна.

Гүйцэтгэх ажлын материалаар эрүүгийн хэрэг үүсгэсэн үеийн мөрдөн байцаалтын анхан шатны төлөвлөлт өөрийн онцлогтой. Энэ тохиолдолд мөрдөн байцаалтын анхан шатны ажиллагааны төлөвлөгөөгөөр гүйцэтгэх ажлын мэдээлэл шалгах төлөвлөгөөний биелэлтийг хангана. Байцаах, нэгжих гэх мэт мөрдөн байцаах ажиллагаа явуулахдаа гүйцэтгэх ажлын мэдээллийн эх үүсвэрийг задруулахгүйн тулд тактикийн зохих арга барил ашиглана.

Орчин үед энэ шатанд тавигдах болсон нэг чухал зорилго нь хохирогч, гэрчийн аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэ зорилго зохион байгуулалтын шинжтэй бөгөөд төлөвлөгөөнд тусгайлан тусгагдана.

Мөрдөн байцаалтын дараах шатны төлөвлөлт нь мөн л энэ шатны ерөнхий зорилго нь нотолгооны процессоос их хэмжээгээр хамааралтай. Тухайн шатанд мөрдөн байцаагчийн ажиллагаа нотлох баримт цуглуулахаар зогсохгүй, түүнийг нарийвчлан үнэлэх, системчлэхэд чиглэнэ. Цуглуулсан мэдээлэл дэвшүүлсэн таамаглалыг үнэлэх, шинээр солих буюу шаардлагатай засвар оруулах бололцоо өгнө. Шаардлагатай бүх экспертиз хийлгэх, нэмэлт байцаалт, үзлэг, заримдаа давтан нэгжлэг хийх асуудлыг төлөвлөнө.

Сэжигтэн, яллагдагч, тэдгээрийн өмгөөлөгчийн байр суурь энэ шатны төлөвлөлтөд ихээхэн нөлөөлнө. Гэм буруугаа үгүйсгэсэн, худал мэдүүлэг өгсөн тохиолдолд алибыг шалгах ажиллагаа, нүүрэлдүүлэн байцаах, нарийвчилсан давтан байцаалт явуулах, дурдсан этгээдийн хүсэлтийг хангахад чиглэсэн ажиллагааг төлөвлөгөөнд заана. Мөн нуугдаж байгаа сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлах ажиллагааг төлөвлөнө.

Тасралтгүй (хөдөлгөөнтэй) байх зарчим энэ шатанд илүү тод харагдана. Шинэ мэдээлэл олох, шинэ таамаглал дэвшүүлэх буюу хуучныг өөрчлөх, урьд мэдэгдээгүй янз бүрийн байдалтай холбоотойгоор төлөвлөгөөнд байнга засвар хийж байх нь ердийн үзэгдэл болдог.

Мөрдөн байцаалтын төгсгөлийн шатны төлөвлөлт. Энэ шатанд шилжих нь мөрдөн байцаалт зорилгодоо хүрлээ гэсэн үг: хэрэгт үнэн тогтоогдов, субъектын гэм буруу буюу гэм буруугүй бүрэн тодорхой болов, хэргийг хэрэгсэхгүй болгох хэрэгтэй.

### **Энэ шатанд дараах ажиллагаа төлөвлөгдөнө:**

- яллагдагч, түүний өмгөөлөгчийг хавтаст хэрэгтэй танилцуулах;
- яллагдагч, түүний өмгөөлөгчийн хүсэлтийг шийдвэрлэх;
- хяналт тавьж байгаа прокурор, мөрдөн байцаах байгууллагын удирдлагын зааварчлагыг биелүүлэх;
- цуглуулсан нотлох баримтыг үнэлснээр мөрдөн байцаагч өөрийн санаачлагаар гүйцэтгэх нэмэгдэл ажиллагаа.



Мөн ял төлөвлөх, хэрэгт хавсралтыг бэлтгэх, хавтаст хэргийг цэгцлэх ажил төлөвлөгдөнө.

Шүүхээс нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр хэрэг буцаасан бол төлөвлөгөөнд шүүхийн заалтыг биелүүлэх ажиллагааг заана.

### **Мөрдөн байцаалтыг хэсгээр явуулах үеийн төлөвлөлтийн онцлог**

Хэсгийн ажлыг зохион байгуулах асуудал нэгдүгээрт тавигдана. Хоёр төрлийн: ерөнхий - хэсгийн ажил бүхэлдээ, хэсгийн гишүүдийн нэг бүрчилсэн төлөвлөгөө боловсруулна.

Ерөнхий төлөвлөгөөнд таамаглал буюу үйл явдлын хэсгийг шалгах, гишүүн тус бүрийн зорилго, үүргийг заана. Хуваарилсан үүрэг биелүүлэх тодорхой ажиллагаа нэг бүрчлэн төлөвлөгөөнд тусгагдана.

Мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажлын томоохон хэсэг ажиллах болвоос гишүүдийн үйл ажиллагааг зохицуулах, мэдээлэл шуурхай солилцох явдлыг хангахын тулд хэсгийн штаб байгуулж болох бөгөөд түүний ажлыг ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөнө.

Төлөвлөлтийн хэлбэр нь түүний гадаад илрэл. Дотоод сэтгэлийн ба бичмэл гэсэн төлөвлөлтийн хоёр хэлбэр байна.

Дотоод сэтгэлийн хэлбэр. Хамгийн энгийн хэрэг мөрдөн байцаахад бичмэл төлөвлөгөө боловсруулахгүй байх практик бий. Гэвч ямар ч тохиолдолд программын шинжтэй бичмэл ямар нэгэн тэмдэглэл байх хэрэгтэй: мөрдөн байцаах ажиллагаа, байцаах гэрчийн нэрийн болон үзлэг хийх объектын жагсаалт гэх мэт. Энэ нь нэг л хэлбэрийн бичмэл төлөвлөгөө. Гэмт хэрэг илрүүлэхэд мөрдөн байцаагч, цагдаагийн байгууллагын шуурхай-эрэн сурвалжлах ба бусад албадын хамтын ажиллагаа шаардлагатай тохиолдолд бичмэл төлөвлөгөө заавал боловсруулна.

### **Бичмэл төлөвлөгөөг чөлөөт хэлбэрээр хийх**

Практикт бичмэл төлөвлөгөөний дараах хамгийн энгийн хэлбэр ашигладаг.

Хэрэг дээр хэд хэдэн мөрдөн байцаагч ажиллаж байгаа бол “гүйцэтгэгч” гэсэн хүснэгт нэмнэ. Хэрэв мөрдөн байцаах ажиллагаа буюу тактикийн хослол хийх шаардлагатай үед “тактикийн тэмдэглэл” хүснэгт нэмнэ.

Төлөвлөгөөнд нэмэлт болгож ямар нэг процесст хяналт тавих, цуглуулсан нотлох баримтыг системчлэх зорилгоор гэмт хэргийн хэсгээр тодорхой этгээдийн гэм бурууг нотлох баримтаар системчлэсэн “схем-шатар” боловсруулна. Ийм схемийн босоод - гэмт хэргийн хэсэг, хөндлөнд - түүнд оролцогчдыг заана; хүснэгтийн огтлолцол нь тухайн этгээд гэмт хэргийн энэ хэсэгт оролцсон, эсхүл

үгүйг үзүүлнэ. Гэм буруугийн нотлох баримтыг яллагдагч бүрийн карт буюу бусад аргаар системчлэж болно.

Эрүүгийн хэд хэдэн хэрэг дээр ажиллаж байгаа тохиолдолд календарчилсан (долоон хоногийн) төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ төлөвлөгөөнд заагаагүй мөрдөн байцаах буюу шинээр хүлээн авсан эрүүгийн хэрэгт хийх ажиллагааг явуулах шаардлага гарч болзошгүй тул долоон хоногийн нэгээс хоёр өдрийг хоосон үлдээнэ.

Эцэст нь тэмдэглэхэд гэмт хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах нь өндөр зохион байгуулалт, гүн гүнзгий хандлага, чин эрмэлзлэл шаардсан төвөгтэй, олон талт үйл ажиллагаа. Тийм ч төвөгтэй биш эрүүгийн хэрэг л гэхэд мөрдөн байцаах, эрэн сурвалжлах болон бусад хэд хэдэн ажиллагаа явуулахыг шаардана. Энэ арга хэмжээ нь сайн бэлтгэлтэй, тодорхой дараалалтайгаар, хуулиар тогтоосон хугацаанд явагдах ёстой. Нотлох баримт зөвхөн илрүүлэх биш, түүнийг бүх талаас нь шалгасан байх нь чухал. Мөрдөн байцаалт бүрэн дүүрэн, бүх талаас нь, объектив байх шаардлага мөрдөн байцаагч ажлаа шуурхай-эрэн сурвалжлах аппарат, цагдаагийн бусад байгууллага, албадтай чадварлагаар зохицуулахаас их шалтгаална. Үүнээс гадна мөрдөн байцаагч нэг биш, хэд хэдэн хэрэгт нэгэн зэрэг ажиллагаа явуулдаг. Зарим тохиолдолд мөрдөн байцаах ажиллагааг их хэмжээний нутаг дэвсгэрт явуулах ч бий. Ийм учраас төлөвлөлт мөрдөн байцаах ажиллагааны салшгүй нөхцөл болдог.

Зөвхөн төлөвлөгөөтэй ажилласнаар хууль ёсыг хэлбэрэлтгүй сахиж, мөрдөн байцаалт шуурхай байж, хэргийн бүх байдлыг бүрэн дүүрэн, бүх талаас нь, объективоор тогтоох зарчим, шаардлагыг биелүүлж чадна.

Мөрдөн байцаалтын төлөвлөлт нь хуулийн шаардлагад бүрэн нийцүүлж, цаг, хүч бага зарцуулж, гэмт хэргийн бүх байдлыг тогтоох, буруутай этгээдийг илчлэх ажлын агуулга, журмыг тодорхойлдог сэтгэхүйн процесс.

Төлөвлөлт нь зөвхөн мөрдөн байцаалт дууссанаар төгсдөг төвөгтэй, үргэлжийн сэтгэн бодохуйн процесс. Төлөвлөлт, төлөвлөгөө хоёрыг хутгаж болохгүй. Төлөвлөгөө нь төлөвлөлтийн эцсийн үр дүн, материаллаг хэлбэр.

Мөрдөн байцаалтын төлөвлөгөөнөөс гадна илүү нарийн, хариуцлагатай мөрдөн байцаах ажиллагааг тусгай төлөвлөгөөгөөр явуулна.

3. Зохион байгуулалт. Мөрдөн байцаалтыг зохион байгуулж явуулах нь төлөвлөлтөөс өргөн хүрээтэй (агуулгатай) ойлголт юм. Мөрдөн байцаалтыг зохион байгуулж явуулах гэдэг нь:

- мөрдөн байцаалтын төлөвлөгөөг урьдчилан боловсруулах,
- мөрдөн байцаалтын явцад мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцогчдын хоорондын харилцан ажиллагааны уялдаа холбоог хангах,



- мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах,
- ажлын хэсгийн гишүүдийн ижил үүргийн хуваарийг нарийн ялган зааглах,
- ажлын хэсгийн зөвөлгөөнийг тогтмол зохион байгуулж мөрдөн байцаалтын үр дүн болон дараагийн зорилтуудыг авч хэлэлцүүлж байх,
- мөрдөн байцаах шуурхай хэсгийн оролцогчдын хооронд мэдээллийг байнга солилцох боломжийг бүрдүүлэх,
- мөрдөн байцаагчийн ажлыг төлөвлөхдөө түүний мөрдөж байгаа бүх эрүүгийн хэргүүдийг тооцох өөрөөр хэлбэл, ажлын ачааллыг тэнцүүлэх,
- мөрдөн байцаалтын ажлын зайлшгүй нөхцөл болон техник хангамжийг бүрдүүлэх,
- эрүүгийн хэргийг мөрдөн байцаах ажиллагааны явцад зайлшгүй шаардагдах эрхийн актуудыг (холбогдох тушаал, заавар, дүрэм журам гэх мэт) цуглуулж судлах,
- мөрдөн байцаалтын ажлын мэдээ баримтыг задруулахгүй байх, үрэгдэж устахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байх зэрэг асуудлуудыг өөртөө багтаана.

Эүүгийн хэргийг мөрдөн байцаах ажиллагааны зохион байгуулалтын бүрэн арга хэмжээнүүдийн иж бүрдэл нь тодорхой бөгөөд оновчтой, бүх асуудал нарийн боловсрогдсон байвал зохино.

Мөрдөн байцаах ажиллагааны зохин байгуулалтын чухал хэсгийн нэг нь мөрдөн байцаагчийн зүгээс шуурхай эрэн сурвалжлах, криминалистикийн шинжилгээний болон бусад байгууллага албад, олон нийттэй тогтоосон нягт уялдаа холбоо юм.

Мөрдөн байцаалтын ажиллагааг гүйцэтгэх ажлын арга хэмжээтэй хослуулан явуулах нь гэмт хэргийн мөрдөн байцаах ажлын чанарыг дээшлүүлэх чухал нөхцөл юм. Үүний тулд мөрдөн байцаагчийн ажил нь гүйцэтгэх албаны үйл ажиллагаатай (ажил хэрэгчээр) нягт уялдсан байвал зохино. Энэхүү ажил хэрэгч уялдаа холбоог авч үзэхдээ тэдний эрх хэмжээний ялгаа заагийг мартаж болохгүй. Тэдний харилцан уялдаатай хамтын ажиллагаа нь янз бүрийн хэлбэрээр явагддаг. Үүнд:

- хэрэг учирлын газарт хамтран ажиллах,
- гэмт этгээдийг баривчлах,
- эрүүгийн хэргийг мөрдөн байцаах болон нарийн төвөгтэй мөхдөн байцаалтын ажиллагаа, шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг хамтарч боловсруулах,
- шалгаж байгаа эрүүгийн хэргийн нөхцөл байдал ба гэмт этгээдийн талаар мэдээ мэдээллийг харилцан солилцох зэрэг асуудал орно.

Ийм ажил хэрэгч уялдаа холбоог цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч болон гүйцэтгэх ажилтнуудын хооронд тогтоох нь харьцангуй хялбар байдаг. Мөрдөн

байцаалтын хэсэгт томилогдсон гүйцэтгэх ажилтан болон криминалистикийн мэргэжилтэн нь гэмт хэргийг түргэн шуурхай, бүрэн илрүүлэхийн тулд өөрсдийн ажлын өвөрмөц арга хэрэгслийг идэвхтэй ашиглан ажиллах, шинээр олж авсан мэдээ баримтын талаар мөрдөн байцаагчид цаг тухайд нь мэдэгдэж байх үүрэгтэй.

Мөрдөн байцаагч мөрдөн байцаалт, гүйцэтгэх ажлын уялдаа холбоог хангахын тулд шуурхай эрэн сурвалжлах арга хэмжээг авч явуулахад зайлшгүй шаардлагатай мөрдөн байцаалтын үед авагдсан мэдээ мэдээллээр гүйцэтгэх ажилтныг хангах хэрэгт холбогдогчийн хувийн байдлыг тодруулах, хань хамсаатан, харилцаа, амьдралын хэвшил, биеэ авч яваа байдал, хэргийн гэрч нарыг тогтоох зэрэг асуудлын талаар даалгавар өгөх, хэргийн холбогдогчийг баривчлах ба цагдан хорих, нэгжлэг болон гэмт этгээдийн зүгээс оргон зайлах амиа хорлох, эд мөрийн баримтыг устгах зэргээр эсэргүүцэл үзүүлж болзошгүй тохиолдолд гүйцэтгэх ажилтны туслахааг авах, эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалт явуулж байгаа мөрдөн байцаагчдын зөвлөгөөнд гүйцэтгэх ажилтныг оролцуулах, шалгалтын явцад цугларсан мэдээ баримтыг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар санал бодлыг нь сонсож төлөвлөгөөнд тусгах зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Мөрдөн байцаалтын ажиллагаа болон шуурхай эрэн сурвалжлах арга хэмжээг зөв хослуулан уялдаа холбоо сайтай хэрэгжүүлэх нь бэлтгэгдэж байгаа гэмт хэргийг таслан зогсооход чухал ач холбогдолтой байдаг.

Хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагын ажиллагаа нь олон түмэнтэй нягт уялдаа холбоотой тэдний туслалцаанд түшиглэх ёстой. Иргэдийн туслахааг авахдаа сайн дурын үндсэн дээр тэдний аюулгүй байдлыг найдвартай ханган, хуулиар зөвшөөрөгдсөн хэм хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ. Эдгээр нь:

- гэмт хэргийг илрүүлж таслан зогсоох,,
- гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийг олж тогтоох,
- гэмт этгээдийг эрэн сурвалжилж баривчлах,
- гэрчүүдийг олж тогтоох,
- мөрдөн байцаалтын зарим ажиллагааг явуулахад туслах.

Мөрдөн байцаалтын явцад мөрдөн байцаагчтай хамтран ажиллах субъектүүдэд гүйцэтгэх ажилтнаас гадна

- цагдаагийн байгууллагын бусад албад, аймаг нийслэл дүүргийн Засаг даргын дэргэдэх албад
- мэргэжлийн хяналтын зохих албад
- гаалийн алба
- татварын албадыг нэрлэж болох юм.



#### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Мөрдөн байцаалтын төлөвлөлт гэж юу вэ?
2. Мөрдөн байцаалтын зохион байгуулалт гэж юу вэ?
3. Төлөвлөлтийн төрлүүдийг нэрлэнэ үү?
4. Төлөвлөлтийн зарчмуудыг тодорхойлно уу?

## СЭДЭВ 5. ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ

1. Хэргийн газрын үзлэгийн ойлголт
2. Хэргийн газрын үзлэгийн тактик, зохион байгуулалт

1. “Үзлэг” хэмээх үг нь “биеийг шинжлэх, үзэх, судлах нь”<sup>1</sup> гэсэн утгатай, үзлэгийн үйл болох “үзэх” гэдэг нь “харах, сурах, судлах, шинжлэх, бодох, тооцох, турших”<sup>2</sup> гэсэн олон утгатай үг. Гэтэл Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-д “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэрэг гарсан байдал, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, гэмт хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор хэрэг гарсан газар болон эд зүйл, баримт бичигт үзлэг хийнэ”<sup>3</sup> гэж үзлэгийн зорилгыг “олох” гэж томъёолсон байна.

Олох гэсэн үг нь “олз” гэсэн үгнээс үүсэлтэй ба олз гэдэг үг нь үнэ өртөггүй олсон юм<sup>4</sup>, харин “олох” гэдэг нь санамсаргүй тохиолдол юм.

Хэрэв бид үзлэгийг мөр олох зорилгоор хийвэл үзлэг хэзээ ч үр дүнтэй болохгүй. Яагаад гэвэл, мөр санамсаргүйгээр олдохгүй л бол мөрдөгч үзлэг хийгээгүйд тооцогдоно.

Иймээс зөв сэтгэж, зөв ажиллана гэвэл үзлэгийн зорилгыг хуульд өөрөөр томъёолох шаардлагатай. Доктор Ж.Хурцгэрэл: “Үзлэг нь эрүүгийн хэрэгт ач холбогдолтой төрөл бүрийн материаллаг объект, түүн дээрх мөр, түүний шинж тэмдэг, шинж, байдал, өөр хоорондын байрлалыг шууд илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэх ажиллагаа мөн”<sup>5</sup> гэж үзлэг, түүний зорилго, агуулга, мөн чанарыг тодорхойлжээ. Иймд мөрдөгч нь үзлэгийг зүгээр л мөр олох зорилгоор бус харин ч гэмт үйл, түүний улмаас бий болсон мөрийг идэвхтэйгээр хайх, тооцоолох, судлах, шинжлэх зорилгоор хийвэл үзлэг чанартай, үр дүнтэй болох юм.

### Үзлэгийг дараах байдлаар төрөлжүүлдэг:

#### Объектоор нь:

- Хэргийн газар,
- Цогцос,
- Хүн,

1 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 615 дахь тал.

2 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 617 дахь тал.

3 Төрийн мэдээлэл., 2002., №6., 201 дэх тал.

4 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966., 412 дахь тал.

5 Ж.Хурцгэрэл, Криминалистик-2., УБ., 2004., 116 дахь тал.



- Эд зүйл,
- Бичиг баримт,
- Мал, амьтанд гэх мэт.

#### **Хэмжээгээр (газар) нь:**

- Үндсэн,
- Нэмэгдэл.

#### **Дарааллаар (хугацаа) нь:**

- Анхны,
- Дахин.<sup>6</sup>

Хэргийн газрын тухай ойлголт. Цагдаагийн байгууллага гомдол, мэдээллийн дагуу ямар нэгэн “явдал”<sup>7</sup> болж өнгөрсөн газар очин үзлэг хийдэг. Уг газрыг зарим судлаачид “учралын газар”, “гэмт хэргийн газар” гэж нэрлэдэг. Зүй нь “хэргийн газар” гэж нэрлэх нь зохимжтой. Учир нь болж өнгөрсөн явдал нь эрх зүйн ямар зөрчил болохыг бид урьдчилан мэдэх боломжгүй байдаг. Харин үзлэг хийж, байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулснаар тухайн болж өнгөрсөн “хэрэг-явдал” нь дараах эрх зүйн зөрчил, эсвэл учрал байсныг тогтооно. Үүнд:

- Гэмт хэрэг.
- Захиргааны хэрэг, зөрчил.
- Иргэний хэрэг.
- Учрал.

Хэргийн газар гэдэг нь бодит явдал эхэлсэн, өрнөсөн, төгссөн орон зай, түүнийг хүрээлэн буй орчинг хэлнэ.

Практикт хэргийн газар гэдгийг зөвхөн хэрэг болсон орон зайн хүрээнд ойлгох явдал түгээмэл. Өөрөөр хэлбэл, хэрэг болсон орчинд үзлэг хийх нь дутагдалтай байдаг. Орон зай, орчинд үзлэг хийснээр хэргийн газарт бүрэн үзлэг хийсэн гэж ойлгоно.

Хэргийн газрын үзлэг. Хэргийн газрын үзлэгийн чанар, үр дүнгээс хамаарч гэмт хэрэг илрүүлэх, нотлох, шийдвэрлэх ажиллагааны цаашдын “хувь заяа” шалтгаалдаг.

“Хэргийн газрын үзлэг гэдэг нь хэрэг болсон орон зай, орчиноос гэмт үйлдлийн мөр цуглуулах<sup>8</sup>, гэмт үйл, гэмт этгээдийг оношлох зорилгоор хуульд заасан үндэслэл,

6 А.Г.Филиппов., Криминалистик., Москва., 2006, 162 дахь тал.

7 Юмсын хөдөлгөөн, хэрэг явдал хорш үг., Я.Цэвэл., Монгол хэлний товч тайлбар толь., УБ., 1966, 899 дэх тал.

8 Мөр илрүүлэх, бэхжүүлэх, битүүмжлэх ажиллагааг хамтад нь ийнхүү нэгтгэж бичив.

журмын дагуу мөрдөгчийн хийж буй криминалистик ажиллагаа мөн”.

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэсэн өнөөгийн ардчилсан нийгэмд гэмт бүх явдлыг зөвхөн байцаах, залхаах аргаар сэжигтэн, яллагдагчийг айдаст автуулан, хэрэг хүлээх аргагүй байдалд оруулж хэргийг шийдэх биш харин гэмтний хэргийн газарт үлдээсэн мөрөөр нь буюу шинжлэх ухааны үүднээс “мөрдөж нотлох” ёстой.

Хэргийн газарт гэмт үйлдлийн мөр үүсэх нь зайлшгүй гэдгийг олон орны криминалистууд хүлээн зөвшөөрдөг тул хэргийн газраас гэмт үйлдлийн мөр илрүүлэх ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгдөг ба хэргийн газраас сэжигтэн этгээдийн гэмт үйлдлийн мөр илрээгүй бол Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактад заасан үзэл баримтлалын дагуу түүнд ял оногдуулахгүй байх зарчим үйлчилдэг байна.

Иймээс л хэргийн газрын үзлэгийн чанар нь мөрдөн байцаалтын цаашдын хувь заяаг шийднэ гэсэн ойлголт урган гарчээ.

Хэргийн газрын үзлэгийг чанартай, мэргэжлийн түвшинд явуулах нь ЭБША-ны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах үндэс болох юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн гэмт хэргээр яллуулж буй хүн бүр гэм буруутай болох нь хуулийн дагуу нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрхтэй”<sup>9</sup> гэж, мөн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэхь хэсэгт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор шүүгч нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлох хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй” гэж, тус хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт “Сэжигтэн оргон зугтахыг завдсан, эсхүл онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдэх хангалттай баримт байгаа бол түүнийг баривчилна”<sup>10</sup> гэж тус тус заажээ. Дээр тодотгосон “нотлогдоогүй бол”, “тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлох”, “хангалттай баримт” гэдэг ойлголт нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг гэмт үйлдлийн мөрөөр нь нотлох, баривчлах гэсэн логик-санаа гэж ойлгож болно.

Нотлох баримт гэдэг нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нараас гаргах бүхий л шийдвэрийн үндэслэл юм. Нотлох баримтыг хуулийн дагуу, шинжлэх ухааны арга хэрэгслээр цуглуулсан байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, мөрийг ЭБШХуулийн дагуу, криминалистикийн арга, хэрэгслээр нотлох баримт болгон хувиргадаг.

9 НҮБ., Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтэл., УБ., 1992., 14 дэх тал.

10 Төрийн мэдээлэл., 2002., №6.



## Эрүүгийн байцаан шийтгэх хууль

Мөр \_\_\_\_\_> Нотлох баримт

### Криминалистик

#### 2. Хэргийн газрын үзлэгийн тактик, зохион байгуулалт

Хэргийн газрын үзлэг нь криминалистикийн техник, тактик, түүнчлэн гүйцэтгэх ажлын хосолмол ажиллагаа юм.

Хэргийн газарт үзлэг хийх техник ажиллагаа гэдэг нь стандарт-аргачлал, хэрэгслийн тусламжтайгаар хэргийн газраас мөр илрүүлэх, мөшгөх, бэхжүүлэх, битүүмжлэх, зөөвөрлөх үйл явцыг хэлнэ.

Хэргийн газарт үзлэг хийх тактик ажиллагаа гэдэг нь бодит байдалд үнэлэлт, дүгнэлт өгч таамаглал дэвшүүлэх, хэргийн газрын үзлэгийг төлөвлөх, тогтсон үе, шатыг зохион байгуулах үйл явцыг хэлнэ.

Мэх буюу зөв техник эзэмшээгүй, тэмцэх ухаан буюу зөв тактик боловсруулаагүй бөх өрсөлдөгчөө унагаж чадахгүйтэй нэгэн адил криминалистикийн техник, тактикийг мэдэхгүй мөрдөгч хэргийн газрын үзлэгийг чанартай сайн хийж, гэмт хэрэгтэнд шударгаар ял ногдуулж эс чадна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан “Хууль зүйн сэтгэл судлал” номондоо “Хэрэг учралын газрын үзлэгийн үр дүн нь мөрдөн байцаагчийн эрх зүйн болон криминалистикийн мэдлэг, мөрдөн байцаах ажлын дадлага туршлагаас шууд хамаарна. Хэрэг учралын газар дахь олон тооны төрөл бүрийн мэдээллээс хэрэг илрүүлэхэд шаардлагатай чухал мэдээлэлүүдийг сонгон авахдаа мөрдөн байцаагч криминалистикийн мэдлэгээ үндэс болгон”<sup>11</sup> гэж криминалистикийн ач холбогдлыг дурьдсан байдаг.

#### **Мөрдөгч хэргийн газарт үзлэг хийхдээ дараах зарчмыг баримтлана:**

1. Хууль ёсны байх,
2. Цагаа олсон байх,
3. Бодитоор хийх,
4. Төлөвлөгөөтэй, дэс дараалалтай хийх,
5. Бүрэн дүүрэн хийх,
6. Идэвхтэй хийх,
7. Арга зүйч байх.

11 С.Жанцан., Хууль зүйн сэтгэл судлал., УБ., 2005., 340 дэх тал.

Хэргийн газрын үзлэгийн зохион байгуулалт гэдэг нь үзлэгийн зорилгыг хангахын тулд мөрдөгчөөс үзлэгийн үйл явцад зарчимч хандахыг хэлнэ.

Хэргийн газрын үзлэгийн үе, шат. Хэргийн газарт үзлэг хийхэд тактикийн хувьд тогтсон хэдэн үе, шатыг заавал мөрддөг. Үе, шат бүр зорилго агуулдаг, хоорондоо нягт уялдаатай, харилцан нэгнээсээ хамааралтай байдаг тул энэ нь үзлэгийн зорилгыг хангах үндэс болно. Харин аль нэг шатанд зорилгыг гүйцэт биш, буруу хэрэгжүүлэх, эсхүл алгассанаар нөхөж баршгүй алдаанд хүргэх уршиг тарих магадлалтай.

Амьдрал дээр гарч буй хэрэг явдал бүр хоорондоо адилгүй, өөр өөрийн гэсэн онцлог шинжтэй байдаг хэдий ч хэргийн газрын үзлэгийг тогтсон үе, шаттайгаар хийх нь тухайн гэмт хэргийг илрүүлэх, нотлох эхний зөв алхам болох юм. Үүгээр юуг хэлэх гээд байна вэ? гэвэл, амьдрал баялаг учраас хэргийн газрын үзлэг хийх арга зүйг бүхэлд нь нэг хэвэнд цутгасан мэт стандартчилах бус харин үзлэгийг дэгтэй, дараалалтай явуулах, үзлэгт ашиглах техник, хэрэгсэл, тэмдэглэгээ, нэр томьёо, үзлэгээр зайлшгүй хийх ажиллагааг нэг мөр цэгцлэх шаардлагатай гэсэн санаа юм.

Мөртэй ажиллах үе, шат (криминалистикийн техник ажиллагаа), хэргийн газрын үзлэгийн үе, шат (криминалистикийн тактик ажиллагаа) гэсэн хоорондоо ялгаатай ойлголтыг нэг зүйл мэтээр төсөөлж болохгүй. Нэг нь техник зүйн шинжтэй, нөгөө нь тактик зүйн шинжтэй энэ 2 ажиллагааг хэн зөв хослуулж чадсан нь л амжилтад хүрэх зүй тогтолтой.

Хэргийн газрын үзлэгийн нэг үеэс дараагийн үед шилжихэд хийвэл зохих алхамыг шат гэнэ.

### **Хэргийн газрын үзлэг нь дараах үе, шаттай:**

#### **Нэг: Бэлтгэл үе**

- Бэлтгэл ажил.
- Хэргийн газарт очих.
- Хэргийн газрын хүрээг тогтоох.
- Хэргийн газрыг хамгаалах.

#### **Хоёр: Ажлын үе**

- Анхны байдлаар нь гэрэл зургаар баримтжуулах.
- Урьдчилсан үзлэг хийх.
- Таамаглал дэвшүүлж, үзлэг хийх төлөвлөгөө гаргах.
- Нарийвчилсан үзлэг хийж мөр илрүүлэх.
- Илрүүлсэн мөрийг бэхжүүлэх, битүүмжлэх.



### **Гурав: Төгсгөлийн үе**

- Үзлэгийн явцыг гэрэл зураг, тэмдэглэлээр баталгаажуулах.
- Эцсийн үзлэг хийх.
- Хамгаалалтыг буулгаж, хэргийн газрыг орхих.

Үзлэгийг дээрх үе, шатуудыг дамжин хийх нь үзлэг чанартай болох, зөв таамаглал дэвшүүлэх, мөр нотлох баримтын шинж чанараа хадгалах, гэмт хэргийг халуун мөрөөр нь шуурхай илрүүлэх зэрэг ач холбогдолтой. Харин тодорхой логик дэс дараалал бүхий үе, шатын нэгийг алгасах, дэс дарааллыг нь гажиж үзлэг хийвэл дээр дурдсан ач холбогдлыг алдах аюултай.

### **Сургалтын тоглолт**

Бэлтгэх зүйлс: Үзлэгийн иж бүрэн цүнх, хамгаалалтын хувцас хэрэгсэл. Зохиомол хэргийн газар үүсгэхэд шаардлагатай зүйлс: хиймэл хүн, хутга, архины шил, тамхины иш, товч, аяга, үс гэх мэт.

Гүйцэтгэл: Оюутнууд 6 хүнтэй баг болон, 1 мөрдөн байцаагч, 2 мэргэжилтэн, 1 прокурор, 2 хөндлөнгийн гэрчийн дүрд тоглоно. Үзлэгийн баг тухайн хэргийн газарт криминалистикийн техник, тактикийн дагуу бодитой үзлэг хийнэ.

## **СЭДЭВ 6. БАЙЦААН ШИЙТГЭХ ТОДОРХОЙ АЖИЛЛАГААНЫ ТАКТИК**

ЭБШ ажиллагааны зорилтыг хангахын тулд хийж байгаа ажиллагаа нэг бүр нь өөр өөрийн зорилго, хийж гүйцэтгэх технологийн ялгаанаас хамаарч харилцан адилгүй байдаг нь энэхүү бүлэг сэдвийг судлах хэрэгцээг бий болгож байдаг.

ЭБШ тодорхой ажиллагааны тактик нь тодорхой ажиллагаа явуулахтай холбогдсон арга зүйн зөвлөмж, арга аргачлалыг боловсруулахад анхаарлаа хандуулан тэрхүү чиглээр тодорхой санал, зөвлөмж аргачлалыг боловсруулсан байдаг. Тухайлбал: ЭБШ тодорхой ажиллагааны хэлбэр (нэгжлэг, үзлэг, хураан авах, мэдүүлэг авах, таньж олуулах, туршилт хийх г.м) тус бүрээр нь судлан авч үзсэн байгаа нь түүний ач холбогдлыг нээн харуулах юм. Тодорхой ажиллагаа нэг бүрээр боловсруулсан бөгөөд бидний үзэж байгаагаар тодорхой ажиллагааны тактик зүйн чиглэлээр боловсрогдсон шинэ хандлага одоо илэрхий дутагдаж байна. Тийм ч учраас тодорхой гэмт хэргийг мөрдөх явцад ЭБШ хууль тогтоомжид заасан тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхдээ нэлээд нарийн бүтэц бүхий үе шатыг дамжин уялдаа холбоог хангаж явуулах нөхцөл нь энэхүү хичээлийн зорилго болж байдаг юм.

ЭБШ тодорхой ажиллагаа бүр нэг дор бүгд хэлбэршин хийгдэх боломжгүй учраас хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас тухайн ажиллагаа нэг бүрийг эмх цэгцтэй, дэс дараалалтай, тодорхой бэлтгэлтэйгээр зохион байгуулах нь үр дүнтэй болдог байна.

Тодорхой ажиллагааны тактикийг боловсруулахдаа дараах үе шатыг харгалзан урьдаас тооцоолох шаардлага үүсэн бий болно. Үүнд: - тодорхой ажиллагааг зөв зохион байгуулах, дэс дараалал, хослолыг тохируулах, - сонгон авсан тухайн ажиллагааг явуулахаас өмнө сэтгэл зүйн, техник хэрэгслийн, зохион байгуулалтын, оролцогчдын, учирч болох саад бэрхшээл зэргийг судлан тогтоох, тооцох зэрэг бэлтгэлийг хангах, - тухайн ажиллагаанд оролцогчдыг эрх, үүрэг, оролцооны хэв шинж, хөдөлгөөн, ярих зүйлсийн талаар урьдчилан сануулсан байх, - тодорхой ажиллагааг эхлүүлэх буюу тухайн ажиллагааг зохион байгуулж байгаа албан тушаалтан гүйцэтгэвэл зохих ажиллагааг тухайн ажиллагааны онцлогоос хамааруулан дэс дараалалтай, эмх цэгцтэйгээр явуулж гэрэл зураг авах, тэмдэглэл, дуу, дүрс бичилэг хийх, шаардлагатай эд мөрийн баримтыг илрүүлэх, хураан авах, савлах зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэх, - ажиллагааг удирдан зохион байгуулж байгаа албан тушаалтан тухайн ажиллагааг зогсоох, эцсийн ажилбарыг хийж ямар нэг дутуу орхигдсон зүйл байгаа бол түүнийг нягтлах, хянах, - ажиллагааг төгсгөж эцэслэх, ажиллагаа дууссан талаар бусад оролцогч, хүмүүст хэлэх, бэхжүүлсэн, цуглуулсан баримт сэлт, мэдээ, мэдээллийг нэг бүрчлэн бүртгэх, шилжүүлсэн буюу шилжүүлэх гэж байгаа бол тэдгээрийн талаар зохих тэмдэглэл



үйлдэж баталгаажуулах, ажиллагаа нэг бүрээ баталгаатай болгох зэргээр тодорхой ажиллагааны тойм зэргийг гаргаж байна.

Гэтэл ЭБШ тодорхой ажиллагааг хэрэг шалгах явцад зэрэг явуулах боломж бүрддэггүй болохыг дээр тэмдэглэсэн. Тийм ч учраас тодорхой ажиллагааг зэрэгцүүлэн явуулах боломж, түүнийг зэрэгцүүлэн явуулж байгаа бол тухайн ажиллагааг явуулж байгаа албан тушаалтнуудын харилцаа, мэдээлэл солилцох боломж, ажиллагааг дутуу явуулах буюу шалгахгүй орхисон зүйл байгаа эсэхийг харилцан мэдээлж, солилцож байх учиртай. Үүнийг тактик зүйд хослол гэж нэрлэж заншсан боловч тодорхой ажиллагааг явуулахдаа анхаарах зүйлсийн нэг хэмээн үзэж судалж байдаг юм.

Нийтлэг байдлаараа ямар ч тодорхой ажиллагааг - бэлтгэл, - ажлын, - төгсгөлийн зэргээр явуулах ажлын дэс дараалал, горимыг тогтоосон байдаг нь өдгөө ч мөрдөх ажиллагааны үндсэн ухагдахуун байсаар ирлээ. Тийм ч учраас ЭБШ тодорхой ажиллагааг хэрэгжүүлж байгаа буюу түүнийг хэрэгжүүлэх онолын болон прагматик мэдлэгийг, хийж гүйцэтгэх ажиллагааг дээрх гурван үндсэн үе шатнаас салангид авч үзэж болохгүй.

Тодорхой ажиллагааны аль ч хэлбэрийг хийж гүйцэтгэхэд тактикийн эрсдэл учирч болзошгүй байдаг тул түүнийг даван туулах арга замаа тодорхойлох хэрэгтэй болно. Тухайн ажиллагаа нь хэний эрх ашиг, сонирхолд харшлах буюу нотлох гээд байгаагаас хамаарч тухайн ажиллагааг үр дүнгүй болгох буюу санаатайгаар тухайн ажиллагааг эсэргүүцэх үйлдэл гарах магадлалыг тооцоолж байж тухайн тодорхой ажиллагаа үр дүнтэй болно. Өөрөөр хэлбэл, мэдүүлэг авах явцад гэрч, хохирогч зарим үйл явдлын талаар нэг ойлголттой бус зөрүүтэй, ноцтой төөрөгдөхөөр нөхцөл үүсч байдаг. Энэ нь мөрдөх ажиллагаа нэг зорилгод хүрэх үндсэн нөхцөлийг алдагдуулахад хүргэдэг. Угтаа бол үүний зөрүүтэй байдлыг гаргахын тулд нүүрэлдүүлэх нөхцөл үүсэн бий болж байдаг юм. Тэгэхлээр тактикт бидний үзэж байгаагаар тодорхой ажиллагааны аль нэг нь зорилгоо хангаагүй бол түүнийг гэтлэх дараагийн арга зүйг боловсруулах шаардлага үүснэ гэсэн агуулгыг илтгэж байдаг юм.

## **Сургалтын тоглолт**

**Зохион байгуулалт:** 1 ангийн оюутнууд 3-4 хүнтэй баг болно.

Баг тус бүр өөрсдөө эрүүгийн нэг хэргийн зохиомж гаргана. Үүний дараа тухайн хэргийг мөрдөхийн тулд явуулах шаардлагатай эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас 2-ыг сонгоно. Сонсож авсан байцаан шийтгэх ажиллагааныхаа төлөвлөгөө гаргана. Мөн зохион байгуулалтын ямар тактик сонгосон, хэрхэн хэрэгжүүлэх талаараа илтгэл бичнэ.

Багш төлөвлөгөө, илтгэлийг хүлээн авч дүгнэн, оюутнуудад тайлбар, зөвлөмж өгнө.

## IV БҮЛЭГ. КРИМИНАЛИСТИКИЙН АРГА ЗҮЙ

### СЭДЭВ 1. КРИМИНАЛИСТИКИЙН АРГА ЗҮЙН ОЙЛГОЛТ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

1. Криминалистикийн арга зүйн ойлголт, эх сурвалж, зарчим
2. Гэмт хэргийн криминалистик шинжийн ойлголт, мөн чанар, ач холбогдол

1. Зарим төрлийн гэмт хэргийг (хүн алах, хүчиндэх, хулгайлах гэх мэт) илрүүлэх, мөрдөн байцаах криминалистикийн арга зүй нь криминалистикийн шинжлэх ухаан, сургалтын курсын сүүлчийн хэсгийн гэмт явдалтай тэмцэх практикт шаардлагатай зөвлөмжүүд нь өөрийн ач холбогдлоороо криминалистикийн тэргүүн шугамд байна.

Шинжлэх ухааны үзэл баримтлал, түүн дээр үндэслэн боловсруулсан, зарим төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаах, таслан зогсоох ажиллагааг зохион байгуулах, явуулах зөвлөмжийн системийг криминалистикийн арга зүй гэнэ.

Криминалистикийн арга зүй эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шаардлагад зохицуулан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг илүү үр ашигтай явуулах шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулах зорилгоор гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах, таслан зогсоох ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх зүй тогтлыг судална.

Энэ зүй тогтол гэмт хэргийн шинжтэй үйл явдлын тухай анхны мэдээллийг шалгах; хэрэг бүртгэх, мөрдөн байцаахад нотлогдвол зохих байдлыг тодорхойлох; мөрдөн байцаах ажиллагаа, эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үнэнийг тогтоох бусад арга хэмжээний хөтөлбөр (программ) боловсруулах, мөрдөн байцаах зарим ажиллагаанд бэлтгэх, явуулах хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагааг зохион байгуулахад илүү гол, тогтвортой, дахин давтагдах бүхнийг илэрхийлнэ. Гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах, таслан зогсоох процесстой холбоотой объектыг криминалистикийн байр сууринаас судлах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагааны хөгжлийн үндсэн чиглэлийг нэгтгэн дүгнэх, тогтоох, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг зохион байгуулах, явуулах тогтвортой харилцан хамаарал, нийтлэг холбоог шинжлэх, тодорхойлох замаар энэ зүй тогтлыг танин мэднэ. Жишээлбэл, энэ тухайд зарим төрлийн гэмт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа гэмт үйлдлийн объектив, субъектив хүчин зүйл, гэмт хэргийн тухай мэдээлэл олж авах байдал, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах



аппаратын үйл ажиллагааны зохион байгуулалтын онцлогоос хамааралтайг тогтоох нь их үүрэгтэй.

Криминалистикийн техник, тактикийн хэрэгсэл, арга барил зарим төрлийн гэмт хэрэг мөрдөн байцаах онцлогтой зохицон криминалистикийн арга зүйд биеллээ олно. Жишээлбэл, криминалистикийн техник гарын мөр үүсэх механизмыг тогтоох бөгөөд тэгэхдээ хулгайлах буюу хүн алах гэмт хэрэг үйлдэгдсэн үед энэ мер ямар эд зүйл дээр бий болох асуултад хариулт өгөхгүй. Криминалистикийн тактик гэрчийг байцаах арга зүйг авч үзэх боловч тодорхой хэрэг, тухайлбал, зам тээврийн ослыг бүртгэх мөрдөн байцаахад гэрчийг байцаах онцлогийг судлахгүй.

Криминалистикийн тодорхой арга зүйг ямар нэг гэмт хэрэг бүртгэх, мөрдөн байцаахад шаардлагатай мөрдөн байцаах ажиллагаа, техникийн хэрэгсэл, тактикийн арга барилын механик нэгдэл, цуглуулга гэж ойлгохгүй. Хувийн арга зүй зөвхөн тухайн тохиолдолд үр ашигтай арга зүй, зөвлөмжөөр зогсохгүй, түүнийг ашиглах арга зүй, мөрдөн байцаалтыг зохион байгуулах онцлог, мөрдөн байцаалтын нийтлэг таамаглал, ямар нэг тусгай мэдлэг ашиглах тухай асуудлыг авч үзнэ.

Криминалистикийн тодорхой хувийн арга зүйн агуулга нь түүнийг боловсруулахад зориулагдсан криминалистикийн шинжлэх ухааны энэ хэсэгт байгаа тусгай мөн.

Криминалистикийн арга зүй өөр хоорондоо нягт холбоотой хоёр хэсгээс тогтоно:

1) Судлахуй, систем, зарчим, эх сурвалж; шинжлэх ухааны мэдлэгийн бусад салбар криминалистикийн арга зүйн холбоо; криминалистикийн хувийн арга зүйг боловсруулах, ашиглах; гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөдрөн байцаах, таслан зогсоох асуудлыг багтаасан криминалистикийн арга зүйн онолын үндэс (ерөнхий үзэл баримтлал); эцсийн эцэст энэ асуудлын боловсруулалтаас үр ашигтай хувийн арга зүй бий болгох, гэмт явдалтай тэмцэхэд түүнийг амжилттай хэрэглэх явдал шалтгаална.

2) Зарим төрөл, бүлгийн гэмт хэрэг мөрдөн байцаах арга зүй (хувийн арга зүй). Өөр хоорондоо бүрэлдэхүүнээрээ, өөрөөр хэлбэл эрүүгийн эрх зүйн шинжээр нь ангилдаг (жишээлбэл, хүн алах, хүчиндэх, хулгайлах, танхайрах гэх мэт) гэмт хэрэг, зарим бүлэг гэдэгт өөр шинж тэмдэг (жишээбэл, насанд хүрээгүй хүмүүс үйлдсэн, бүлэглэн үйлдсэн, зохион байгуулалтай бүлэг үйлдсэн, өнгөрсөн жилүүдийн илрээгүй гэмт хэрэг гэх мэт)-ээр ялгагддаг гэмт хэрэг хоёрдахь хэсэгт тус тус хамаарна. Хувийн арга зүй криминалистик шинжлэх ухааны эцсийн “бүтээгдэхүүн” бөгөөд хавсарга шинжтэй, онолын хувьд үндэслэлтэйгээр боловсруулагдсан зөвлөмжийн цогц мөн.

Зарим төрлийн гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах, таслан зогсоох ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх арга зүй (шинжлэх ухаан-практикийн)-н

төрөлжүүлсэн систем байдгаараа хувийн арга зүй, криминалистикийн арга зүйн ерөнхий үзэл баримтлалаас ялгаатай.

Криминалистикийн арга зүйн тодорхойлолтод арга зүйн зөвлөмж гэдэг ойлголт орсон байгааг бид дээрээс мэдэх болсон. Криминалистикийн арга зүйн энэ зөвлөмж нь тодорхой төрлийн гэмт хэрэг илрүүлэх, бүртгэх, мөрдөн байцаах, таслан зогсоох ажиллагааг зохион байгуулах, явуулах шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулсан, практикаар шалгагдсан зөвлөгөөн (санал). Криминалистикийн хувийн арга зүй бүр янз бүрийн нөхцөл буюу нөхцөлт байдалд ажиллахад зориулсан өөр хоорондоо холбоотой зөвлөгөөний систем бий болгодог зөвлөмжийн хэд хэдэн бүлгийг агуулдаг.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний элемент, гол төлөв объектив тал (үйлдсэн, нуусан арга буюу газар гэх мэт)-ын онцлогийг үндэслэн хувийн арга зүйг цааш нь нарийвчилна.

Криминаликтик хувийн арга зүй хоёр чиглэлээр бий болж байна:

1. Байгааг боловсронгуй болгох, шинэ арга зүй боловсруулах. Шинэ арга зүйд, жишээлбэл, байгаль хамгаалах журмын эсрэг, хүний эрх, эрх чөлөөний эсрэг, компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэх мэт гэмт хэрэгтэй холбоотойгоор гарч ирсэн шинэ бүрэлдэхүүн хамаарна. Байгаа арга зүйн өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдэх, нуух шинэ аргатай холбоотой байж болно (цахилгаан тооцоолон бодох машин ашиглах, гэмт хэргийн субъектын өөрчлөлт - зохион байгуулалттай бүлэглэл бий болох гэх мэт).
2. Газар, цаг хугацааны тодорхой нөхцөлд, ямар нэг ялгагдах ерөнхий шинж тэмдгээр тодорхойлогддог этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хэд хэдэн төрөл, зүйлийг багтаасан, их хэмжээгээр нийтлэг шинжтэй криминалистикийн хувийн зөвлөмжийн цогц бий болгох. Ийм цогц нь өөрийн бүтэц, агуулгаар криминалистикийн уламжлалт арга зүйгээс ялгагдана.

Криминалистикийн арга зүйн эх сурвалж:

- Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдэг, нотолгооны зүйл, хэмжээг тогтоосон эрүү ба эрүүгийн байцаан шийтгэх хуулийн хэм хэмжээ;
- Гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, таслан зогсоох практик;
- Криминалистикийн шинжлэх ухааны ерөнхий онол, криминалистикийн техник, криминалистикийн тактикийн үзэл баримтлал, мөн бусад шинжлэх ухаан (шүүх эмнэлэг, сэтгэл судлал, криминологи гэх мэт)-ы үзэл баримтлал, тодорхой хэм хэмжээ тогтоосон журам, заавар.

Арга зүйн эх сурвалж болох эруугийн байцаан шийтгэх эрх зүйн үүрэг дараах байдалд илэрнэ:



1. Эрүүгийн байцаан шийтгэх хууль гэмт хэрэг мөрдөн байцаах ерөнхий журам тогтооно. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажиллагааны журам, дарааллыг тусгасан, криминалистикийн хувийн арга зүйн бүтэц дээрх журамд үндэслэнэ. Энэ бүхэн нотолгооны процессын тодорхой “шав” (эхлэх цэг), “зангилаа агшин”-ы үүрэгтэй.
2. Эрүүгийн байцаан шийтгэх хууль нотолгооны процесс явагдах хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны хүрээг төгс байдлаар тодорхойлсон. Мөрдөн байцаах ихэнх ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үзэмжээр явуулж болохыг зөвшөөрөхдөө эрүүгийн байцаан шийтгэх хууль зарим ажиллагааны хувьд бүх, эсхүл зарим категорийн гэмт хэрэгт хамаарах ноёлох (ерөнхий) (imperativus -ноёлогч гэсэн утгатай.) ерөнхий заалттай байна. Мөрдөн байцаах ажиллагааны нийтлэг хүрээ, дарааллын ерөнхий зөвлөмжийг агуулсан криминалистикийн хувийн арга зүй зөвхөн хуулиар тогтоосон тийм ажиллагааг ашиглах бөгөөд ингэхдээ ерөнхий заалтыг харгалзана.
3. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нотолгооны зүйлийн ерөнхий томъёоллыг заасан байна. Үүнийг үндэслэн эрүүгийн хэргийн категори бүрт тодруулбал зохих байдлыг криминалистикийн арга зүй боловсруулдаг.
4. Гэмт хэргийг шуурхай, бүрэн дүүрэн илрүүлэх, хэргийн байдлыг бүх талаас нь, бодитоор шинжлэх тухай эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шаардлага бүхэлдээ криминалистикийн арга зүйд чухал ач холбогдолтой. Энэ шаардлага нь процессын оролцогчдын эрх, ашиг сонирхлын эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоосон баталгааг хэрбэрэлтгүй хангах явдалтай хослон үйл явдалд өрөөсгөл хандах, өөрийн ажиллагааг урьдаас буруугаар тааварлах явдал гаргахгүй байхыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгосон.

Криминалистикийн хувийн зарим арга зүйн агуулгад нотолгооны зүйлийг тодорхойлоход харгалзан үзэх шаардлагатай, эрх зүйн бусад салбарын хэм хэмжээ ихэд нөлөөлнө. Жишээлбэл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт хэм хэмжээний зохих актад тусгагдсан журам нотолгооны зүйл бий болох чухал эх сурвалж болно.

## 2. Гэмт хэргийн криминалистикийн шинж.

Гэмт хэргийн криминалистикийн тодорхойлолт нилээд нарийн бүтэцтэй. Үүнд дараах зүйл хамаарна:

1. Анхны нийтлэг мэдээллийн шинж;
2. Тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэх, нуух нийтлэг арга, түүнээс бий болсон хор уршгийн тухай мэдээллийн систем;
3. Үйлдсэн байж болох гэмт хэрэгтний хувийн байдал, гэмт хэргийн шалтаг, зорилго;

4. Байж болох хохирогчийн хувийн байдал;
5. Гэмт хэрэг үйлдсэн зарим нийтлэг байдал (газар, цаг, байдал)-ын тухай мэдээлэл;
6. Тодорхой төрөл, зүйлийн гэмт хэрэг үйлдэхэд бололцоо олгодог зарим нийтлэг байдлын тухай мэдээлэл.

Энэ бүтэцэд хийсэн задлан шинжилгээ нь эрүүгийн тухайн категорийн гэмт хэрэгт нотлогдвол зохих зүйлд тохирсон, тогтоохыг шаардсан бүх нийтлэг байдал тусгадсаныг харуулж байна. Мөрдөгдөж байгаа гэмт хэргийн өвөрмөц онцлогтой уялдуулан энэ байдлыг бодит болгох нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зорилго болно.

Криминалистикийн шинжийн дээр дурдсан бүтцийн зарим хэсгийг арай дэлгэрэнгүй авч үзье.

Анхны нийтлэг мэдээлэл; энэ мэдээлэл түүний агуулагчийг мэдсэнээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч түүнийг амархан илрүүлэн үнэлж, түүнээс мөрдөн байцаах үйл явдлын гол зүйлд чиглэлтэй болно.

Гэмт хэрэг үйлдэх, нуух аргын мэдээ чухамхүү гэмт үйл ажиллагааны хамаарлын талыг илэрхийлдэг учраас энэ мэдээ криминалистикийн шинжийн төв хэсэг болдог. Энэ мэдээлэл зөвхөн гэмт хэрэгт яаж бэлтгэсэн, үйлдсэн, нуусан тухай баримт агуулаад зогсохгүй, гэмт этгээдийн үйлдэл тойрон буй орчинд яаж туссан, еерөөр хэлбэл, гэмт халдлагаар ямар мөр бий болсон, хаана түүнийг эрэх, түүгээр гэмт хэргийн механизмыг сэргээх боломж өгнө.

Байж болох гэмт хэрэгтэн хохирогчийн хувийн байдлын тухай мэдээллийг криминалистик гэмт хэргийн криминологийн шинжээс олж авдаг. Чухамдаа криминологи, виктимологи (*victima*-хохирогч /*nam*/; *vicimology* /англ/ - хохирогч судлал) гэмт хэрэгтэн, хохирогчийн хувийн байдал, тэдний хоорондын холбоог судалдаг. Тухайн төрөл, зүйлийн гэмт хэрэг үйлдэх бололцоо олгосон нийтлэг байдлын тухайд ч мөн ижил.

Криминалистикийн шинжийн энэ бүх элемент тэдний хоорондын магадлал буюу статистикийн хамаарал (*correlatio* - (лат) хоорондын холбоо, хамаарал гэсэн үг) байсан ч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд баримжаа болох үүрэгтэй. Энэ элементүүдийг криминалистикийн арга зүйн тодорхой хэсэгт ямагт судалсаар ирсэн бөгөөд криминалистикийн шинжийн ойлголт бий болсноор тэдгээрийг нэгтгэж, мөрдөн байцаалтын тодорхой нөхцөлт байдалд үнэний тухай дүгнэлт хийх магадлалыг дээшлүүлээ.



### **Бодлого**

2011 оны 12 дугаар сарын 03-наас 04-нд шилжих шөнө Баянгол дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт иргэн Б.Эрхэмбаяр нь үл таних залуучуудад зодуулж, эд зүйлээ дээрэмдүүлж, биедээ хүнд гэмтэл авсан байна.

### **Асуулт:**

1. Энэ гэмт үйлдлийн зүйлчлэлийг хийнэ үү?
2. Уг гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлно уу?

## СЭДЭВ 2. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХ АРГА ЗҮЙ

1. Гэмт хэргийг мөрдөх арга зүйн тухай ойлголт
2. Мөрдөн байцаалтын үе шатууд
3. Эсрэг үйлдлийг нотлох хэрэгсэл, арга

1. Гэмт хэрэг бүр өөрийн онцлогтой байдаг бөгөөд тэр бүрт тохирсон мөрдөн байцаах аргачлалыг боловсруулах нь боломжгүй юм. Иймээс гэмт хэргүүдийг төрөл, нийтлэг шинжээр нь бүлэглэн тодорхой төрлийн гэмт хэргүүдийг мөрдөн байцаах аргачлал боловсруулна. Гэхдээ эдгээр зөвлөмж нь хөдөлбөргүй тогтоосон журам биш харин сонгон хэрэглэж болох хувилбар гэдгийг мартаж болохгүй юм.

Мөрдөн байцаах аргачлалыг ерөнхий ба тусгай гэж ангилна. Ерөнхий ангилалд мөрдөн байцаах аргачлалын шинжлэх ухааны үндэс, зарчим, бүтэц, зэрэг нийтлэг асуудлуудыг хамруулдаг бол тодорхой аргачлалд нэг төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход криминалистикийн техник, тактикийн тодорхой арга барилыг тусгасан байдаг онцлогтой.

Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаах аргачлалыг боловсруулахад гэмт үйлдлийн арга чухал ач холбогдолтой. Мөрдөн байцаах аргачлал нь тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэгддэг төрөлжсөн аргуудыг тодорхойлж тэдгээрийн үр дүнд бий болох шинж тэмдэг, ул мөрийн онцлог, түүнийг илрүүлэх бэхжүүлэх шалган нотлох аргыг зааж өгнө.

Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаах аргачлалын дагуу мөрдөн байцаалтыг анхан, дараагийн, төгсгөлийн шатны ажиллагаанд хуваахаас гадна мөрдөн байцаалтын үедгүйцэтгэх ажилтантай хамтран ажиллах, мөрдөн байцаалтын ажиллагаанд олон нийтийг оролцуулах, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах зэрэг асуудлыг авч үздэг юм.

Мөрдөн байцаалтын анхан шатны ажиллагааны зорилго нь гэмт хэргийн шинжийг илрүүлэн тогтоож, гэмт хэргийн талаар нотлогдвол зохих байдлуудыг тогтоон, нотлох баримтыг цуглуулан бэхжүүлэх ажиллагаа болон гэмт этгээдийг олж тогтооход оршино.

Хэргийн талаар нотлогдвол зохих байдлуудыг Монгол Улсын ЭБШХ-ийн холбогдох зүйлүүдээр тодорхойлсон байдаг. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хуулийн хэм хэмжээ, мөрдөн байцаах практик, криминалистикийн аргачлалд тулгуурлан, тодорхой төрлийн гэмт хэргийн талаар нотолбол зохих нөхцөл байдлуудын жагсаалтыг сонгон ажилладаг юм.



Мөрдөн байцаалтын анхан шатанд нотлох баримтыг олж авахын тулд хуульд заасан аливаа ажиллагааг явуулж болох боловч чухам аль ажиллагааг нь эхлэн хэрэгжүүлэх нь нэн чухал болохыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийн нөхцөл байдлыг үнэлэн үзсэний үндсэн дээр өөрөө шийдвэрлэнэ.

Ингэхдээ хэргийн онцлог, мөрдөн байцаалтын тохироог тооцон үзэх нь ойлгомжтой.

Мөрдөн байцаалтын тохироо гэдэг нь мөрдөн байцаалтын тодорхой үе шатанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид буй ач холбогдол бүхий мэдээ баримтын нийлбэр цогц юм.

Мөрдөн байцаалтын тохирооны агуулгыг:

а/ Хэрэг цугларсан нотлох баримт,

б/ Мөрдөн байцаалтад ач холбогдол бүхий бусад мэдээлэл,

в/ Мэдээллийн эх сурвалж зэрэг бүрдүүлнэ.

Мөрдөн байцаалтын тохироо нь:

1. Сэтгэл зүйн хүчин зүйл (мөрдөн байцаагч болон бусад оролцогчдын хоорондын зөрчил гэх мэт),
2. Мэдээллийн хүчин зүйл (Мөрдөн байцаагчийн болон бусад оролцогчдын олж авсан мэдээллийн хэмжээ гэх мэт),
3. Процессын болон тактикийн хүчин зүйл (хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын байдал, нотлох баримт, түүний эх сурвалж, таслан сэргийлэх арга хэмжээ авсан байдал, мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа явуулах боломж гэх мэт).
4. Зохион байгуулалтын хүчин зүйл (төвлөрсөн тоо бүртгэлээс мэдээлэл авах, хүч хэрэгслийг түргэн шуурхай ашиглах боломж гэх мэт) гэсэн хэсгээс бүрдэнэ.

5. Мөрдөн байцаалтын тохироог:

а/ Ердийн ба тодорхой,

б/ Мөрдөн байцаалтыг бүхэлд нь явуулахад бий болсон тохироо эсвэл мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа явуулахад үүссэн тохироо,

в/ Зөрчилтэй ба зөрчилгүй гэж ангилж болно.

Тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн байцаах анхан шатны ажиллагааны дарааллыг тогтооход гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авсан цаг хугацаа, мөрдөн байцаалтын тохироо онцгой нөлөө үзүүлнэ.

2. Анхан шатны ажиллагаагаар тухайн гэмт хэргийн криминалистикийн шинжийг тодорхойлох ба тэдгээр нь гэмт хэргийг илрүүлэх ажиллагааны чиглэлийг сонгоход ихээхэн ач холбогдолтой.

Гэмт хэргийн криминалистик шинж гэж гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээ баримтын нийлбэр цогцыг хэлнэ. Эдгээр элементэд:

- Халдлагын зүйл,
- Гэмт хэрэг үйлдсэн болон нуун далдалсан арга,
- Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн болон гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал (цаг, хугацаа, газар орон гэх мэт),
- Гэмт этгээдийн мөр,
- Гэмт хэргийн хор уршиг,
- Гэмт этгээдийн болон хохирогчийн хувийн байдал,
- Гэмт хэргийн шалтгаан нөхцөл зэрэг орно.

Гэмт хэргийг илрүүлэхэд криминалистик шинжээс гадна бусад салбар эрх зүйн мэдлэг тухайлбал ЭЭЗ, криминологи, сэтгэл судлал, криминалистикийн техник, тактик болон бусад шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах нь зүйтэй.

Тухайлбал, хүч хэрэглэсэн гэмт хэргийн 75 хувь нь согтуугаар, гэмт хэрэгтний дундаж нас 23-27, гэмт хэрэг үйлдэгчдийн 2/3 нь гэр бүлгүй байдаг гэх мэт криминологийн үзүүлэлтийг гэмт хэрэг илрүүлэхэд тооцож байвал зохино.

Мөрдөн байцаалтын дараагийн үе шатанд гэмт буруугийн болон гэм буруугүйн байдлыг бүх талаас нь бүрэн дүүрэн нотлоход чиглэгдсэн ажиллагааг явуулна.

Энэ үе шатанд шаардлагатай урьд хийгдсэн ажиллагааг дахин явуулж болно.

Төгсгөлийн үе шатанд мөрдөн байцаалтыг дуусгавар болгон, хавтаст хэргийг ялын дүгнэлт бичүүлэхээр шилжүүлэхтэй холбогдсон ажиллагааг хийнэ.

Мөрдөн байцаагчаас хэрэг бүртгэх байгууллагатай хамтран ажиллах хэлбэр нь:

а/ Мөрдөн байцаах ажиллагаа болон гүйцэтгэх ажлын арга хэмжээг хамтран төлөвлөх,

б/ Харилцан мэдээлэл солилцох,

в/ Мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааг явуулахад хэрэг бүртгэгчээс туслалцаа үзүүлэх,

г/ Хэрэг бүртгэх байгууллагаас мөрдөн байцаагчийн өгсөн даалгаврыг биелүүлэх зэрэг юм.

Мөрдөн байцаагчаас бусад албад, байгууллагатай хамтран ажиллах боломжийг бүрэн дүүрэн ашиглах нь гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, бодит байдлыг бүрэн дүүрэн нотлоход ихээхэн ач холбогдолтой. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага нь олон түмэнтэй нягт уялдаа холбоотой байж, тэдний хүчин туслалцаанд түшиглэх ёстой. Иргэд, олон түмний туслалцааг авах нь сайн дурын



үндсэн дээр, тэдний аюулгүй байдлыг найдвартай ханган, хуулиар зөвшөөрөгдсөн хэм хэмжээний хүрээнд авагдана.

Мөрдөн байцаалтад олон нийтийн туслалцааг авахдаа дараах зарчмыг удирдлага болгоно.

а/ Олон нийтийн төлөөлөгчид нь зөвхөн сайн дурын үндсэн дээр мөрдөн байцаалтад оролцох,

б/ Олон нийтийн төлөөлөгчид нь мөрдөн байцаах ямар нэг ажиллагааг бие даан явуулж болохгүй,

в/ Мөрдөн байцаагч нь мөрдөн байцаалтын нууцыг чанд хадгалах,

г/ Мөрдөн байцаагч нь мөрдөн байцаалтад туслалцаа үзүүлж буй олон нийтийн төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Мөрдөн байцаалтын явцад гэмт хэрэг гарах болсон шалтгаан, нөхцөлийг илрүүлэн арилгах, дахин гэмт үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь ихээхэн ач холбогдолтой юм.

Урьдчилан сэргийлэх ажиллагаа нь гэмт хэргийг үүсгэгч нийгмийн сөрөг хүчин зүйлд нөлөөлөх нөхцөлийг аажмаар арилган бууруулах, хязгаарлахад чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, ёс суртахууны шинжтэй арга хэмжээнүүдийн нийлбэр цогц юм.

Мөрдөн байцаах аргачлал нь криминалистикийн техник, тактикаар дамжин мөрдөн байцаалтын ажиллагаанд биелэлтээ болж амьдралд хэрэгждэг.

3. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны эсрэг үйлдэл сүүлийн жилүүдэд онцгой тулгамдсан, хурцаар тавигдсан асуудлын нэг боллоо. Энэ нь төр, засаг, хууль хамгаалах байгууллагын ажилтнуудтай холбоотой гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа улам бүр идэвхжиж байгаатай шууд уяалдаатай. Үүнээс урьд мөрдөн байцаах ажиллагааны эсрэг үйлдэл гэж гол төлөв гэмт хэрэг нуух янз бүрийн арга, хэлбэрийг ойлгодог байсан бол одоо энэ ойлголт илүү өргөн агуулгатай болсоор түүнийг гэмт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эцэст нь хэрэгт үнэнийг тогтооход саад болох зорилготой санаатай үйлдэл гэж тодорхойлоход хүргэлээ.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны эсрэг үйлдлийг үр ашигтайгаар гэтлэх явдал хангалтгүй байх нь хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны үзүүлэлт тоо, чанарын тогтворгүй байх нэг шалтгаан. Бүртгэгдээгүй гэмт хэргийн өндөр түвшинг ч үүгээр тайлбарлаж болно.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг тусгайлан эрх олгосон албан тушаалтан - хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч явуулдаг учраас эсрэг үйлдэл уг ажилтан эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд саад болоход бас илэрнэ. Эсрэг үйлдэл тодорхой хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид ямагт хамаарахгүй; тодорхой гэмт халдлагыг бүртгэх,

мердөн байцаах ажиллагааны эсрэг бүхэлдээ чиглэсэн байж болно.

Тодорхой гэмт хэргийн тухайд авч үзвэл “дотоод”, “гадаад” эсрэг үйлдэл гэж ангилах хэрэгтэй. Хэрэг бүртгэх, мердөн байцаах ажиллагаатай холбоотой ямар нэг этгээдийн эсрэг үйлдлийг “дотоод”-ын гэнэ: сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч, мэргэжилтэн, эксперт, орчуулагч, хэлмэрч, учрал болсон газар тохиолдлоор байсан этгээд гэх мэт. Энэ этгээдүүд үйл явдлын тухай ямар нэг мэдээлэлтэй, түүнийгээ нуух, өөрчлөх буюу устгах эрмэлзлэлтэй.

Тухайн үйл явдалтай холбоогүй, эсхүл хэрэг бүртгэлт, мердөн байцаалт явуулж байгаа, эсхүл хэрэг бүртгэгч, мердөн байцаагчтай байцаан шийтгэх, албаны буюу төр, захиргааны харилцаа буюу бусад хамаарлаар хэрэг бүртгэгч, мердөн байцаагчтай холбоотой этгээдийн эсрэг үйлдлийг “гадаад” эсрэг үйлдэл гэнэ.

### **Гэмт хэрэг нуух аргыг дараах бүлэгт хуваана:**

1. Мэдээлэл, түүний агуулагчийг нуух;
2. Мэдээлэл, түүний агуулагчийг устгах;
3. Мэдээлэл, түүний агуулагчийг хувиргах;
4. Мэдээлэл, түүний агуулагчийг хуурамчаар үйлдэх;
5. Холимог арга.

**Нуух.** Уул санаагаараа нуух гэдэг үг хэргийн болон мэдээллийн эх сурвалжийн ямар нэг байдлыг мэдэгдэхгүй үлдээх гэсэн утгатай; нуух нь идэвхтэй ба идэвхигүй хэлбэрээр илэрнэ. Халдлагын зүйл, эд мөрийн баримт, гэмт хэргийн замаар олж авсан мөнгө, үнэт зүйлс, бусад объект-мэдээллийн эх сурвалж нуух, хэрэг бүртгэлт, мердөн байцаалтаас зайлсхийхийг идэвхтэйд, дугарахгүй байх, үл мэдээлэх, мэдүүлэг өгөхөөс татгалзахыг идэвхгүйд тооцно.

**Устгах.** Юунд чиглэснээр нь энэ аргыг гэмт хэргийн буюу гэмт хэрэгтний мөр устгах гэж хуваана. Бүрэн ба хэсэгчлэн устгаж болно. Хэсэгчлэн устгах нь хуурамчаар үйлдэхтэй ойролцоо, заримдаа түүний арга болдог.

**Хувиргах.** Гэмт хэрэг үйлдсэн арга, гэм буруутай этгээдийн хувийн байдал, объектын зориулалтыг өөрчлөх зорилготой. Хувиргах аргын жишээ гэвэл объектыг шилжүүлэх (тогтоосон журмаар байх газраас өөр газар байрлуулах); гэмт хэрэгтэн гадаад төрхөө өөрчлөх (хиймэл үс, нүүрээ будах, баг өмсөх, хувцас, үсний өнгөө өөрчлөх, шүдэндээ хуурамч бүрээс хийх, содон тэмдэг тавих буюу өөрчлөх гэх мэт); объектыг жинхэнэ зориулалтаар нь ашиглаагүй байдал бий болгох; хийж байгаа үйлдэл буюу явагдаж буй процесстой зэрэгцүүлэн нуух (тээврийн хэрэгслийн чимээнд объект эвдэх).



Хуурамчаар үйлдэх - худал мэдээлэл бий болгох. Хуурамч үйлдлээр гэмт хэрэг нуух арга

- Санаатайгаар худал мэдүүлэг өгөх;
- Санаатайгаар худал мэдээлэх, ховлох;
- Хуурамч мөр, эд мөрийн бусад баримт бий болгох;
- Бичиг баримтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хуурамч үйлдэх;
- Объект солих, дууриалган хийх;
- Объектыг хэсэгчлэн устгах, түүний гадаад байдлыг еерчлөх зорилгоор засварлах, дахиж хийх, зориулалтыг өөрчлөх гэх мэт.

Худал алиби нь хуурамч үйлдлийн хослосон арга. Мөрдөн байцаалтын практикт худал алиби бий болгох хоёр арга байдаг. Нэгдүгээрт, гэмт этгээд дараа нь алибийн гэрч болгохоор хамтран оролцогч буюу бусад хүмүүстэй үгсэн тохиролцоно. Мэдэгдэхүйц үнэн байдал бий болгохын тулд энэ бүх этгээд гэмт хэрэг үйлдэхээс өмнө буюу дараа нь ямар нэг хугацаагаар гэмт хэрэгтэн үнэхээр хамт байж, хожим нь өөрийн хамт байсан он, сар, өдрийг гэмт хэрэг үйлдсэн болгон өөрчилж мэдүүлнэ.

Гэмт этгээд хамт байсан он, сар, өдөр буюу цагийн талаар гэрчийг мэхлэх нь худал алиби бий болгох илүү төвөгтэй хоёрдахь арга. Энэ тохиолдолд алибийг баталж байгаа гэрч шударгаар төөрөлдөнө.

Гэмт хэрэг нуух холимог аргыг гэмт хэргийн хуурамч байдал бий болгох гэж мөрдөн байцаах практикт ойлгодог.

Гэмт хэрэг хуурамчаар бий болгохыг тухайн газар, бодитоор болж өнгөрсөн үйл явдалд үл зохицох байдлаар өөрчлөх гэж тодорхойлж болно.

Гэмт хэрэг өөрчлөх үндэс нь үйл явдлын материаллаг мөрийг зохиомлоор бий болгох явдал байдаг. Байдлыг өөрчилсөн этгээд болон түүнтэй холбоотой этгээдийн зан үйл ямагт материаллаг мөрөнд нэмэлт болно. Байдлыг өөрчилсөн этгээд цагдаагийн байгууллагад гэмт хэрэг үйлдэгдсэн мэт (жишээлбэл, хуурамч хулгайлах гэмт хэргийн тухай мэдэгдэх) мэдээлдэг.

### **Хохирогч гэмт хэрэг нуух гурван тохиолдол байдаг:**

1. Гэмт хэрэг тухайн этгээдийн жишээлбэл, түүний аймхай, шунахай, шударга биш гэх мэт чанарыг харуулсан, нэр хүнд гутаах шинжтэй байвал. Хохирогч гэмт хэргийг тухайн орчинд түгээмэл тодорхой ойлголтын улмаас өөрийн нь нэр алдрыг гутаасан явдал гэж үнэлж болно. Чухамхүү хүчиндэх гэмт хэргийг ингэж ойлгодог. Үүний улмаас хохирогч өөрийн нэр алдрыг хадгалахын тулд түүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг нуух нь дээр гэж бодох нь цөөн биш байна.
2. Хохирогч өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байвал. Хээл хахууль авах, бусдын эд хөрөнгө завших гэмт хэргийн замаар олсон мөнгө, үнэт зүйлсийг гэмт

хэрэгтэн залилан мэхэлж авсан нь үүний жишээ болно;

3. Гэмт хэрэгтэн - онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэглэлийн гишүүдээс хохирогч болсон этгээд, гэмт буруутай этгээдээс хариу авах буюу бүлгийн ашиг сонирхлыг хамгаалах хүслээр гэмт хэрэг үйлдсэн бол.

Гэмт хэрэг нуухад хүргэдэг хүчин зүйлээс гадна, энэ санааг хэрэгжүүлэх бололцоо, аргыг сонгон авахад нөлөөлдөг хэд хэдэн байдал байдаг.

Идэвхгүйгээр далдлахаас бусад гэмт хэрэг нуух бүх арга тодорхой цаг хугацаа шаардана. Нөгөө талаар олонх тохиолдолд гэмт хэрэгтэн ихэд яаравчилна. Энэ нь нуух аргын сонголт, хуурамч байдал бий болгосон үйлдэл төгс биш, хааш яаш байдлаар илэрнэ. Үүнээс гадна аргын сонголтод гэмт хэрэгтэн, халдлагын зүйлд хандах хандлага бас нөлөөлнө. Гэмт хэрэгтэн халдлагын зүйлтэй нягт холбоотой байх тусам гэмт хэрэг нуух арга төвөгтэй, нарийн болно.

Өгүүлснээс гадна гэмт хэрэг үйлдсэн аргад нөлөөлдөг тэр хүчин зүйл гэмт хэрэг нуух аргыг тодорхойлдог. Энэ нь бодит байдал, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа; нуусан газрын материаллаг объектын чанар, шинж; нуусан газар, цаг агаарын нөхцөл, нуусан этгээдийн амьдралын нөхцөл, төлөв, гэмт хэрэг үйлдэх туршлага, дадал байна.

Гэмт хэрэг үйлдэхээр санаархаж, үйлдэх, нуух арга сонгоод гэмт хэрэгтэн өөрийн үйлдлийн загварыг дотроо боловсруулна. Энэ загварын агуулга, нарийвчлал нь субъектын сэтгэлгээний түвшингээс, гэмт хэрэг үйлдэх, нуух үйлдлийн сонголт, хослол нь гэмт хэрэг үйлдэж байсан өнгөрсөн үеийн туршлага, ямар нэг мөр гэмт хэрэг илрүүлэхэд ямар ач холбогдолтойг мэдэх эсэхээс олон талаар шалтгаална.

Энэ байдал ялангуяа, гэмт хэрэг хуурамчаар бий болгоход мэдэхүйцээр илэрнэ. Өөр гэмт хэрэг буюу эрүүгийн биш шинжтэй үйл явдал дууриалган хийхдээ гэмт хэрэгтэн зохиомол үйл явдлыг тодорхойлдог шинж тэмдэг, үйлддэг арга, үлддэг онцлог мерийг мэдэж байх ёстой. Гэвч гэмт хэрэгтний санаа хэдий нарийн байлаа ч гэсэн тэрээр ихэнх тохиолдолд хуурамч байдлыг илрүүлэх, жинхэнэ үйл явдлын шинж тэмдгийг тодруулах бололцоо өгөх, их, бага ямар нэг хэмжээний алдаа заавал гаргадаг.

#### ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Криминалистикийн аргазүй, аргачлал хоёрын ялгааг гаргаарай.
2. Мөрдөн байцаалтын тохироо гэж юуг хэлэх вэ?
3. Гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагааг хэдэн үе шаттай явуулдаг вэ?
4. Алиби гэж юуг хэлэх вэ?
5. Эрсдэл гэдэгт юуг ойлгох вэ?



### СЭДЭВ 3. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХ АРГА ЗҮЙ

**Хулгайлах гэмт хэргийн криминалистикийн шинж.** Хохирогч болон бусад хүн мэдэхгүй байгаа гэсэн итгэлтэйгээр бусдын эд хөрөнгө авах далд арга хулгайлах гэмт хэргийг булаах, дээрэмдэхээс ялгаж өгнө. Хууль орон байр, байшин буюу агуулахад нууцаар нэвтрэхийг хулгайлах гэмт хэргийн хариуцлагын хүндрүүлэх нэг нөхцөл байдал болгон заасан. Үүгээрээ хулгайлах нь залилан мэхлэх, далайлган сүрдүүлэхээс ялгаатай.

Хулгайлах гэмт хэргийн бүрэлдэхүүн, түүний криминалистикийн шинж дараах байдлыг тогтоох, нотлохын чухлыг харуулж байна:

А) субъектээр нь хэн үйлдсэн, гэм буруутай этгээдийн хувийн байдал, нас, өнгөрсөн үеийн гэмт ажиллагаа (нэг бус удаа үйлдсэн); гэмт бүлгийн шинж, бүрэлдэхүүн, түүний зохион байгуулалтын бүтэц, гишүүдийн үүргийн хуваарлалт; хамаарагдсад;

Б) субъектив талаар нь урьдчилан үгсэж тохиролцсон эсэх, хэзээ, хаана, чухам юун тухай үгсэж тохиролцсон;

В) объектоор нь ямар эд хөрөнгө хулгайлагдсан, хэмжээ (ялимгүй, үлэмж, их, онц их); хулгайлсан эд хөрөнгөө хаана, хэнд, яаж борлуулсан; хулгайлагдсан эд хөрөнгө эрэн сурвалжлах ажиллагааг хүндрүүлэх ямар үйлдэл хийхээр бодсон ба хийсэн;

г) объектив тапаар нь ямар арга, байдлаар хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газар нэвтэрсэн, үүний тулд хэн, юу хийсэн; гэмт хэрэг, түүний мөрийг нуухын тулд үйлдэх буюу дараах үед ямар үйлдэл, хэн хийсэн.

Энэ гэмт хэрэг хамгийн янз бүрийн газар үйлдэгдэнэ. Орон байр, албан газар, аж ахуйн нэгж, дэлгүүр, агуулах, материаллаг үнэт зүйлс хадгалдаг газар; галт тэрэг, хүнс ба барааны зах, хотын нийтийн тээвэр болон хүмүүс ихэд цугларсан газарт халааснаас хулгайлах нь олонтой. Боллоцоо л гарвал өдөр, шөнийн ямар ч цагт хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэнэ.

Хулгайлах эд зүйл нь: мөнгө, үнэт эдлэл, телевизор, дуу, дүрс бичлэгийн техник, гутал хувцас, тээврийн хэрэгсэл, ахуйн техник, хэрэгсэл, ер нь бол авч явж болох, амархан борлогдох юу л бол юу хулгайлна. Хүн ам, зах зээлийн эрэлт хэрэгцээ, хангамжийг гэмт хэрэгтэн судалж өөрийн “үйл ажиллагаанд” байнга харгалзан үзнэ.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэх арга олон учраас түүнийг бүрэн жагсаах боломжгүй.

Хулгайлах аргын сонголт нь гэмт хэргийн ба мэргэжлийн дадал, объектын байдал, шаардлагатай техникийн ба тээврийн хэрэгсэл байгаа эсэх зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогдоно. Орон байр, дэлгүүр, агуулахаас хулгайлахад: түгжих төхөөрөмж, хаалт, агуулахыг эвдэх; эд хөрөнгө байдаг газарт чөлөөтэй нэвтрэх аргыг ихэвчлэн хэрэглэнэ. Халаанаас хувцас, цүнх зүсэх ба зүсэхгүйгээр хулгайлана. Хулгайч “стандартын” арга ч хэрэглэнэ.

Халааснаас хулгайлах гэмт хэргийг хоёр аргаар үйлдэнэ: ямар нэг эд зүйлээр халхлах (халхавч - “ширма”) буюу ийм халхавчгүйгээр шахцалдааны үед. Халаасны хулгайч аргаа удаан хугацаагаар маш нарийвчлан боловсруулах бөгөөд ингэснээр ч тэр баригдахгүйгээр олон гэмт хэрэг үйлдэх боломжтой болдог. Ял эдлээд суллагдсаны дараа мөн тэр л аргаараа халаас суйлна.

Хулгайч нь ихэвчлэн ерөнхий боловсрол муутай, хулгайлах болон бусад гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээд байдаг.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэх аргыг тодорхойлох нь түүнийг илрүүлэхэд их ач холбогдолтой.

Хулгайлах гэмт хэргийн нилээд хэсгийг бага насны хүүхэд, шаардлагатай мөнгө, эд зүйл олохын тулд архаг архичин үйлдэх нь олонтой.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэхэд бололцоо олгож байгаа нөхцөл, байдал олон: юуны өмнө хохирогчийн салан задгай байдал, эд хөрөнгөө хамгаалалтгүй орхих, хамгаалсан ч түүнд хэрэглэж байгаа түгжих төхөөрөмж нь шаардлага хангахгүй (гараар гардаг цоож зүүх, цүү, цуургыг ард нь нуглаагүй байх, уян хатан төмрөөр даруулга хийх) гэр, орон сууцаас хулгайлахад их дөхөм болж байна. Малаа хариулгагүй орхисноор малын хулгайч нарт ихээхэн бололцоо олгож, хөнгөлөлт үзүүлж, хатуухан хэлбэл түүнд тусалж байна. Халаасны хулгайч нар бидний сэтгэл зүйг сайн мэдэж байна. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх (урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлэх)-д гэмт хэрэгтнээс зарим зүйлийг “суралцах” ч илүүдэхгүй: гэмт хэрэг үйлдэх, нуух арга. Эсрэг талынхаа арга, тактикийг мэдэхгүйгээр түүнтэй тэмцэж, ялалтад хүрнэ гэж байхгүйн хэнд ч ойлгомжтой.

Мөрдөн байцаалтыг төлөвлөх. Хулгайлах гэмт хэрэгт дэвшүүлж болох нийтлэг таамаглал: а) хулгайлах гэмт хэрэг үнэхээр үйлдэгдсэн; б) хулгайлах гэмт хэрэг гараагүй хохирогч андуурсан; в) гэмт хэргийн байдлыг зохиомлоор бий болгосон. Таамаглал дэвшүүлэхдээ анхны дараах баримтад үндэслэнэ: 1) хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газрын байдал (тодорхой объект, орон нутгийн онцлог нөхцөл); 2) нэвтэрч орсон арга; 3) хулгайлагдсан эд зүйлийг борлуулах, хүлээн авах газар, түүний арга; 4) хулгайлах гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэдэг багаж, зэвсгийн төрөл; 5) хулгайлагдсан эд хөрөнгийн тоо.



Дараах баримт мөрдөн байцаалтын анхан шатанд эрүүгийн хэрэг үүсгэх, төлөвлөх үндэслэл болно:

1. Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан буюу хулгайлах гэмт хэргийг шууд илрүүлсэн иргэний мэдээлэл. Учрал болсон газар үзлэг хийх, мэдээлэгч, гэрчийг байцаах ажиллагааг төлөвлөнө. Гэм буруутай этгээд, хулгайлагдсан эд зүйлийг тогтоох, эрэн сурвалжлах шуурхай арга хэмжээг төлөвлөгөөнд мөн заана,
2. Эзэмшигч буюу бусад иргэний орон байранд хулгайлах гэмт хэргийн тухай гарсан гомдол. Гомдол гаргагч (хохирогч), гэрчийг байцаах, учрал болсон газар үзлэг хийх, гэмт хэрэг, гэмт этгээдийн мөрөнд хийгдэх экспертийн шинжилгээ, эрэн сурвалжлах арга хэмжээг төлөвлөгөөнд заана,
3. Явж байх замдаа өөрийн эд юмсыг алдсан тухай зорчигчийн гомдол. Мэдээлэгчийг байцаах, гэрчийг тогтоож байцаах, эрэн сурвалжлах арга хэмжээ төлөвлөнө,
4. Тээврийн хэрэгсэл алдагдсан тухай эзэмшигчийн гомдол. Хулгайлах гэмт хэрэг гарсан байдал, хулгайлагдсан тээврийн хэрэгслийн шинжтэмдгийн талаар гомдол гаргагчийг байцаах; учрал болсон газар үзлэг хийх; харсан хүн буюу бусад гэрчийг байцаах ажиллагааг төлөвлөгөөнд тусгана,
5. Мэдсэн даруйдаа гаргасан, халааснаас хулгайлах гэмт хэргийн тухай гомдол. Хулгайлагдсан эд зүйл, мэдсэн байдлын талаар гомдол гаргагчийг байцаах, хохирогчийг оролцуулан гэмт этгээдийг эрэн сурвалжлах идэвхтэй арга хэмжээ авна,
6. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурорын байгууллагын санаачлага (өөрөө шууд илрүүлэх). Мөрдөн байцаалтын төлөвлөгөөг гүйцэтгэх ажлын арга хэмжээний төлөвлөгөөтэй зохицуулна,
7. Гэмт хэрэг үйлдэж байх үед нь буюу үйлдсэн даруйд нь гэмт этгээдийг баривчилсан. Баривчлагдагчийг байцаах, бие, орон байранд нь нэгжлэг хийх ажиллагааг төлөвлөн явуулна.

Мөрдөн байцаалтын анхан шатны ажиллагаа. Хулгайлах гэмт хэрэг мөрдөн байцаах анхан шатанд дараах нөхцөлт байдал байна: 1) гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээд баривчлагдсан; 2) гэмт хэрэг үйлдсэн этгээд баривчлагдаагүй боловч түүний хувийн байдлын тухай тодорхой мэдээлэл байгаа; 3) хулгайлах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн тухай цагдаагийн байгууллагын тоо бүртгэлд уг этгээд байхгүй байх.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, хулгайлагдсан эд хөрөнгийн нэр, тоо, шинж тэмдэг, сэжиглэгдэж байгаа этгээдийн талаар мэдээлэгч буюу хохирогчийг байцаана.

Үйлдвэр, худалдааны болон албан байгууллага, агуулахаас эд хөрөнгө алдагдсан бол түүний хамгаалалт хариуцсан этгээдээс дараах байдлыг тодруулна.

1. Алдагдсан эд зүйл, хулгайлагдсанаас илүү үнэ цэнтэй эд зүйл үлдсэн эсэх, хаана байсан; алдагдсан эд хөрөнгийг хэзээ авсан, түүнийг хэн мэдсэн; хулгайлагдсан эд юмсын төрлийн ба тус бүрийн шинж тэмдэг (нэр, зориулалт, дугаар, барааны тэмдэг, боодол гэх мэт), ямар үнэтэй,
2. Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг; алдагдсан эд зүйл хамгийн сүүлд хэзээ байсан; ямар нэг байдлын улмаас гэмт хэрэг илрүүлж чадахгүй хугацаа (баяр ба амралтын өдөр, эд хөрөнгийг битүүмжилсэн, гүйлгээг зогсоосон гэх мэт),
3. Байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны дэглэм, агуулахад хэн чөлөөтэй орж болох, түүнийг яаж хамгаалдаг; тэнд үлдсэн байж болох этгээдийг илрүүлэх зорилгоор ажлын дараа байр, агуулахад шалгалт хийдэг эсэх; хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх өдөр ажлын дэглэм зөрчигдсөн эсэх, хэрэв тийм бол хэний шийдвэрээр өөрчилсөн, үүнийгхэн мэдэх, харуул, хамгаалалтын орон тооны ажилтныг халж сольсон байна уу, байсан бол үүнийг хэн мэдэх, ажил үүргээ тэр хэрхэн гүйцэтгэж байсан,
4. Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх үед байгууллага, аж ахуйн нэгжид ажиллахаа больсон ба гадны сэжигтэй этгээд ирсэн эсэх, түүний содон тэмдэг, юу сонирхож явсан, хэнтэй уулзсан,
5. Урьд нь цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй хулгайлах гэмт хэрэг, завдалт гарч байсан эсэх; хэн түүнийг ямар байдалд үйлдсэн, чухам юу хулгайлагдсан, хулгайлахыг завдсан, түүнийг яаж таслан зогсоосон, яагаад түүнийг мэдэгдээгүй.

Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хариуцсан этгээд, эзэмшигчийг байцаахдаа завшсан буюу үрэгдүүлсэн, хураах эд хөрөнгийг нуух зорилгоор хулгайлах гэмт хэргийн байдлыг зохиомлоор бий болгосон байж болохыг анхаарах хэрэгтэй.

Орон байрнаас хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд хохирогчийг байцаахад дараах байдлыг тогтооно:

1. Ямар эд юмс хулгайлагдсан, хохирогчид түүний байгааг хэн мэдэх, түүний тус бүрийн шинж тэмдэг, хохирогчид түүний төсөөтэй эд юмс үлдсэн эсэх, үнэ, хэзээ худалдаж авсан,
2. Хаана хадгалж байсан, хэн түүнийг худалдаж авсан, хэрэглэж байсан эсэх, хаана хадгалдгийг хэн мэдэх; хэн нэгэн түүнийг ямар нэг хугацаагаар авч байсан эсэх, ямар байдалд, хэзээ эргүүлж өгсөн; ломбард, банк, бусад газар өгч байсан эсэх, хэн түүнийг мэдэх,
3. Хэн, хэзээ, ямар байдалд хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэнийг мэдсэн; хохирогчийн бодлоор гэмт хэрэг хэдэн цаг үйлдэгдсэн байж болох,
4. Ямар байдалд гэмт хэрэг үйлдэгдсэн байж болох; ямар нөхцлөөс болж гэмт хэрэг гарав, хэн энэ нөхцөлийг мэдэх,



5. Хохирогч хэнийг сэжиглэж байгаа; гадны ямар хүн гэмт хэрэг үйлдэгдэхийн өмнө тэднийд ирж байсан, юун тухай ирсэн, тэрээр түүний эд хөрөнгийг сонирхож байсан эсэх.

Хэрэг болсон газар хийх үзлэгээр дараах асуултад хариу болох баримт илрүүлэх хэрэгтэй.

- А) Хулгайч ямар аргаар байранд нэвтэрсэн, ямар багаж, зэвсгээр эвдсэн, ямар мөр үлдсэн, түгжих төхөөрөмж, хаалга, цонхны байрлал, байдал;
- Б) Гэмт хэрэгтэн хаагуур орсон, ямар чиглэлд, юугаар явсан; тээврийн хэрэгсэл ашигласан эсэх, ашигласан бол чухам ямар, гэмт хэрэг үйлдэгдэх үед тэр хаана байсан;
- В) Хэн хулгайлсан, хулгайч хэдүүлээ байсан, гэмт хэргийн газар хэр удаан байсан, тэдний биеийн хүчний чадвар, гэмт хэрэгтэн мэргэжлийн ба гэмт хэргийн дадалтай эсэх, хэрэв тийм бол чухам ямар, гэмт хэргийн өвөрмөц мухар бишрэл, заншлын шинж тэмдэгт дүгнэлт хийвэл тэрээр мэргэжлийн гэмт хэрэгтэн байж болох эсэх;
- Г) Чухам юу хулгайлагдсан. Эзэмшигч буюу эд хөрөнгө хариуцагч этгээд илүү бүрэн хариу өгнө. Шаардлагатай үед тооллого, шүүх-нягтлан бодохын шинжилгээ хийлгэж болох боловч үзлэгийн явцад урьдчилсан дүгнэлт хийж болно. Үүнээс гадна үзлэгийн баримтыг ашиглан хулгайлагдсан эд хөрөнгө, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг цааш нь мэдүүлгээр шалгана;
- Д) Ямар байдал цаашид гэмт этгээдийг илчилж болох. Эвдэх багаж, зэвсэг, гэмт этгээдийн мөр, хулгайлагдсан эд хөрөнгийн боодлын хэсэг, дугаартай эд юмсын бичиг баримтаас гадна гэмт хэрэгтний гэсэн эд зүйл, хувцасны хэсэг, тамхины иш гэх мэт байж болно.

Мөрдөн байцаалтын энэ шатанд гэрчийг байцаахдаа сэжигтэн, тээврийн хэрэгслийн содон тэмдгийг юуны өмнө тодруулна. Энэ мэдүүлгээр сэжигтний аман зураг гаргаж болно.

Шинжилгээ ялангуяа, эвдсэн ба гэмт хэрэгтний мөрөнд хийх криминалистикийн шинжилгээ их ач холбогдолтой. Шинжилгээ зөвхөн гэмт хэрэгтний нэвтрэн орсон үйлдлийн механизм, гэмт хэрэгтний тоо, явсан чигээр зогсохгүй дараа нь гэмт этгээдийг адилтгаж болох баримтыг ч тогтооно.

Хулгайчийг үйлдэл дээр нь баривчилсан халааснаас хулгайлах гэмт хэргийн мөрдөн байцаалтын анхны шат нилээд онцлогтой. Үйлдэл дээр нь баривчлах нь халаасны хулгайчийг илчлэх хамгийн үр ашигтай хэрэгсэл. Хохирогч өөрөө, харсан хүн - гэрч, халааснаас хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх талаар мэргэшсэн цагдаагийн байгууллагын шуурхай хэсэг баривчилж болно. Халаасны хулгайчийг гэмт хэрэг үйлдэх үед нь баривчлахад мөрдөн байцаалтын анхны дараах ажиллагаа явуулна:

- Биед нь нэгжлэг хийх;
- Баривчилсан газар үзлэг хийх;
- Баривчлагдсан этгээдийн хувийн байдал, оршин суугаа газрыг тогтоох;
- Бүх хохирогч, харсан хүн буюу гэрчийг тогтоох, байцаах;
- Баривчлагдсан этгээдийгбайцаах;
- Эд мөрийн баримтад үзлэг хийх: гэмт хэргийн зэвсэг, багаж (сахлын хутга / бритва), хутга, халхавч, хувцас, гэмтлийн мөртэй хохирогчийн авч явсан эд зүйл;
- Баривчлагдагчийн орон байр, хулгайлсан эд зүйлээ хадгалдаг бусад газар нэгжлэг хийх.

Биед нь хийх нэгжлэг онцгой чухал. Энэ нэгжлэгээр хулгайлагдсан мөнгө, үнэт зүйлс, гэмт хэргийн зэвсэг илрүүлж болно. Ийм зүйлийн илчлэх ач холбогдлыг мэддэг учраас халаасны хулгайч аль болохоор түүнээс түргэн салахыг эрмэлзэх тул түүнийг баривчлахын өмнө, дараа нь байнгын ажиглалтад байлгах, баривчилсан газар үзлэг хийх шаардлагатай. Тогтоосон бүх хохирогч, харсан хүн - гэрчийг баривчлагдсан этгээдийн дараа байцаана.

Баривчлагдагчийг байцаахдаа: гэмт хэрэг үйлдсэн арга, баривчлагдсан байдал, хамтран оролцогч, хулгайлсан эд зүйлээ хадгалдаг газар байгаа эсэх, хулгайн эд зүйлээ борлуулдаг аргыг тодруулна. Хэрэв тэр халааснаас хулгайлах гэмт хэрэг үйлдсэнээ үгүйсгэж байвал хаана байсан, баривчлагдахын өмнө юу хийж байсан, яагаад баривчлагдсан шалтгааны тухай түүний тайлбарыг хамгийн жижиг зүйл хүртэл дэлгэрэнгүйгээр бэхжүүлэх хэрэгтэй.

Сэжигтэнг криминалистикийн төрөл бүрийн тоо бүртгэлээр шалгах, төсөөтэй аргаар үйлдэгдсэн, илрээгүй байгаа халааснаас хулгайлах гэмт хэргийн тоо бүртгэл, архивийн материалд шинжилгээ, дүгнэлт хийх, сэжигтэнг эрэн сурвалжлах, гэмт хэрэгтний содон тэмдэг, хулгайлагдсан эд зүйлийн талаар цагдаагийн бусад байгууллагад мэдээлэх; хулгайлагдсан эд зүйл борлуулж болох газарт ажиглалт хийх шуурхай-эрэн сурвалжлах арга хэмжээ авна.

Мөрдөн байцаалтын дараах ажиллагаа. Юуны өмнө хэрэв анхан шатанд хийгдээгүй бол сэжигтэн, яллагдагчийн орон байр, урьдчилан үгсэж тохиролцсон, тохиролцоогүй хамаарагсад, субъектын орон байранд нэгжлэг заавал хийнэ. Эрлийн үндсэн объект нь хулгайлагдсан эд хөрөнгө, гэмт хэргийн зэвсэг байна.

Дараа нь сэжигтнийг харсан хүн - гэрчээр таньж олуулна.

Бүлэглэн үйлдсэн тохиолдолд сэжигтэн буюу яллагдагчийг байцаахад ерөнхий асуултаас гадна хамтран оролцогч бүрийн үүргийг тодруулна, зохион байгуулагчийн хувийн байдал, үүрэг, хулгайлсан эд хөрөнгийг нуух, борлуулахаар урьдчилан амласан хамаарагсадын хувийн байдлыг тогтооно. Хэрэв бүлгийн гишүүд тойргоор



даахаар тохиролцсон байвал хамгийн “сул хэсэг” - гэмт хэргийн тогтвор муутай оролцогчийг тогтоохоос эхэлнэ.

Шамшигдуулах гэмт хэргийн зохиомол байдал илрүүлэх нь еерийн онцлогтой. Өөрт нь итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгийгзавшсан, үрэгдүүлсэн үйлдлээ нуух зорилгоор хуурамч гэрч энэ байдлыг бий болгоно. Шамшигдуулах бүх гэмт хэрэгт зохиомол байдал бий болгож болох боловч тохиолдолд илүү нийтлэг шинжтэй.

Зохиомол байдал бий болгосон тухай таамаглалыг хэрэгт дэвшүүлсэн бусад таамаглалтай хамтруулан нэг зэрэг шалгана. “хулгайлах” учрал болсон газар үзлэг, мөрдөн байцаалтын туршилт хийх, экспертиз хийлгэх нь зохиомол байдлыг нотлох, илчлэх үр ашигтай хэрэгсэл.

“Хулгайлах” хэргийн газар үзлэг хийхдээ зохиомол байдал бий болгосныг нотлох сөргүү байдлыг тогтооно:

- Объектод нэвтрэхэд байх ёстой болон бодит байдалд байгаа гэмтлүүд өөр хоорондоо тохирохгүй байх;
- Шаардлагагүй, гэмт хэргийн нөхцөлтэй холбоогүй, эд зүйл, үнэт зүйлс хадгалдаг газрыг эвдсэн байх;
- Гадны хүн мэдэхгүй, мэдэх ч учиргүй газар хадгалдаг илүү үнэ цэнтэй үнэт зүйлс үгүй байх;
- Байх ёстой газар гэмт хэрэг, гэмт хэрэгтний мөр илрэхгүй байх;
- Алдагдсан гэх эд хөрөнгийн шинж объектив нөхцөлд тохирохгүй байх.

Хулгайлах гэмт хэргийн байдлын тухай хохирогчийн мэдүүлгийг шалгах, хулгайлах гэмт хэрэг үнэхээр үйлдэгдсэн бол үлдсэн байх учиртай мөрний шинжийг тогтоох зорилгоор мөрдөн байцаалтын туршилт хийнэ. Хулгайлах гэмт хэргийн газар нэвтэрсэн, гэмт хэрэгтний ашигласан гэх аргыг тогтоох; хулгайлагдсан гэх тооны бараа тухайн газар багтах эсэхийг шалгах; хулгайч тодорхой хугацаанд тухайн тооны бараа зөөж чадах эсэхийг туршилтаар тогтооход онцын бэрхшээл байхгүй.

Хулгайлах гэмт хэргийн зохиомол байдлыг илчлэх, үйл явдлын механизмыг объективноор үнэлэхэд криминалистикийн шинжилгээ, гэмт хэрэг үйлдэх үед байсан, хулгайлагдсан гэх тэр бараа - материалын үнэт зүйлс үнэхээр байсан эсэхийг тодорхойлоход шүүх нягтлан бодох шинжилгээ ач холбогдолтой байдаг.

### **Бодлого**

1998 оны 4 сард Баянгол дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байх Төмөр замын зорчигчдын тасалбар худалдах төвийн гадна зогсож байсан Говьсүмбэр аймгийн Сэргээн босголт банкны салбарын зузаатгалын 15 сая төгрөг авч явж байсан УАЗ-469 маркын автомашин хулгайлсан.

Уг автомашиныг Баянхошууны 9-р хорооны нэгэн зэлүүд байх жалганд хаясан байсныг 1 хоногийн дараа илрүүлсэн.

### Асуулт.

1. Энэ хэргийн газраас ямар, ямар мөр илрүүлж, бэхжүүлэх боломжтой вэ?
2. Тээврийн хэрэгслийг илрүүлсний дараа ямар, ямар мөр илрүүлж, бэхжүүлэх вэ?
3. Энэ гэмт хэргийн криминалистик шинжийг тодорхойлно уу? Тэдгээрийг хэрхэн тогтоох вэ?
4. Та мөрдөн байцаагч байсан бол хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн мөр ашиглан ямар таамаглал дэвшүүлэх вэ?
5. Энэ гэмт хэргийг шалгахад ямар, ямар байцаан шийтгэх ажиллагаа явуулах вэ? Төлөвлөгөө хийнэ үү?



## ГУРАВ. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙГ ЗААХ АРГА ЗҮЙ

### 1. “Криминалистик” хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

Нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэх зорилгоор криминалистикийн шинжлэх ухааны боловсруулсан техникийн хэрэгсэл, арга зүй, арга барилаар дамжин хэрэг бүртгэх, мөрдөх ажиллагаа нь шүүхийн практикт биелэлээ олдог.

Энэхүү хичээл нь эрх зүйч мэргэжлээр суралцаж буй оюутны заавал судлах мэргэшүүлэх хичээл бөгөөд энэхүү хичээлийг судлахгүйгээр гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжгүй юм. Иймд дараах шаардлага тавигдана. Үүнд:

1. Хичээлийн зорилгыг хангахуйц арга, хэлбэрийг сонгох, тэр нь хичээлийн агуулгад тохирсон байх;
2. Мөрилрүүлэх, бэхжүүлэх, битүүмжлэхэд шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн ашиглан хичээлийг заах;
3. Гэмт хэргийн зохиомол нөхцөл бий болгох сургалтын орчинтой байх;
4. Оюутнууд хичээлд жигд, идэвхтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;
5. Хичээлийн арга зүй нь онолд суурилсан, оюутнууд өөрсдөө даалгаврыг биечлэн гүйцэтгэж чадвар олж авахад чиглэгдсэн байна.

## 2. Мэдээлэл түгээх арга, аргачлал

### А. Лекц (Lecture):

Лекцийн арга нь онолын мэдлэг, ойлголтын түвшний зорилтыг хангахад тохиромжтой байдаг бөгөөд энэ шинжлэх ухааныг судлахад лекцийн аргыг өргөнөөр ашигладаг. Лекц нь мэдээллийг онолын өндөр түвшинд боловсруулан түгээх, асуудал дэвшүүлэх сургалтын суурь аргын нэг юм.

Бүх сэдвүүдийг зөвхөн лекцийн аргаар заах нь төдий л тохиромжтой биш байдаг учир тохиолдол шинжлэх (case-study) аргыг хослуулан ашиглах хэрэгтэй.

### Лекцын аргыг хэрэглэхэд анхаарах зүйл

- Хүн анхаарлаа дунджаар 15-20 минут төвлөрүүлдэг тул лекц урт хугацаагаар үргэлжилэх нь зохимжгүй бөгөөд боломжтой нөхцөлд сургалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс хэлэлцүүлэг, эвлүүлгийн болон бусад аргыг хамт ашиглах нь зүйтэй.
- Хүн нэг зэрэг 7-оос илүүгүй мэдээллийг тогтоох боломжтой гэж судлаачид дүгнэсэн байдаг.

- Барууны судлаачдын дүгнэснээр оюутнуудын 60-65 хувийнх нь харааны ой, 20-25 хувийнх нь сонсох ой илүү хөгжсөн байдаг ба хүмүүсийн 15-20 хувийг үйл хөдлөлөөр дамжуулан сургадаг байна.
- Багш ярихын хажуугаар үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд суралцагчдын тогтоох мэдээллийн хэмжээ 25 хүртлэх хувиар нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70% хүртэл өсдөгийг багш бүхэн анхаарах шаардлагатай.

### **Б. Эвлүүлгийн арга (Jacksaw):**

Энэ арга нь оролцогчдод богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад ашигладаг. Эвлүүлгийн аргын зорилго нь оюутанууд бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй хичээлийг тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах ба сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй.

Зарим сэдвийг судлахад оюутнуудад дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэл лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг жижиг багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна. Бэлтгэсэн материалаа нэг дугтуйд хийж багуудад тараан өгнө.

Эвлүүлгийг хэрэглэхдээ баг тус бүрт нэг ижил даалгавар, материал өгөх бөгөөд тодорхой асуудлын талаар мэдлэг бүтээх зорилготой. Багийн гишүүд өгөгдсөн сэдвийн дагуу өөр өөрсдийн санал бодлыг цаасан дээр бичнэ. Тэдэнд санал бодлоо бичих, илэрхийлэхэд хангалттай хугацаа өгөх хэрэгтэй ба багш баг бүрт очиж материалаа ойлгож байгаа эсэх талаар асууж арга зүйн туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Багууд дотроо тухайн асуудлаар ярилцан үзэл бодлоо илэрхийлэх үндэслэлээ гаргаж, нэгдсэн тайлбараа гаргахад бэлтгэнэ.

Үүний дараа баг бүр өөрсдийн санал бодлоо бусад багуудад тайлбарлах, багуудаас асуусан асуултанд хариулах, харилцан мэтгэлцэх замаар мэдлэг бүтээх ба оюутнуудаас гаргасан асуултанд багш хариулах, харилцан ярилцах, маргаантай асуудлыг тайлбарлах, шийдвэр гаргах замаар мэдлэгийг цэгцэлнэ.

Хичээлийн эцэст багш багуудын хариултыг дүгнэж идэвхитэй оролцсон оюутанд үнэлгээ өгнө.

### **В. Хүн бүр багш (Each one teach one)**

Бүлэг сэдвийг танилцуулахад болон үзсэн сэдвийн агуулга ухагдхууныг дүгнэх, лекцийн агуулгыг оюутнуудад хүргэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Энэ аргын зорилго нь сургалтын үйл явцад идэвхтэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход оролцогчдод ихээхэн ач холбогдолтой болно.



Хүн бүр багш аргыг хэрэглэснээр хичээлээр заавал эзэмших ёстой агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба оюутнуудын сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

### **3. Оролцооны арга, аргачлал**

#### **А. Тохиолдол шинжлэх (case method)**

Энэ арга нь суралцагчдад криминалистикийн техник, тактик зүйн ойлголтыг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн тайлбарлаж сурахад туслахад чиглэгдсэн асуултын аргад тулгуурласан хэлбэр юм.

Криминалистик хичээлийг тохиолдол шинжлэх аргаар явуулах тун тохиромжтой бөгөөд амьдрал дээр гарсан гэмт хэрэг, тохиолдлыг оюутнууд шийдвэрлэх замаар онолын мэдлэгээ баталгаажуулах өргөн боломжтой болдог.

Тодорхой жишээ гэдэг нь түүхэн явдал, бодит хэрэг, зохиомол үйл явдал, шүүхийн сонсгол мэдээ зэрэг суралцагчдад шинжлэх ухаан, технологи, нийгэм эрх зүй, хүний эрхийн асуудлаар шинэ сэргэг ойлголт, мэдлэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдсэн хэрэглэгдэхүүн юм.

Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан гэмт хэргийн талаарх янз бүрийн мөр, мэдээлэл, тоо баримт, техник хэрэгсэл болон холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх зайлшгүй шаардлагатай.

Зорилго: Сургалтын энэ арга нь суралцагчийг ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд чухам ямар элемент нь чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, тохиолдол бүрт эргэцүүлэн бодож байх боломж олгодог.

#### **Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?**

- Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл, санааг гаргадаг.
- Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.
- Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага, чадварыг хөгжүүлж, бие даасан задлан шинжилгээ хийх болон шийдвэр гаргах хүнд бэрх сэтгэн бодох үйлдэлд дасгана.
- Хүний сэтгэл хөдлөл, мэдрэмжийг таниулахын зэрэгцээ суралцагчдын дүрслэн бодох сонирхол, сэтгэлгээг өдөөдөг.

- Танхимд суралцаж буй суралцагчдыг бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Суралцагчдад мэдсэн, сурсанаа хэрэглэх боломж олгохын зэрэгцээ хүний эрх, эрх зүйн салбарт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:

Хэдийгээр авч байгаа тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг орлохгүйг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл мэдэгдэм, үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрдэг. Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-с илүүгүй оюутан оногдохоор тооцоолох хэрэгтэй бөгөөд илүү олон оюутантай багш нэгэн зэрэг ажилласан тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг.

Холбогдох гарын авлага, мөр, мөртэй ажиллах техник хэрэгсэл, материал зайлшгүй хангагдсан байх ёстой бөгөөд энэ шаарддага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломж багатай.

### **Б. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга**

Энэ арга нь эсрэг, тэсрэг үзэл бодлыг оюутнууд хамтран хэлэлцэх, өөрийн санал бодол, байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, өрсөлдөгчийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгох зорилготой.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг хийх аргаар хичээлийг явуулахад оюутанд эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах, нотолгоог дэвшүүлэх чадвар хөгжих, байр суурь, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар, хандлага төлөвших боломжтой.

Суралцагчдаас, уг хэрэгт тэдний үзэж байгаагаар хамгийн чухал МАРГААНТАЙ АСУУДЛУУД нь юу болохыг асууснаар багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг, ярилцлагаа эхэлж болох юм. Хичээлийг явц, дүнгээс шалтгаалаад олон төрлийн асуудлууд гарч болох юм. Энэхүү арга нь орчин үед хөгжиж буй “өмгөөлөх криминалистик”-ийн талаар оюутнуудад мэдлэг олгохоос гадна чадвар суулгах ач холбогдолтой.

### **Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:**

- Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэхийг тогтооно.
- Хуулийг дээдлэхэд болон ардчиллыг хөгжүүлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой эсэх.
- Энэ асуудал нь тухайн ангид хэлэлцэхэд тохиромжтой болон суралцагчдын хувьд ач холбогдолтой эсэх.



### **Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:**

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтандаа байлгахад дараахь дүрэм нь багшид тус болно. Тухайлбал, дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.

- Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусаддаа олгоно.
- Өөрийн байр суурийн эргэлзээтэй зүйл, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна.
- Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

### **Хэрэгжүүлэх дараалал:**

- Ангийн булангуудад хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран “Санал бүрэн нийлж байна”, “Санал нийлж байна”, “Шийдээгүй буюу эргэлзэж байна”, “санал нийлэхгүй байна” гэсэн бичиг бүхий цаасыг дээрх дарааллаар байрлуулсан байна.
- Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батлана.
- Хэлэлцэж буй асуудлын хүрээнд суралцагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
- Суралцагчдыг өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх суралцагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой сурагчид нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
- Өөрсдийн байр сууриа тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж өөр буланд очихыг хүсэж байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй хүн гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.
- Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

## **В. Жижиг багаар ажиллах (Group work)**

“Жижиг багаар ажиллах” энэхүү арга нь бусдыг анхааралтай сонсох, нэгдсэн дүгнэлтэнд хүрэх, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, багаа төлөөлөх зэрэг чадварыг амьдралд хэрэглэх боломжийг оюутанд олгодог.

Энэхүү аргын зорилго нь хамтран ажиллах болон бусдыг ойлгох зэрэг чухал чадваруудыг эзэмших боломжийг олгодоггоос гадна өөр хоорондоо зөрүүтэй бодол санааг нийцүүлэхэд тусалдаг. Багаар ажиллахад дасгал дээр ажиллуулах шаардлага зүй ёсоор тулгардаг. Жижиг багаар ажиллах аргыг тохиолдол шинжлэх, маргаантай асуудлаар хэлэцүүлэг явуулах аргуудтай хослуулан явуулах нь илүү үр дүнтэй байдаг.

### **Жижиг багаар ажиллуулахад юу анхаарах хэрэгтэй вэ?**

- Суралцагчид тухайн ажлыг гүйцэтгэх мэдлэг, дадал, чадвар эзэмшсэн байх ёстой. Эзэмшээгүй тохиолдолд тэд тухайн даалгаврыг хийж гүйцэтгэх ямар ч сонирхолгүй байх тул та үүнийг нэн түрүүнд мэдэх шаардлагатай.
- Багт ажлын зааварчилгааг маш тодорхой өгөх ёстой. Нэг дор хоёроос дээш зааварчилгаа өгөхгүй байх.
- Жижиг багт тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд хангалттай цаг хугацаа олгох ёстой. Түрүүлж ажлаа дуусгасан багийг бусаддаа саад болгохгүйн тулд юу хийлгэхээ сайтар төлөвлөсөн байна.
- 3-6 гишүүнтэй баг бүрдүүлэх. Жижиг багийн хувьд 6 гишүүнтэй байх нь хамгийн дээд хэмжээ байна.
- Бие дааж болон хамтаараа ажиллах чадварыг зэрэг хөгжүүлэх буюу тэнцвэртэй байлгахыг зорьсон асуудал, даалгаврыг өгөх ёсгүй. Учир нь жижиг багаар ажиллах аргыг ширээ тойрон сууж бие даан ажиллах чадварыг бус зөвхөн хамтаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд л ашиглах нь илүү тохиромжтой байдаг.
- Энэ аргыг тодорхой зорилготойгоор, тохиромжтой үед, дүрмийн дагуу хэрэглэх ёстой болохоос биш зөвхөн лекцийг орлуулах нэгэн арга болгон ашиглаж үл болно.
- Баг доторхи удирдлагын асуудлыг мөн тооцож үзэх ёстой. Багаас нэг гишүүн хийсэн зүйлээ танилцуулах тохиолдолд тэр суралцагчийг шударгаар сонгоход анхаарах.
- Багаар ажиллахад гарах дуу чимээг хүлээн зөвшөөрөх ёстой.
- Жижиг багаар ажиллах явцад суралцагчид бие биеийнхээ нүдийг харах боломжтой байдлаар суусан байна. Гишүүн тус бүр бусад гишүүдээ төвөггүйгээр харж, харьцах ёстой.



## Г. Дүрд тоглох арга

Дүрд тоглох аргыг зарим төрлийн хичээлийг явуулахдаа ашиглаж болох бөгөөд оюутнууд өөрсдөө эрдэмтэн, судлаачид, багшийн дүрд тоглох замаар тэдний хэлж байсан үг, сургаалиудыг хэлэлцүүлэх, асуудалд нээлттэй хандах замаар мэтгэлцэх зэргээр хичээлийг явуулах нь үр дүнтэй. Түүнчлэн оюутнууд хохирогч болон судлаачийн дүрд, зарим нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгчийн дүрд тоглож тэднээс ярилцлага авах, тоо баримт шаардах зэргээр хичээлийг явуулна.

Ялангуяа “Криминалистик” хичээл дээр дүрд тоглох аргыг хэрэглэх өргөн боломжтой бөгөөд оюутнууд шүүх хуралдаанд оролцогсод, шүүгч, прокурор, өмгөөлөгчийн дүрд тоглож мэдлэгээ баталгаажуулах, ярих, илтгэх чадвараа дээшлүүлэх боломжийг олж авдаг. Энэ аргыг ихэвчлэн “мини шүүх” аргатай хослуулах нь илүү үр дүнтэй.

## Д. Сургалтын шүүх ажиллагаа (мини шүүх)

Энэ арга нь “Криминалистик” хичээлээр амьдралд болсон үйл явдал гэмт хэрэг, зөрчлийг оюутнууд өөрсдөө дүрд тоглох замаар уг сэдвийн агуулгыг нээн харуулах зорилготой.

Мөн шүүх хурал явуулах замаар зарим сэдвээр оюутнуудад өөрсдөө мэдлэг бүтээх боломжийг олгодог. Жишээ нь: Шүүх хуралд прокурор буюу улсын яллагч, шүүгдэгч, хохирогч, шүүгч нараас гадна гэрч, өмгөөлөгч, шинжээч зэрэг тухайн тохиолдлыг шүүхэд шаардагдах бүх дүрүүдийг хуваарилаж бэлтгэх хэрэгтэй болдог.

Мөн анги танхимаа шүүхийн танхимын байдлаар засах хэрэгтэй учир нь дээрх арга илүү бэлтгэл, цаг хугацааг шаарддаг. Шүүх ажиллагааны дарааллыг шүүгч, прокурор нар болон бусад оролцогчдод урьдчилан хэлж өгсөн байна. Хичээлийн анги танхимыг урьдчилан бэлдсэн, хаягийг тавьсан байна. Жишээ нь: шүүгчид, шүүгдэгчид, яллагч, нарийн бичгийн дарга, индэр гэх мэт.

## 4. Загвар хичээл (Семинар)

**Хичээлийн сэдэв:** Мөртэй ажиллах арга зүй

### Сэдвийн зорилго:

криминалистикийн мөр судлал, мөрний ангилал, төрөл, мөртэй ажиллах арга зүй, зарчимын талаар тодорхой ойлголттой болох, мөртэй зөв харьцаж, ажиллах дадал эзэмших зорилготой.

## Санал болгож байгаа арга:

- Жижиг багаар ажиллах.
- Тохиолдол шинжлэх.
- Дүрд тоглох аргуудыг хослуулна.

## Нэр томьёо:

- Мөр
- Мөр-дүрс
- Мөр-эд
- Мөр-бодис
- Макро, микро мөр
- Гүн, өнгөц мөр
- Үзэгдэх, бүдэг, үл үзэгдэх мөр
- Динамик
- Статик

## Агуулга:

1. Мөртэй ажиллах арга зүй, дараалал, зарчим.
2. Мөр илрүүлэх арга зүй.
3. Мөр бэхжүүлэх арга зүй.
4. Мөр битүүмжлэх арга зүй.

## ХЯНАЛТЫН АСУУЛТ:

1. Мөртэй ажиллах арга зүй, дараалал, зарчмыг дурьдана уу?
2. Мөр илрүүлэх хэдэн арга байдаг вэ?
3. Гарын мөрийг ямар аргаар илрүүлэх вэ?
4. Мөр бэхжүүлэх хэдэн арга байдаг вэ?
5. Гутлын улны мөрийг хэрхэн бэхжүүлдэг вэ?
6. Мөр битүүмжлэх дэс дараалал, анхаарах асуудлыг ярина уу?
7. Архины шилийг хэрхэн битүүмжлэх вэ?



### **Үйл ажиллагааны дараалал:**

Багш хичээлийн зорилго, явагдах дэс дарааллыг тайлбарласны дараа оюутнуудыг 1-5 хүртэл тоолуулж жижиг багуудад хуваана.

Баг бүр зохиомол хэргийн газар үүсгэнэ. Хэргийн газарт гарын мөр, хөлийн мөр, архины шил, хутга, тамхины иш зэрэг мөрүүдийг бэлтгэнэ.

Багуудад хэргийн газарт мөртэй ажиллахад шаардагдах техник хэрэгсэл, гарын мөр илрүүлэх нунтаг, өсгөгч шил зэргийг хуваарилан өгнө.

Багш эхлээд мөртэй ажиллаж харуулна. Үүний дараа багууд өөрсдийн үүсгэсэн зохиомол хэргийн газар ажиллаж, үүсгэсэн мөрөө илрүүлж, бэхжүүлж, битүүмжлэнэ.

Оюутнууд хэргийн газар мөртэй ажиллаж байх үед багш багууд дээр очин зөвлөгөө өгнө.

Мөртэй ажиллаж дууссаны дараа баг бүр илрүүлж, бэхжүүлж, битүүмжилсэн мөрөө багшид шалгуулан, мөртэй ажиллахад гарсан хүндрэл, бэрхшээлээ бусаддаа ярьж өгнө.

Эцэст нь багш тайлбар хийж, амьдрал дээр тохиолдсон алдаа, оноотой бодит жишээг ярина.

## ДӨРӨВ. КРИМИНАЛИСТИК ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

### 1. Үнэлгээний зорилго

Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэгдэнэ. Багш оюутнуудын сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхжүүлэх, сургалтын үр дүнд хүрэх явцад оюутны мэдлэг, чадвар чухам ямар түвшинд байгааг тэдэнд мэдэгдэх, оюутанд өөрийгөө үнэлэх боломж олгох, багш өөрийхөө мэргэжлийн болон заах арга зүйг үнэлэх зорилтыг мөн тавьж ажиллана.

### 2. Үнэлгээний журам

Оюутныг үнэлж, дүгнэхдээ доорх үсгэн дүнг хэрэглэнэ.

“А” үнэлгээ: Сурлагын дээд амжилтыг илтгэх дүн: Криминалистик хичээлийн ухагдахуун, агуулгыг бүрэн дүүрэн ойлгосон, хөтөлбөрт тусгагдсан мэдлэгийг онцсайн эзэмшсэн, бие дааж ном сурах бичиг, нэр томьёог оновчтой зөв хэрэглэх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай, хичээлд жигд идэвх, санаачлагатай оролцдог, явцын шалгалтад амжилттай дүн үзүүлсэн болон тодорхой сэдвээр илтгэл тавьсан байна.

“В” үнэлгээ: Амжилттай суралцсаныг илтгэх дүн: Хичээлийн ухагдахуун, агуулгыг сайн ойлгосон, тэдгээрийн мөн чанарыг зөв тайлбарлах, семинарын хичээлд байнга идэвхитэй оролцдог, явцын шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн байна.

“С” үнэлгээ: Хичээлийн агуулгыг дундаж төвшинд эзэмшсэн байгааг илтгэх дүн: Криминалистик хичээлийн ухагдахуун, агуулгын ихэнх хэсгийг хангалттай ойлгосон, семинарын хичээлд идэвхтэй оролцдог, явцын шалгалтад хангалттай дүн үзүүлсэн байна.

“D” үнэлгээ: Дундаж түвшинөөс доогуур амжилтыг илтгэх дүн: Криминалистик хичээлийн ухагдахуун, агуулгыг жигд ойлгоогүй, асуултанд бүрэн дүүрэн бус хариулсан, семинарын хичээлд жигд бус оролцдог, явцын шалгалтад хамрагдсан, хялбар асуулт, бодлогыг бодох чадвар эзэмшсэн боловч хариулт нь оновчтой бус байна.

“F” үнэлгээ: Мэдлэг, чадвар хангалтгүйг илтгэх дүн. Тухайн хичээлийн агуулгыг эзэмшиж чадаагүй, хялбархан асуултанд хариулах, бодлого бодох, тохиолдол шийдвэрлэх чадваргүйг илтгэнэ.

Үсгэн, процентон болон тоо (оноо)-н дүнгүүдийг дараах жишгээр нэгээс нөгөөд шилжүүлнэ.



Үсгэн дүн	Тоон дүн	Процентон дүн
A	4,0	90-100
B	3,0	80-89
C	2,0	70-79
D	1,0	60-69
F	0	0-59

**Жишиг үнэлгээ:** Ирц – 10  
 Семинар – 20  
 Бие даалт - 10  
 Явцын шалгалт - 20

Явцын оноо 60, шалгалтын оноо 40 байх, үүнээс босго оноо 24 байна.

### 3. Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг, шалгуур
Мэдлэг	<ul style="list-style-type: none"> <li>Асуудлын мөн чанарыг хэрхэн ойлгож, тусгаж байгаа байдал</li> <li>Асуудалд онолын үндэстэй хариулж чадаж байгаа эсэх</li> <li>Мэдлэгээ бусдад түгээх, дамжуулах, тайлбарлаж чадаж байгаа эсэх</li> <li>Тухайн судлагдхууны тодорхойлолт гаргах, харьцуулалт хийх, харилцан хамаарал, зүй тогтлыг тодорхойлох арга зүйг эзэмшсэн эсэх</li> <li>Хариулт болон үзэл бодлынхоо үндэслэл, нотолгоог гаргаж байгаа байдал</li> </ul>
Чадвар	<ul style="list-style-type: none"> <li>Тодорхой онолын мэдлэгийг ашиглан (үндэслэл, нотолгоо болох жишээ баримт татах, тайлбарлах,) тухай асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх</li> <li>Бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх</li> <li>Баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал</li> <li>Амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин, (соёлтой мэтгэлцэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хамгаалах, эсрэг тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх)</li> <li>Олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж байгаа байдал (шүүхийн шийтгэх тогтоолд үнэлэлт дүгнэлт өгөх)</li> <li>Дүрд тоглох чадвар, арга барилыг эзэмшсэн байх</li> </ul>
Хандлага	<ul style="list-style-type: none"> <li>Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх</li> <li>Багийн гишүүн байх, бусдыгаа төлөөлөх чадварын хөгжилт</li> <li>Ялгаатай үзэл хандлага, байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал</li> </ul>

